



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-16
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	17-98
1.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 02 дугаар дүгнэлт /Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсгийн холбогдох зохицуулалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх, үргэлжлэл/	18-20
2.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар нарын 9 гишүүн 2025.01.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/	20
3.Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.01.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/	21-23
4.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2024.12.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	23-51 54
5.Өмгөөллийн тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг 2025.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	51-53
6.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.03.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	54-91 94-98
7.Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	91-94
8.Баталсан Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулах	98

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
04 дүгээр сарын 04-ний өдөр /Баасан гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 71 гишүүн хүрэлцэн ирж, 56.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 00 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Х.Булгантуяа, Ж.Галбадрах, Н.Наранбаатар, О.Номинчимэг, С.Одонтуяа, Б.Пунсалмаа, О.Саранчулуун, С.Цэнгүүн, Ж.Энхбаяр;

Чөлөөтэй: Ж.Алдаржавхлан, Ч.Анар, Б.Баярбаатар, Л.Оюун-Эрдэнэ, С.Эрдэнэбат;

Эмнэлгийн чөлөөтэй: С.Амарсайхан, Ж.Баярмаа;

Тасалсан: Х.Баттулга;

Хоцорсон: Н.Алтанхуяг-05 минут, Т.Аубакир-48 минут, Х.Баасанжаргал-28 минут, М.Бадамсүрэн-19 минут, Б.Батбаатар-1 цаг 14 минут, Ж.Батсуурь-04 минут, Б.Батцэцэг-16 минут, Ж.Бат-Эрдэнэ-13 минут, Г.Ганбаатар-29 минут, Д.Ганбат-36 минут, П.Ганзориг-08 минут, Л.Гантөмөр-38 минут, М.Ганхүлэг-01 минут, Г.Дамдинням-25 минут, Т.Доржханд-08 минут, Б.Жавхлан-16 минут, Х.Жангабыл-01 минут, Б.Жаргалан-01 минут, Д.Жаргалсайхан-45 минут, Ж.Золжаргал-21 минут, Л.Мөнхбаатар-02 минут, Ц.Мөнхбат-22 минут, П.Мөнхтулга-01 минут, Ц.Мөнхтуяа-01 минут, З.Мэндсайхан-32 минут, Ц.Туваан-19 минут, Г.Тэмүүлэн-2 цаг 30 минут, Н.Учрал-28 минут, Г.Уянгахишиг-45 минут, Р.Эрдэнэбүрэн-1 цаг 08 минут.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 95 дугаар зүйлийн 95.3-т заасны дагуу Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан иргэн Энхтөрийн Батбаяраас Улаанбаатар хотын тээврийн хэрэгслийн татварын нэмэгдлийг цуцлах асуудлаар ажлын хэсэг байгуулах тухай асуудлаар ирүүлсэн нийтийн өргөдлийг хэлэлцүүлж шийдвэрлүүлэхээр Төсвийн байнгын хороонд хуваарилсан талаар танилцуулав./10:02/

Нэг.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 02 дугаар дүгнэлт /Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсгийн холбогдох зохицуулалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх, үргэлжлэл/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх М.Отгон, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, Хуулийн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

Байнгын хорооноос гаргасан санал тус бүрээр санал хураалт явуулав.

Д.Амарбаясгалан: 1.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэгт "...Шүүгчээр 30, түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгоно." гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "...шударга ёс, ...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн." гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн Байнгын хорооны саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	58
Татгалзсан:	26
Бүгд:	84

69.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэгт "...Шүүгчээр 30, түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгоно." гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна." гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн Байнгын хорооны саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	64
Татгалзсан:	21
Бүгд:	85

75.3 хувийн саналаар дэмжигдлээ.

3. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэгт "...Шүүгчээр 30, түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгоно." гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Хүнийг ... нас ...-аар нь ялгаварлан гадуурхаж үл болно. ..." гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн Байнгын хорооны саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	60
Татгалзсан:	26
Бүгд:	86

69.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл, П.Батчимэг, Ж.Баясгалан, Н.Батсүмбэрэл, Х.Ганхуяг, Ж.Батжаргал, Д.Энхтүвшин, Б.Хэрлэн, С.Замира нарын "дэмжсэн" санал техникийн саатлын улмаас "эсрэг" гарсан тул санал хураалтын

дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 86 гишүүнээс 69 гишүүн дэмжиж, 80.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэгт “...Шүүгчээр 30, түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгоно.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс ... нийгэм, хууль зүйн ... баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн Байнгын хорооны саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	71
Татгалзсан:	15
Бүгд:	86

82.6 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэгт “...Шүүгчээр 30, түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгоно.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Үндсэн хууль, шүүхийн тухай хуульд заасан үндэслэл, шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн дагуу огцруулах, эсхүл хүсэлтээр нь чөлөөлөхөөс бусад тохиолдолд аль ч шатны шүүхийн шүүгчийг огцруулахыг хориглоно.” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн Байнгын хорооны саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	66
Татгалзсан:	20
Бүгд:	86

76.7 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэгт “...Шүүгчээр 30, түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгоно.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд хууль ... бүрнээ нийцсэн байвал зохино.” гэснийг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн Байнгын хорооны саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	71
Татгалзсан:	17
Бүгд:	88

80.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.2.3-т заасны дагуу хуралдаан оролцсон гишүүдийн олонх Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэж үзсэн тул энэ тухай Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцов.

Уг асуудлыг 10 цаг 09 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар нарын 9 гишүүн 2025.01.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, Хуулийн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх асуудал санал хураалтаар үргэлжлүүлэн хэлэлцэв.

Д.Амарбаясгалан: 1.Байнгын хорооны саналаар Захиргааны ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 26
Бүгд: 88
70.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Байнгын хорооны саналаар Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 26
Бүгд: 88
70.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Байнгын хорооны саналаар “Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64
Татгалзсан: 24
Бүгд: 88
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 11 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.01.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Д.Нямбаяр, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, Хуулийн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудал санал хураалтаар үргэлжлүүлэн хэлэлцэв.

Д.Амарбаясгалан: 1.Байнгын хорооны саналаар Хууль зүйн туслалцааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 74
Татгалзсан: 14
Бүгд: 88
84.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Байнгын хорооны саналаар Өмгөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 72
Татгалзсан: 16
Бүгд: 88
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Байнгын хорооны саналаар Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 26
Бүгд: 88
70.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Байнгын хорооны саналаар Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69
Татгалзсан: 20
Бүгд: 89

77.5 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Байнгын хорооны саналаар Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71

Татгалзсан: 18

Бүгд: 89

79.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл, Ц.Мөнхтуяа, М.Мандхай, Д.Үүрийнтуяа, Н.Батсүмбэрэл нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 89 гишүүнээс 76 гишүүн дэмжиж, 85.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Байнгын хорооны саналаар Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүйг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 42

Татгалзсан: 47

Бүгд: 89

47.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

7.Байнгын хорооны саналаар Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62

Татгалзсан: 27

Бүгд: 89

69.7 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Байнгын хорооны саналаар Төрийн болон албаны нууцын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71

Татгалзсан: 20

Бүгд: 91

78.0 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Байнгын хорооны саналаар Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүйг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 30
Бүгд: 91
67.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах тухай тогтоол баталсанд тооцов.

10.Байнгын хорооны саналаар Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70
Татгалзсан: 21
Бүгд: 91
76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Байнгын хорооны саналаар Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 20
Бүгд: 91
78.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 19 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2024.12.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Н.Жамъянхүү, Нийтийн эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ц.Лхагвацэнд, Улсын Ерөнхий прокурорын орлогч, төрийн хууль цаазын шадар зөвлөх М.Чинбат, Улсын Ерөнхий прокурорын туслах прокурор, Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга О.Мөнхбаатар, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга Б.Батзориг, мөн газрын Мөрдөн байцаах албаны дэд дарга Б.Батдэлгэр, Шүүхийн

шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Тэргүүн дэд дарга бөгөөд Хорих ял эдлүүлэх албаны дарга А.Намсаманд, Тагнуулын ерөнхий газрын Мөрдөн шалгах газрын дарга Д.Энхтөр, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Б.Энхболд, Монголын криминологичдын холбооны удирдах зөвлөлийн дарга Б.Батзориг, Монголын өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгч Л.Данзанноров нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Бат.Баярмаа, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, Хуулийн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, Л.Мөнхбаясгалан, Х.Тэмүүжин, Г.Очирбат, Ц.Сандаг-Очир, Н.Номтойбаяр, Л.Мөнхбаатар, Ж.Золжаргал, Х.Баасанжаргал нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Улсын Ерөнхий прокурорын орлогч, төрийн хууль цаазын шадар зөвлөх М.Чинбат, Монголын өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгч Л.Данзанноров, Улсын Ерөнхий прокурорын туслах прокурор, Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга О.Мөнхбаатар нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, С.Эрдэнэболд, Б.Мөнхсоёл, Ж.Чинбүрэн, Б.Жаргалан нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./11:49/

Тав.Өмгөөллийн тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг 2025.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ж.Түвшинжаргал нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны саналаар Өмгөөллийн тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 45
Бүгд: 108
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 108 гишүүнээс 64 гишүүн дэмжиж, 59.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Өмгөөллийн тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 12 цаг 01 минутад хэлэлцэж дуусав.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.12.27-ны өдөр өргөн мэдүүлсэн/ хэлэлцэх эсэх асуудал санал хураалтаар үргэлжлүүлэн хэлэлцэв.

Д.Амарбаясгалан: 1.Байнгын хорооны саналаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 48
Бүгд: 108
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Байнгын хорооны саналаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 48
Бүгд: 108
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл

баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 12 цаг 03 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.03.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жахлан, Улсын Их Хурлын гишүүн, *Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү*, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Б.Батцэцэг, мөн газрын Хууль, эрх зүйн газрын ахлах референт Х.Сүрэнхорол, Салбарын бодлого, зохицуулалтын газрын референт Б.Золбоо, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Н.Жамъянхүү, мөн газрын Нийтийн эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ц.Лхагвацэнд, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга Б.Батзориг, мөн газрын Кибер гэмт хэрэгтэй тэмцэх газрын дарга С.Тайван, Харилцаа холбооны зохицуулах хорооны Зохицуулалтын газрын дарга Т.Батболд, Монополын эсрэг газрын Хэрэглэгчийн эрхийг хамгаалах, зар сурталчилгааны газрын дарга Ц.Тэрбиш нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн дарга Б.Нарангэрэл, мөн хэлтсийн зөвлөх Г.Алтанцэцэг, Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнийн тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван нар хариулж, тайлбар хийв.

Үдээс өмнөх хуралдаан 2 цаг 30 минут үргэлжилж, 12 цаг 30 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 15 цаг 00 минутад эхлэв.

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж 15 цаг 00 минутаас 16 цаг 27 минутад хуралдааныг даргалав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдийн асуулт, хариултаар үргэлжлүүлэн хэлэлцэв.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал, С.Бямбацогт, П.Сайнзориг, Л.Соронзонболд, Б.Заяабал, Х.Ганхуяг, Э.Болормаа, Ц.Сандаг-Очир, Н.Алтаншагай, Ц.Мөнхбат нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, *Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү*, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, Харилцаа холбооны зохицуулах хорооны Зохицуулалтын газрын дарга Т.Батболд нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан 16 цаг 27 минутаас хуралдааныг даргалав.

Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал, Л.Соронзонболд, Х.Ганхуяг, Б.Жаргалан, Б.Пүрэвдорж, С.Зулпхар нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./16:34/

Долоо.Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн дарга Б.Нарангэрэл, мөн хэлтсийн зөвлөх Л.Батмөнх, Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц нар танилцуулав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан уг асуудлыг дараагийн хуралдаанаар хэлэлцэхээр хойшлуулав. /16:34/

Уг асуудлыг 16 цаг 43 минутад хэлэлцэж дуусав.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.03.26-ны өдөр өргөн мэдүүлсэн/ хэлэлцэх эсэх асуудал санал хураалтаар үргэлжлүүлэн хэлэлцэв.

Д.Амарбаясгалан: 1.Байнгын хорооны саналаар Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 57
Бүгд: 109
47.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51
Татгалзсан: 58
Бүгд: 109
46.8 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан горимын саналаар санал хураахад Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн заалттай холбогдуулж тайлбар хийв.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58
Татгалзсан: 51
Бүгд: 109
53.2 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 48
Бүгд: 109
56.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

1.Байнгын хорооны саналаар Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 47
Бүгд: 109
56.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, П.Мөнхтулга нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 109 гишүүнээс 64 гишүүн дэмжиж, 58.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Байнгын хорооны саналаар Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 48
Бүгд: 109
56.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Байнгын хорооны саналаар Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 46
Бүгд: 109
57.8 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Байнгын хорооны саналаар Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 48
Бүгд: 109
56.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 109 гишүүнээс 62 гишүүн дэмжиж, 56.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Байнгын хорооны саналаар Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 48
Татгалзсан: 61
Бүгд: 109

44.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүй тул хууль санаачлагчид нь буцаах тухай тогтоол баталсанд тооцов.

6.Байнгын хорооны саналаар Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59

Татгалзсан: 50

Бүгд: 109

54.1 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Байнгын хорооны саналаар Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62

Татгалзсан: 47

Бүгд: 109

56.9 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Байнгын хорооны саналаар Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65

Татгалзсан: 44

Бүгд: 109

59.6 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Байнгын хорооны саналаар Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63

Татгалзсан: 46

Бүгд: 109

57.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн, Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодод шилжүүлэв.

Уг асуудлыг 16 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.

Найм.Баталсан Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулах

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн дарга Б.Нарангэрэл нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 02 дугаар дүгнэлтийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./16:59/

Уг асуудлыг 17 цаг 00 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 8 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцөөж, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 4 цаг 30 минут үргэлжилж, 126 гишүүнээс 109 гишүүн хүрэлцэн ирж, 86.5 хувийн ирцтэйгээр 17 цаг 00 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

*2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр, Баасан гараг
Төрийн ордон “Их хуралдай”
танхим
10 цаг 00 минут*

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. 71 гишүүн бүртгэгдэж, ирц 56.3 хувьд хүрсэн байна.

2025 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. Чуулганы нэгдсэн хуралдаанаар өнөөдөр 9 асуудал хэлэлцэнэ.

Нэгдүгээрт, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 02 дугаар дүгнэлтийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Хоёрдугаарт, Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

Гуравдугаарт, Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

Дөрөвдүгээрт, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Тавдугаарт, Өмгөөллийн тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Зургаадугаарт, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Долоодугаарт, Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Наймдугаарт, Транс Азийн төмөр замын сүлжээний тухай, Засгийн газар хоорондын хэлэлцээрийн нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэнэ.

Есдүгээрт, Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсоно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 95 дугаар зүйлийн 95.3-д нийтийн өргөдлийг дэмжсэн иргэдийн санал энэ хуулийн

95.2-т заасан тоонд хүрмэгц Улсын Их Хурлын дарга саналыг хэлэлцүүлж шийдвэрлүүлэхээр холбогдох Байнгын хороонд ажлын 5 өдрийн дотор хуваарилж нэгдсэн хуралдаанд танилцуулна гэж заасан.

Нийтийн өргөдлийг холбогдох Байнгын хороонд хуваарилсан талаар танилцуулъя.

Монгол Улсын иргэн Энхтөрийн Батбаяр нийтийн ашиг сонирхлыг хөндсөн Улаанбаатар хотын тээврийн хэрэгслийн татварын нэмэгдлийг цуцлах асуудлаар ажлын хэсэг байгуулах тухай нийтийн өргөдөл ирүүлснийг Улсын Их Хурлын нийтийн өргөдөл, гомдлын системд 2025 оны 3 дугаар сарын 17-ны өдөр байршуулсан.

Уг өргөдөл 2025 оны 4 дүгээр сарын 4-ний өдөр Монгол Улсын 18 насанд хүрсэн 33042 иргэн санал авсан тул нийтийн өргөдөлд дурдсан асуудлыг хэлэлцүүлж шийдвэрлүүлэхээр Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний дагуу Төсвийн байнгын хороонд хуваарилж байна.

Төсвийн байнгын хороо иргэний гаргасан өргөдөлд дурдсан асуудлыг хуульд заасны дагуу шийдвэрлэх нь зүйтэй.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 02 дугаар дүгнэлтийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан байгаа.

Одоо Хууль зүйн байнгын хорооны саналаар санал хураалт явуулна. Санал хураалт.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэгт “...Шүүгчээр 30, түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгоно.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “...шударга ёс, ...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн Байнгын хорооны саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

58 гишүүн буюу 69 хувиар санал дэмжигдлээ.

2.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэгт “...Шүүгчээр 30, түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтооно.” гэж заасан нь “Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна гэснийг зөрчсөн байна.” гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн Байнгын хорооны саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

64 гишүүн буюу 75.3 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэгт “...Шүүгчээр 30, түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгоно.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг ... нас ...-аар нь ялгаварлан гадуурхаж үл болно. ...” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн Байнгын хорооны саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

60 гишүүн буюу 69.8 хувиар санал дэмжигдлээ.

Хууль зүйн сайд Алтангэрэл, Пүрэвийн Батчимэг гишүүн, Баясгалан гишүүн, Батсүмбэрэл, Ганхуяг, Батжаргал, Энхтүвшин, Хэрлэн гэсэн гишүүд, Замира гишүүн дэмжсэнд тооцлоо. Дэмжсэнээр протоколд тэмдэглэлээ.

4.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэгт “...Шүүгчээр 30, түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгоно.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс ... нийгэм, хууль зүйн ... баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн Байнгын хорооны саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

71 гишүүн буюу 82.6 хувиар санал дэмжигдлээ.

5.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэгт “...Шүүгчээр 30, түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгоно.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Үндсэн хууль, шүүхийн тухай хуульд заасан үндэслэл, шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн дагуу огцруулах, эсхүл хүсэлтээр нь чөлөөлөхөөс бусад тохиолдолд аль ч шатын шүүхийн шүүгчийг огцруулахыг хориглоно.” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн Байнгын хорооны саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

66 гишүүн буюу 76.7 хувиар санал дэмжигдлээ.

6.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэгт “...Шүүгчээр 30, түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгоно.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт Үндсэн хуульд хууль ... бүрнээ нийцсэн байвал зохино.” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн Байнгын хорооны саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

71 гишүүн буюу 80.7 хувиар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны саналаар санал хурааж дууслаа.

Байнгын хорооны саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 02 дугаар дүгнэлтийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталсанд тооцлоо.

Улсын Их Хурлын гишүүдэд талархал дэвшүүлье. Дараагийн асуудалд оръё.

10.09 цаг

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

Одоо Байнгын хорооны саналаар Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалтыг үргэлжлүүлэн явуулна. Санал хураалт.

Байнгын хорооны саналаар Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн

1.Захиргааны ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

62 гишүүн буюу 70.5 хувиар санал дэмжигдлээ.

2.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

62 гишүүн буюу 70.5 хувиар санал дэмжигдлээ.

3.“Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

64 гишүүн буюу 72.7 хувиар санал дэмжигдлээ.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг гишүүдийн олонх дэмжсэн тул төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүллээ. Дараагийн асуудалд оръё.

10.11 цаг

Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан.

Одоо Байнгын хорооны саналаар Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна. Санал хураалт.

1.Байнгын хорооны саналаар Хууль зүйн туслалцааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

74 гишүүн буюу 84.1 хувиар санал дэмжигдлээ.

2.Өмгөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

72 гишүүн буюу 81.8 хувиар санал дэмжигдлээ.

3.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

62 гишүүн буюу 70.5 хувиар санал дэмжигдлээ.

4.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

69 гишүүн буюу 77.5 хувиар санал дэмжигдлээ.

5.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

71 гишүүн.

Хууль зүйн сайд төсөл өргөн барьсан Алтангэрэл гишүүн дэмжсэнээр протокол тэмдэглүүлье. Мөнхтуяа гишүүнийг дэмжсэнээр протокол тэмдэглэе. Мандхай, Үүрийнтуяа, Батсүмбэрэл зэрэг гишүүдийг дэмжсэнээр протокол тэмдэглэе.

6.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүйг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

42 гишүүн буюу 47.2 хувиар санал дэмжигдсэнгүй.

Үндсэндээ төсөл өргөн барьсан нь, Байнгын хороон дээр унасан нь чуулган дээр босож ирж байна гэсэн үг. Тийм.

7.Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

62 гишүүн буюу 69.7 хувиар санал дэмжигдлээ.

8.Төрийн болон албаны нууцын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт.

71 гишүүн буюу 78 хувиар санал дэмжигдлээ.

9.Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүйг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

61 гишүүн буюу 67 хувиар санал дэмжигдлээ.

Тэгэхээр Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, дэгийн тухай 36 дугаар зүйл нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулах 36.14 санал хураалтад оролцсон гишүүдийн олонх хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүй бол хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах тухай тогтоол баталсанд тооцно.

10.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

70 гишүүн буюу 76.4 9 хувиар санал дэмжигдлээ.

11.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

71 гишүүн буюу 78 хувиар санал дэмжигдлээ.

Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг гишүүдийн

олонх дэмжсэн тул төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүллээ. Дараагийн асуудалд оръё.

10.19 цаг

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Хууль санаачлагчийн илтгэлийг Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Оюунсайханы Алтангэрэл танилцуулна. Индэрт урьж байна.

О.Алтангэрэл: Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас боловсруулж Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх эсэхийг шийдвэрлүүлэхээр та бүхэндээ танилцуулж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилт, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 18 дугаар тогтоол, Улсын Их Хурлын 2024 оны 5 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын факт болон Монгол Улсад Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх Хүний эрхийн Үндэсний Комиссын 22 дахь илтгэлд тусгасан дүгнэлт, зөвлөмжид нийцүүлж, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг тодорхойлж, түүнд нийцүүлж хуулийн төсөл боловсрууллаа.

Хуулийн төсөлд дараах зохицуулалтыг тусгалаа.

Хүнийг гэмт хэрэгт сэжиглэх үндэслэл байгаа бол түүнийг гэрчээр дуудах, эсхүл түүнээс гэрчийн мэдүүлэг авахгүй байх. Гэрчийн мэдүүлэг авах үед түүнийг гэмт хэрэгт сэжиглэх үндэслэл илэрсэн бол гэрчийн мэдүүлэг авахыг нэн даруй зогсох.

Хүний халдашгүй байх, өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах хүрээнд мөрдөн байцаалтыг өмгөөлөгчийг байлцуулахгүйгээр явуулахгүй байх. Хэрвээ өмгөөлөгчийг байлцуулахгүйгээр мөрдөн байцаалт явуулж, нотлох баримт цуглуулсан, хэрэг хүлээлгэсэн тохиолдолд тухайн мэдүүлэг нотлох баримтыг үнэлэхгүй байх.

Шүүх хуралдааныг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр удаа дараа хойшлуулдаггүй байх зэрэг эрх зүйн орчныг тодорхой болгох.

Олон оролцогчтой хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг тогтоох.

Хавтаст хэргийг цахимжуулах журмыг боловсронгуй болгох.

Төрийн нууцад хамаарах мэдээ агуулсан шүүх, прокурорын шийдвэрийг оролцогчид танилцуулах, гардуулан өгөх журмыг нарийвчлан тогтоох.

Шинээр нэгтгэсэн хэрэгт цагдан хоригдсон хугацааг тусад нь тоолох.

Хорих ял эдэлж байгаа ялтанд цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ авсан үед хорих ялын хугацаа дуусахаар хуульд заасны дагуу цаашид цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ авах эсэхийг шүүх шийдвэрлэх.

Хуульд заасны дагуу бэхжүүлсэн дууны, дүрсний, дуу, дүрсний бичлэгийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах, хадгалах хугацааг нарийвчлан тодорхойлох.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Өмгөөллийн хуульд заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох өмгөөлөгчийн эрх, үүргийг уялдуулах. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч, сэжигтнийг баривчлах, таслан сэргийлэх арга хэмжээ авах болсон үндэслэлд хамаарах нотлох баримттай танилцах, таслан сэргийлэх арга хэмжээ авах шүүхийн хэлэлцүүлгийг талуудын мэтгэлцээний үндсэн дээр явуулах.

Яллах, өмгөөлөх талын эрх тэгш мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлэх, хэргийн оролцогчийн эрхийг хангаснаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дараагийн шатанд хэрэгжүүлдэг байх.

Мөрдөгч, прокурор Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан яллагдагч, шүүгдэгчийг цагаатгах, хэргийг хөнгөрүүлэх нөхцөл байдлыг нотлох чиг үүргээ хэрэгжүүлээгүй бол яллагдагч, шүүгдэгч энэ талаар нотлох баримтыг шүүхэд гаргах.

Хүн ямар хэрэгт яллагдаж байгаагаа мэдэх эрхийг хангах хүрээнд эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан талаарх тогтоолыг гардуулан өгөх.

Шүүгч, прокурор, мөрдөгч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.10 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан хүсэлтийг хангахаас татгалзаж байгаа үндэслэлийг тухайн шийдвэртээ тодорхой тусгах зэрэг болно.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан болно.

Хуулийн төсөл батлагдсанаар хуулийг хэрэгжүүлэхэд тулгарч байсан хүндэл, хүндрэл бэрхшээл арилж, Монгол Улсын Үндсэн хуульд заасан халдашгүй, чөлөөтэй байх болон өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах үндсэн эрх улам бүүр баталгаажиж, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцод нийцнэ.

Хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэхийг шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Төслүүдийн талаар Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Батжаргалын Заяабал танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Заяабал: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Хууль зүйн байнгын хорооны 2025 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр баталсан “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 18 дугаар тогтоолын 1 дэх хэсэгт хүний эрхийг хангахтай холбоотой 14 асуудлыг судалж, холбогдох хуулийн төслийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцүүлэн боловсруулж, 2024 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасан бөгөөд хууль санаачлагч уг хууль, тогтоолын хүрээнд хуулийн төслийг боловсруулж, хүний халдашгүй байх, өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхийг хангуулах, хавтаст хэргийг цахимжуулах, төрийн нууцад хамаарах мэдээлэл агуулсан шүүх, прокурорын шийдвэрийг нарийвчлан зохицуулах, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд яллах, өмгөөлөх талын эрх тэгш мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлэх, хүн ямар хэрэгт яллагдаж байгаагаа мэдэх эрхийг хангах хүрээнд эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан талаарх тогтоолыг гардуулан өгөх. Шүүх, прокурор, мөрдөгч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан хүсэлтийг хангахаас татгалзаж байгаа үндэслэлийг тухайн шийдвэртээ тодорхой тусгах зэрэг зохицуулалттай холбоотой өөрчлөлтийг тусган хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний халдашгүй чөлөөтэй байх болон өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах үндсэн эрх улам баталгаажиж, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцод нийцэх бөгөөд мөрдөн шалгах ажиллагааны явцад хүний эрхийн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх эрх зүйн орчин боловсронгуй болсноор хүний эрх, эрх чөлөөг хангах, зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээн эдлүүлэх, ажлын үр дүн дээшлэх, мөн шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа цахим хэлбэрт шилжсэнээр зарим хэрэг маргааныг богино хугацаанд хянан шийдвэрлэх замаар хүний эрх, эрх чөлөөг хамгаалагдаж, шүүхийн үйлчилгээний чанар, хүртээмж дээшилж, иргэд цаг хугацаа, орон зайнаас үл хамааран үйлчилгээг шат дамжлагагүй шуурхай авах нөхцөл бүрдэнэ гэж хууль санаачлагч үзжээ.

Уг хуулийн төсөл батлагдсанаар эрүүгийн хэргийн шүүхийн хүний нөөцийн цалингийн зардалд 18269052 төгрөг, хүний нөөцийн хангамжийн материаллаг зардал болон технологийн зардалд 1 тэрбум 300 сая 539 мянга 543 төгрөг, нийт 1 тэрбум 318 сая 808 мянга 595 төгрөгийн зардал төрд үүсэхээр байна гэж төсөл санаачлагч үзсэн байна.

Хуулийн төслийг d.parliament.mn цахим хуудаст байршуулж иргэд олон нийтийн санал авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн асуулт асууж, санал хэлээгүй болно. Эрүүгийн хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 64.7 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Эрүүгийн хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Оюунсайханы Алтангэрэл Хууль зүй, дотоод хэргийн сайд, Чагдаагийн Хосбаяр Улсын дээд шүүхийн Эрүүгийн танхимын тэргүүн, Максимын Чинбат Улсын Ерөнхий прокурорын орлогч, төрийн хууль, цаазын шадар зөвлөх, Отгонбаярын Мөнхбаатар Улсын Ерөнхий прокурорын туслах прокурор, Хэрэг бүртгэх мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга, Батзэвэгийн Энхболд Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, Нэргүйн Мягмар Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Нармандахын Жамъянхүү Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга, Дашийн Энхтөр Тагнуулын ерөнхий газрын Мөрдөн шалгах газрын дарга, хурандаа, Халтарын Буянтүмэн Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар, Бямбажавын Нандинболор Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, хурандаа, Ичинноровын Баатархүү Гадаадын иргэн, харьяатын Захиргаа удирдлагын газрын дарга, Баатарсүрэнгийн Батзориг Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа, Энэбишийн Бадамсамбуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хүний нөөцийн хэлтсийн дарга, Батсүхийн Батдэлгэр Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах албаны дэд дарга, Цэрэнсүрэнгийн Лхагвацэнд Хууль зүй, дотоод хэргийн яамны нийтийн эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн, Батбаярын Цогтбаатар Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн захирал, Хүрэлбаатарын Эрдэм-Ундрах Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал, Бадамын Батзориг Монголын криминологичдын холбооны Удирдах зөвлөлийн дарга, Лхагвын Данзанноров Монголын өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгч, өмгөөлөгч.

Энэ ажлын хэсгийн бүрэлдэхүүнд нэр нь бичигдсэн зарим хүмүүс ирээгүй байна шүү. Тамгын газраас анхаараарай. Одоо Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна.

Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуулт асууя.

С.Эрдэнэболд: Хүний эрхийн багц хуулиуд орж ирж байгаа. Нэг.

Хоёрдугаарт нь болохоороо Хууль зүйн яамнаас бас санаачлаад Хүний эрхийн Үндэсний 2 дугаар хөтөлбөр бас батлагдана гэж тооцож байгаа. 2004 оноос хойш гэхээр бараг 20 жилийн дараа энэ асуудал яригдаж байгаа.

Гуравдугаарт нь бол бас ойрын үед буюу энэ жилийн хавар юм уу, намрын чуулганаар Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал шинэчлэн батлагдах хийгээд түүнд бас энэ хүний эрхтэй холбоотой асуудлууд орох юм байна гэж ойлгож байгаа.

Дөрөвдүгээрт нь болохлоороо ер нь энэ Улаанбаатарын 2040 дунд хугацааны бодлогын бичиг баримт болон бусад зүйлүүд дээр ингээд хүний эрхийн асуудлууд бас нэлээн тавигдаж байгаа. Сая утааны асуудал ч гэсэн энэтэй холбоотой болсон.

Улсын Их Хурал бас хүн төвтэй байх стратеги, 5 тулгуурт стратеги батлаад явж байгаа. Энэ стратегийн хүрээнд Улсын Их Хурлаас гарч байгаа бүх шийдвэрүүд, хууль тогтоомж дээр энэ хүний эрхийн мэдрэмжтэй байх шалгууруудыг гаргаж байгаа.

Тэгэхээр энэ өргөн барьж байгаа төсөл дээр ер нь хүний эрхийн нөхцөл байдлыг сайн сайжруулах, зөрчигдсөн эрхийг сэргээх, хүний эрхийн одоо үүсээд байгаа нөхцөл байдал дээр ямар ямар хамгаалалтууд нэмэгдэж байгаа энэ тал дээр тодорхой мэдээллүүдийг өгөөч гэж хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье Алтангэрэл сайд.

О.Алтангэрэл: Өнөөдрийн бид нарын хэлэлцэж байгаа төсөл бол 2024 онд Улсын Их Хурлаас тогтоол гаргаад эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүний эрхийг хангахтай холбоотой чиглэлээр ийм дараах өөрчлөлтүүдийг ер нь хий гэсэн энэ чиглэлийн дагуу ингээд хийгдэж байгаа өөрчлөлт байгаа юм.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа өөрөө онцлогтой. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат болгонд хүний эрхийн асуудал хөндөгдөж байдаг. Хүнийг саатуулдаг, баривчилдаг, цагдан хорьдог, шүүдэг. Тэгээд энэ үе шатуудад хүний эрхийг хангах гол баталгаа хүн хууль зүйн туслалцаа авах, өмгөөлөгчтэй байх, өмгөөлөгч өөрөө хуульд заасан эрхийнхээ дагуу үйл ажиллагаагаа явуулах бололцоотой байхыг ер нь ойлгодог.

Харамсалтай нь сүүлийн жилүүдэд бас энэ эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой хүндрэлүүд зөндөө гарч байсан. Хүнийг гэрчээр асууя гээд дуудчихдаг тэгээд гэрчээр асуух гэж байгаа юм байх гэж очингуут баахан юм асууж байснаа эргээд нөгөө мэдүүлгээр нь яллагдагч болгочихдог. Тэгээд чи ингэж мэдүүлсэн гээд ингээд хувиргачихдаг. Хүнийг яллагдагчаар татсан тогтоолоо үзүүлдэггүй, хувилаад авъя гэхээр өгдөггүй. Тэр байтугай өөрт холбогдох хэсгийг нь үз гээд мөрдөн байцаагч нь 2 талаас нь гараараа дарчхаад энэ хэсгийг л үзүүл үз, боливол боль гэж байсан гэх мэтчилэн.

Дээрээс нь өмгөөлөгчийн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох өмгөөлөгчийн эрхийн хувьд хязгаарлагдмал байсан, прокурор буюу улсын яллагч нь хамаагүй илүү эрхтэй байсан зэрэг маш олон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд олон жилийн турш хүний эрхийн чиглэлээр яригдаж байсан, шүүмжилж байсан зүйлүүдийг энэ төсөлд оруулсан байгаа юм.

Хэдийгээр 1 хуулийн төслөөр бүгдийг шийдвэрлэх бололцоогүй ч гэсэн өнгөрсөн жилүүдэд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль батлагдсанаас хойш гарсан энэ процессын үйл ажиллагаатай холбоотой хүний эрхийн зөрчлүүдийн дийлэнх хувийг боломжит хэмжээгээр шийдвэрлэхээр бид нар оруулж ирж байгаа. Энэ төсөл батлагдсанаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчийн хүний эрхийн нөхцөл байдал эрс дээшилнэ гэсэн ийм хүлээлттэй байгаа.

Д.Амарбаясгалан: Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн тодруулж асууя.

С.Эрдэнэболд: Баярлалаа. Одоо бид нар хэмжиж чадвал удирдаж чадна гэдэг шиг хэмжих нэгжээ л их тодорхой болгох хэрэгтэй байгаад байгаа юм. Сая Алтангэрэл сайдын хариултаас харахад бол мэдээж хүний эрхийн нөхцөл байдал эрс дээшилнэ гэдэг ийм зүйл хэлээд байгаа юм. Ер нь энэ хууль батлагдсанаар, тэгж хэлэх нь хаашаа юм 100 хувь гэхэд ер нь хэчнээн хэдэн хувьд нь бол энэ хамарч зохицуулалтыг хангаж чадах вэ? Дахиад цаашаагаа яг энэнтэй төсөөтэй ч гэдэг юм уу, яг энэ хүний эрхийн нөхцөл байдлыг сайжруулахын тулд бас хэчнээн хуулиуд шаардлагатай байгаа вэ гэсэн нэг ийм багцааг хэлж өгөөч гэж хүсье.

Д.Амарбаясгалан: Нэмж хариулъя Алтангэрэл сайд.

О.Алтангэрэл: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явц дахь энэ хүний эрхийн нөхцөл байдлыг яг гишүүний асууж байгаачлан тоогоор тэдэн хувь сайжирна, тэдэн хувь өөрчлөгдөнө гэж хэлэхэд хүндрэлтэй байна. Тэгэхдээ энэ Улсын Их Хурлын 18 дугаар тогтоолоор, бид нар үндэслэл болгосон 18 дугаар тогтоолоор 14 арга хэмжээ авч хэрэгжүүлье гэж үүрэг болгосон юм. Бас нэлээн судалж байж гарсан тогтоол, судалгаа хийж байж гарсан тогтоол. Энэ 14 арга хэмжээнээс бид нар энэ удаад 13-ыг нь хэрэгжүүлье гэж оруулж ирж байгаа.

Тэгэхээр энэ дундаас хавтаст хэргийг цахимжуулахтай холбоотой хэсэг нь бид энэ удаад оруулж ирсэнгүй. Ингээд бодохоор Улсын Их Хурлаас эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүний эрхийг 14 төрлөөр ханга гэснээс бид нар 13-ыг оруулж ирж байгаа учраас хэрвээ тогтоолынхоо хүрээнд орж ирж байгаагаар нь хувилж тооцох юм бол 90 гаруй хувьтай орж ирж байна гэж бид ойлгож байгаа.

Д.Амарбаясгалан: Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн асуулт асууя.

Л.Мөнхбаясгалан: Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт дээр 34 дүгээр зүйлийн 34.8.1 дэх хэсгийг хохирогч бичгээр хүсэлт гаргасан, эсхүл улсын яллагч, яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч хүсэлт гаргасан бол анхан шатны журмаар хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд хохирогчийг оролцуулан гэгчихсэн байгаа юм. Өмнөх одоо мөрдөгдөж байгаа хуулиар ингэж эзэн бие субъектив талыг дурдаж өгөөгүй

байсан. Жишээ нь, ялагч, яллагдагч, түүний төлөөлөгч, өмгөөлөгч хүсэлт гаргасан тохиолдолд оролцуулна гэхчхэн байгаа. Хохирогчийг оролцуулна.

Тэгэхээр энэ гарцаагүй оролцуулах ёстой юм шиг заалт болчихоод байна л даа. Энэ зарим хэрэг дээр хохирогч ерөөсөө яллагдагчийг харахыг ч хүсэхгүй, сэтгэл зүйн хүнд байдалд байгаа үед зүгээр хуулиар үзүүлж байгаа дарамт юм шиг ойлгогдохгүй юу? Оролцуулна гэхчхэн байгаа учраас зарим өмгөөлөгчдийн зүгээс энэ заавал оролцуулах ёстой гэж тайлбар хийх вий дээ. Магадгүй хохирогчийн эрх зүйн байдлыг дордуулсан ийм заалт болох вий тэрнээс зүгээр өмнөхөөр нь үлдээхэж болохгүй юу? Өмнөхөөр нь үлдээж болохгүй гэж байгаа бол хохирогчийг оролцуулна биш оролцуулж болно гэдэг засвар хийж болохгүй юу? Ийм асуулт байна.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье Алтангэрэл сайд.

О.Алтангэрэл: Хохирогч өөрөө шүүх хуралдаанд оролцох хүсэлтэй байвал үүнийгээ бичгээр гаргасан бол, хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчөөрөө хүсэлт гаргасан бол заавал оролцуулах утгыг энд байж байгаа. Би оролцоно, би хохирсон хүн ийм учраас би шүүх хуралдаанд оролцож өөрөө яаж хохирсон тухайгаа, гэмт хэрэгт өөрөө ямар эрх ашиг зөрчигдсөн тухайгаа би болон миний өмгөөлөгч нь миний үйлчлүүлэгч гэдэг юм уу, төлөөлөгч нь миний төлөөлж байгаа этгээд энд оролцох хүсэлтэй байна гэвэл энийг заавал оролцуулах тэр үүргийг нь л журамлаж байгаа юм.

Хүсэлт гаргахгүй тохиолдолд энэ шүүх хуралдаанд нь оролцуулахгүй гэсэн үг. Өөрөөр хэлэх юм бол сая Мөнхбаясгалан гишүүний хэлж байгаа санаа, зовнил харин яг бид хууль зүйн техникийн хувьд үүгээр хангагдаж байгаа гэж үзэж байгаа. Үнэхээр шүүх хуралдаанд өөрөө оролцохыг хүсэхгүй оролцмооргүй байгаа гэмт этгээдийг хармааргүй байна. Шүүгдэгчтэй би уулзмааргүй байна. Нэг танхимд байтугай нэг дор баймааргүй байна гэдэг ийм хүсэлт тавивал үгүй заавал оролцох ёстой гэж ингэж албадаж болохгүй. Харин өөрөө оролцоно гэсэн хүсэлт гаргасан бол үүнийг нь хязгаарлах ёсгүй л гэсэн агуулгаар орж байгаа. Тэгээд яг хэлж байгаа Мөнхбаясгалан гишүүний санаа, зовнилын агуулгыг бид үүгээрээ зохицуулж, хүний эрхийг хангаж байгаа л гэж ойлгож байгаа.

Д.Амарбаясгалан: Мөнхбаясгалан гишүүн тодруулж асууя.

Л.Мөнхбаясгалан: Алтангэрэл сайдын саяын агуулга 34.8.2 дээрээ байгаа юм. 2 дугаар заалт хамгаалсан заалт байгаа. Гэхдээ би зүгээр хохирогчийг оролцуулна гэдгийг жишээ нь хууль тайлбарлах эрх зөвхөн Дээд шүүхэд байгаа боловчиг амьдрал дээр бас ингээд хуулийг тайлбарлах гээд маргаад байдаг тохиолдол зөндөө байдаг шүү дээ. Тэгэхээр би зүгээр оролцуулж болно гэхчхэн юм уу?

Д.Амарбаясгалан: Хариулт өгье Алтангэрэл сайд.

О.Алтангэрэл: Хуулийн төслийг Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар хэлэлцэхийг дэмжээд явбал цаашдаа бас яг Мөнхбаясгалан гишүүнээс гарч байгаа шиг энэ асуудлуудыг бид нар угаас зүйл бүрээр нь хэлэлцээд явна. Тэгээд энэ дээр бас оруулаад ингээд хараад явж болох байх. Тэр үедээ ярилцъя.

Д.Амарбаясгалан: Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн асуулт асууя.

Х.Тэмүүжин: Одоо өргөн баригдаж байгаа процессын хуулийг бүүр бүрэн дэмжиж байгаа юм. Үнэхээр тулгарч байгаа асуудлуудыг шийдвэрлэхэд зориулагдсан байна. Гэхдээ би Хууль зүйн сайдаас 2 юм асуумаар санагдаад байгаа юм. Ийм хэмжээний процессын өөрчлөлт хийх бол Засгийн газрын түвшинд ажиллахад арай л жижигхэн санагдаж байна. Бараг Улсын Их Хурлын гишүүд өөрсдийн нөөцөөрөө ийм судалгаануудаа хийгээд ийм процессын өөрчлөлтийг хийчих байх. Би Засгийн газраас илүү том хүлээлттэй байгаа. Өчигдрийн чуулган дээр бас хэлсэн.

Ер нь ингээд тогтолцооны авлигажчихсан юм байгаа үед бид жижиг сажиг косметик засвараар амжилтад ерөөсөө хүрэхгүй. Бараг газар хөдлөлтийн шинжтэй том өөрчлөлтийг хийж байж дорвитой зөв алхмыг хийнэ. Процессын шинэтгэл дээр хэзээ ийм бодлогууд орж ирэх вэ гэдэг асуулт асуумаар байгаа юм. Үнэхээр одоо энэ процесс дээр шүүхийн хяналтыг бүрэн дүүрэн тавья гэвэл прокурор дээр байгаа зөвшөөрлийн тогтолцоонуудыг бүхэлд нь шүүх рүү шилжүүлэх хэрэгцээ байна. Тэгэхгүй бол яллаж байгаа буюу шүүхийн өмнө нэг тал болж байгаа этгээдээсээ зөвшөөрөл, хүсэлт яваад байдаг өмгөөлөгч гэдэг бол процессын хувьд маш сул дорой шүү дээ. Тийм учраас энэ прокурор дээр байгаа зөвшөөрлийг дэлхийн жишгээр, олон улсын жишгээр шүүх рүү шилжүүлэх алхмуудыг хэзээ хийх вэ? Нэг.

Хоёрт нь дахиад процесс дээр маш ноцтой гажуудал байна. Хэрвээ өмгөөлөгч, прокурор хоёр хоорондоо маргаад процессын алдаа байна, нотлох баримт хууль бусаар цуглагдаж байна, энэ асуудлыг дутуу шалгалаа гэх мэтчилэн маргаан явж байгаа бол энэ маргаан шүүх рүү очих ёстой. Шүүх рүү очихын тулд процессын хууль дээр шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг гэдэг энэ шинэ хэлэлцүүлгийн хэлбэрийг бий болгосон. Одоо энэ хэлэлцүүлгийг амилуулах хэрэгцээ байна.

Тэгэхгүй бол дахиад юу болж байна вэ гэхээр өмгөөлөгч, прокурор хоёрын маргаан дээд шатын прокурор явдаг болоод хувирчхаад л байна. Угаасаа л социализмын үед прокурорын ерөнхий хяналт гэж том хяналт байсан. Тэгээд шүүх рүү очих ёстой процессын маргаан нь дээд шатны прокурорууд яваад ирэхээр шүүхийн маргаан дотор хажууд нь зэрэгцээд захиргааны маргаан шиг шаталсан удирдлагатай босоо прокурорын систем дотор өмгөөлөгч нар хамаг хүч, нөөцөө, мэдлэг, тэр үйл ажиллагаагаа зардаг болоод явчихлаа. Энийг хэзээ бас таслан зогсоох вэ? Энийг таслан зогсоож байж л шүүх хуулийн өмнө эрх тэгш гэж Үндсэн хуулийн зарчим өөрөө ажиллаж эхэлнэ.

Гуравт нь дахиад одоо энэ процесс дээрх нэн чухал зүйл бол энэ нотолгоо, нотлох баримт болон нотолгооны онолтой холбоотой том өөрчлөлт хэзээ гарах вэ? Сая Noorog.mn дээр ч гэсэн гарч эхэлж байна. Юу вэ гэхээр манайх энэ Вишинскийн аргаас хэзээ салах юм? Хүн нь байвал хэрэг нь олдоно гэдэг шиг. Нэг жижиг сажиг сэжүүрээр эхэлж өлгөж аваад тэгээд ард нь тэлээний хэргээр ч хамаагүй шоронд явуулах гэж оролддог энэ процессын мөрдөн шалгах үйл ажиллагааны гажгийг хэзээ засах вэ?

Шүүхийн зөвшөөрөл гэж эхний зарчим. Нөгөө улс орнууд чинь шүүхийн зөвшөөрөл чинь хугацаатай, хүрээтэй, чиглэлтэй өгөгдөж байна. Манайх болохоор прокурорын зөвшөөрлөөр юу ч хамаагүй ороод юу ч хамаагүй нээгээд тэгээд яаж ийж байгаад ялладаг ийм тогтолцоо руу орчихлоо. Нөгөө газар чинь анх авсан шүүхийн шийдвэр, зөвшөөрлөөсөө өөр хэргээр оруулж ирэх юм бол наадхыг чинь шүүхэд авахгүй шүү гээд бүүр Дю процессын хувьд маш хатуу зарчмууд ажиллаж байгаа байхгүй юу. Манайд юу болсон гэхээр эв нэгдлийг бусниулах гэсэн гэнэ, мөрийтэй тоглосон гэнэ, өө ер нь юу юу юм мэдэхгүй ээ, прокуророос юм уу шүүхээс өгч байгаа зөвшөөрөл бүгдийг.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Алтангэрэл сайд хариулт өгье.

О.Алтангэрэл: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх процесс хуулийг бүхэлд нь зарчмын шинжтэй өөрчлөлт хийх ёстой гэдэг байр суурь дээр адилхан байр суурьтай байна. Тэгэхдээ өнөөдрийн хэлэлцэж байгаа зүйлүүд энэ косметик шинжтэй жижиг өөрчлөлт гэж бид үзэхгүй байгаа. Өнөөдөр амьдрал дээр өмгөөлөл хийгээд явж байгаа өмгөөлөгч нар, үйлчлүүлэгчийн өмгөөлөх гээд хүсэлтийг нь тавихаар ямар үндэслэлээр хариугаа хэлэхгүй зүгээр таны хүсэлтийг татгалзлаа гэдэг прокурорын хариу аваад явах, шүүх дээр хүнээ хориулахгүй гээд байхад шүүх нь яаж байгаа нь мэдэхгүй хорьчихоод тэр үндэслэлээ хэлдэггүй байх. Хүн ямар хэрэгт сэжиглэгдэж байгаа юм мэдэхгүй очоод юмаа үзье гэхээр тэр байцаагч нь хуруу гараараа дарж суучхаад үзүүлдэггүй байх зэрэг 10 гаруй маш хүндрэлтэй асуудлыг шийдэж байгаа. Өмгөөлөгчийн эрх хэмжээг нэмж байгаа, хүний эрх чөлөөг хангаж байгаа бас их чухал өөрчлөлтүүд орж байгаа гэж ач холбогдлын хуульд үзэж байгаа. Бид бол одоо 2 хуулийн төсөл дээр ерөнхийдөө ажиллаж байна.

Нэгдүгээрт нотолгооны хууль бичье гээд ажлын хэсэг нь байгуулагдсан. Одоо бид нар нотлох баримтыг яаж цуглуулах юм, бэхжүүлэх юм, яаж үнэлэх юм, ямар зүйлийг нотлох баримт гэж үнэлэх юм. Дээрээс нь хэрэгт цугларсан нотлох баримт дээр өмгөөлөгч ямар үүрэгтэй оролцох юм, бусад энэ мөрдөн шалгаж байгаа байгууллагууд ямар үүрэгтэй оролцох юм гэдэг энэ асуудлаа ярих болсон. Энэ ганцхан эрүүгийн процессын асуудал ерөөсөө биш. Иргэний процесс дээр ч гэсэн нотлох баримтыг яаж үнэлэх вэ гэдэг асуудал байгаа. Иргэний процесс дээр очоод ирэхээр яг үндсэндээ гэрчийн мэдүүлгийг үнэлдэггүй. Эрүүгийн процесс дээр ороод ирэхээр хэдэн нөхдүүд цуглуулж байгаад гэрчүүдийн мэдүүлгээр ингээд яллаад явчихдаг. Уг нь хоёулаа л яг адилхан мэдүүлгийн нотлох баримт, 1 процесс дээрээ үнэ цэнгүй, нөгөө газраа хэтэрхий үнэ цэнтэй байх жишээний.

Дээрээс нь бид нар энэ эрүүгийн хянан шийдвэрлэх ажиллагаанд тэр дэвшилтэт аргуудыг яаж ашиглах ёстой юм, нотолгооны тавигдах наад захын стандартыг яаж үзэх ёстой юм гэдэг дээр нотолгооны хуулийн ажлын хэсэг байгуулагдаад ажиллаад явж байна. Энэ шүүхийн хяналтын асуудал маш чухал асуудал. Бид ерөнхийдөө энэ Франц маягийн загварыг бариад энэ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад байгаа зарим төрлийн хүсэлтийг, арга хэмжээг шүүх шийдвэрлэдэг, шүүх явдаг энэний төлөө бид нар явна. Ингэж процессынхоо хуулийг бид нар өөрчилнө. Ингэж прокурорын зарим хяналтын чиг үүргүүдийг процессын хяналтыг шүүх рүү өгөхөөр ямар үр дүн гарна гэж бид нар үзэж байгаа вэ гэхлээр прокурорын төвлөрсөн тогтолцоонд өөрчлөлт гарах ёстой.

Өнөөдөр яг сая Тэмүүжин гишүүний хэлсэн үнэн. Энэ зүйл болохгүй байна. гээд прокурортоо их ханддаг. Прокурор хариу өгдөг. Тэрэнд нь жишээлбэл дүүрэг дээр байсан иргэд дүүргийн ерөнхий прокурорт өгнө. Дүүргийн ерөнхий прокурор нь адилхан хариу өгөнгүүт нь улс руу бичнэ. Ингээд ер нь нэг хэв загварын хариунууд л ер нь ирээд байдаг. Тэгээд бид нэгдүгээрт прокурор хүсэлтээ шийдвэрлэхдээ үндэслэлээ зааж өгөөч, үндэслэлээ зааж өг, яагаад хангахгүй гэж байгаа юм, яагаад энэ өмгөөлөгчийн хүсэлтийг хангахгүй гэж байгаа юм үндэслэлээ зааж өг гэдэг энэ асуудлыг шийдвэрлэж байгаа. Дараагийн ээлжид бид нар энэ үндэслэлийг хөндлөнгөөс прокурорын энэ шийдвэр зөв үү, буруу юу гэдэг асуудал дээр хяналт тавих шүүх, шууд дангаараа шүүхийн бас процесс ажиллагааг хянан шийдвэрлэх ажиллагааг хуульд тусгана гэсэн зорилттой байгаа.

Д.Амарбаясгалан: Тэмүүжин гишүүн тодруулж асууя.

Х.Тэмүүжин: Одоо өргөн барьчихсан байгаа хуулийн ач холбогдлыг ойлгож байна. Гэхдээ цаад тогтолцооны өөрчлөлт рүүгээ ерөөсөө алхахгүй байна гэж харж байна. Дахиад сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих тухай гэдэг бүүр гарчигтай хуулийг өөрчилмөөр байна. Бүүр хорьж байцаа гэдэг зорилготой ийм хуультай байгаад байна. Таслан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх тухай хууль гэж өргөтгөөд хорихоос хорьдоггүйгээр өөр байдлаар мөрдөж шалгадаг, гадуур хүнийг ингээд байлгаж байгаад эрхийг нь хязгаарлахгүйгээр үнэн бодитой тогтоох чадвартай тэр мөрдөн шалгах үйл ажиллагаа руу шилжихгүй бол хуулийнх нь гарчиг нь хүртэл зөвхөн хориод өг, алаад өг гэдэг шиг ийм хуультай улс ер нь алга шүү дээ тээ. Энийгээ хурдан оруулж ирмээр байна.

Хоёрт нь энэ нотлох баримтын чиглэлийн процессоо сайжруулж байгаатай холбоотой энэ шинжээчдийнхээ асуудлыг бас шийдэхгүй бол манай шүүхийн шинжээчийн зориулсан хууль чинь байгууллагын хууль болчихоод байна шүү. Тэрийгээ процессын хууль болгож.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Санал хэлчихлээ тээ? Ганбатын Очирбат гишүүн асуулт асууя.

Г.Очирбат: Өглөөний мэнд. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх энэ хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулахыг дэмжиж байгаа. Тэгэхдээ энэ дээр 1 ерөнхийдөө хэтэрхий хялбаршуулсан, тэгээд л энэ цахимжуулсан гээд ийм агуулга руу орчихоод байгаа юм Алтангэрэл сайд аа. Бид чинь нөгөө Үндсэн хуулиараа шударга шүүхээр шүүлгэх ёстой, давж заалдах эрхтэй гээд ингээд байдаг. Тэгэхээр хэтэрхий ийм хялбаршуулсан нөхцөл рүү ингэж оруулж ирдэг нь ажлын ачаалалтай холбоотой байдаг юм уу? Нэг бол энэ эрүүгийн хэрэг хэтэрхий өмнөх онуудынхаас нэмэгдсэнтэй холбоотой байдаг юм уу энэ дээр тайлбар, тодруулга авчихъя. Нэгт.

Хоёрт гэх юм бол энэ Байнгын хорооны дүгнэлттэй холбоотойгоор бас ингээд хялбаршуулах чиглэл рүү нь, цахимжуулах чиглэл рүү нь яваад байдаг. Ингээд тодорхой хэмжээний хөрөнгө мөнгө гарна гээд 1 тэрбум 318 сая 808 мянга 595 төгрөгийн зардал гарах нь гэж байгаа юм. Ингээд зардал гаргаад яваад байдаг нөгөө талдаа хэрэг хянан шийдвэрлэж байгаа нь бүтээмж нь хэр өсөж байдаг юм бол? Энэ тал дээр тайлбар, тодруулга авчихъя.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье, Алтангэрэл сайд.

О.Алтангэрэл: 2024 оны 6 дугаар сарын 5-ны өөрчлөлтөөр ер нь энэ цахим болгох энэ материаллаг хэмжээ өөрчлөлт нь орчихсон юм. Одоо амьдрал дээр энэ цахимжуулах асар их олон шаардлага байгаад юу вэ гэхлээр би Очирбат гишүүний болгоомжлолыг ойлгож байна. Энэ тэгэхдээ нөгөө үйл ажиллагааг хялбарчлаад байгаа зүйл биш. Иргэдэд үйлчлэх үйлчилгээгээ шуурхай болгоод байгаа. Өнөөдөр мөрдөгч хүн иргэдийн хамгийн ихээр очдог би гар утсаа алдлаа, манай гэрт хулгай орлоо, хүүхэд маань хүнд зодууллаа, намайг тийм хүн дээрэлхлээ гээд хамгийн их өргөдөл, гомдол авдаг тэр хэрэг бүртгэж байгаа цагдаагийн байгууллагын хувьд гэхэд бүх цаасаа хавтсаа бариад прокурор руу гүйгээд байх юм.

Тэгээд прокурор дээр очоод прокурор ч бас хуульд заасныхаа дагуу тэр чинь үзэж хянана шүү дээ, хянаад зөвшөөрөл өгнө, зөвшөөрөл өгнө ингээд сүүл рүүгээ байцаагч дээр 10, 20, 30, 40 гэж байгаа 100 хэрэг хуримтлагдаад ирэхээр 1 мөрдөгч дээр хэргийн чанар муудна, хүний хэргийн хойноос явах бололцоо муудна. Тэгээд прокурор дээр очоод гарын үсэг зуруулчихна прокурорынх нь өөрийнх нь ажлын ачаалал ихэснэ, цаас ихэснэ, зардал ихэснэ гээд ийм асуудлууд их байгаа учраас цахимжилттай холбоотой зүйлээ бид нар оруулах гээд оруулчихсан юм.

Тэгээд энэ цахимжилттай холбоотой зүйл хийснээр ерөөсөө энэ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа иргэдийн эрх чөлөөг хангахтай холбоотой ахиц өөрчлөлт орно. Цахимжуулалт бол одоо зөвхөн ер ерөөсөө яриад байгаа зүйл биш аль хэзээний хийгдээд, ашиглалтад орох гээд байгаа систем манай Улсын Ерөнхий прокурор дээр ашиглалтад орох гэж байгаа байх. Даргаа энэ цахимжилтын талаар прокуророос нэмж тайлбар өгч болох уу ажлын хэсгээс? Чинбат прокурор тайлбар өгчих.

Д.Амарбаясгалан: Чинбат прокурор ажлын хэсгийн дугаар хэд байна микрофон? 10. 10 дугаар микрофон.

М.Чинбат: Гишүүний асуултад нэмж хариулъя. Прокурорын байгууллага үйл ажиллагаагаа цахимжуулах энэ зорилтыг тавьж хэрэгжүүлж ажиллаж байгаа. Энэ хүрээндээ Хууль зүйн яамтай хамтарч зөрчлийн хэргийн нэгдсэн бүртгэл системийг бол боловсруулж үйл ажиллагаандаа туршилтын журмаар хэрэгжүүлж ажиллаж байгаа. Эрүүгийн хэргийг цахимжуулах энэ асуудал бол хууль тогтоомжийнхоо хүрээнд өнгөрсөн 24 оны 6 дугаар сард Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд бол хэрэг, хэргийн ажиллагааг цахимжуулах, шүүх хуралдааныг цахимаар явуулах, таслан сэргийлэх арга хэмжээ хэрэглэх эсэх асуудал, цахим оролцуулах энэ асуудлын үндэс суурийг нь хуульчлаад өгчихсөн байгаа. Цааш цаашдаа бид аль болох энэ их мөрдөгч, прокурор, шүүхийн үйл ажиллагааг цахимжуулахад онцгой анхаарч тодорхой тодорхой энэ алхмыг үе шаттай авч хэрэгжүүлэх энэ бэлтгэлийг хангуулж ажиллаж байгаа. Шууд эрүүгийн хэргийг.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Ганбат гишүүн, Очирбат гишүүн болчихсон уу? Энэ юун дээр бас анхаарвал цахимаар явагдаж байгаа шүүхийн энэ эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх процесстой холбоотой асуудал дээр бас иргэд 2 талтай л гомдол

гаргадаг юм байна лээ шүү дээ бас. Ил тод явж байгаа нь сайн гэж нэг талдаа хараад байдаг. Нөгөө талдаа цахимаар явж байгаа учраас бас шийдвэр гаргалтад янз янзын нөлөөллүүд бас ороод байдаг юм байна гэсэн гомдлууд бас гардаг юм байна лээ шүү.

Тэгэхээр энийг бас та бүхэн энэ үйл ажиллагаандаа, ялангуяа энэ эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх процессын хувьд бол их сайн анхаарч байх ёстой. Нэг ёсондоо туйлширч болохгүй л гэсэн үг шүү дээ. Яг аль хэмжээндээ цахим байх юм, аль хэмжээндээ бас шийдвэр гаргалтад хөндлөнгийн нөлөөллүүдийг өртүүлэхгүй байх дээр анхаарах юм бэ гэдэг асуудлуудыг ярихгүй бол бас ялангуяа шүүхийн процесстой холбоотой юман дээр бас тиймэрхүү гомдлууд бас ирсэн байна лээ Их Хурал дээр. Тэрийг бас та бүхэн анзаарч ажиллаарай.

Цэндийн Сандаг-Очир гишүүн асуулт асууя.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Би Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөс дараах зүйлийг тодруулъя. Шүүх хуралдаанууд хойшилдог өнөөдрийн мөрдөгдөж байгаа хуулиар. Тэгээд өмгөөлөгчийн гаргасан хүсэлтээр ингээд хэдэн ч удаа хойшлох бололцоо, боломжууд бий. Энэ нь өөрөө эргээд хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх ийм асуудал, дуусдаггүй эцэс төгсгөлгүй ингээд иргэнийг залхаадаг ийм байдал руу ордог. Энийг бас өөрчилж байгаа юм байна. Тэгээд өөрчиллөө гэхэд энэ чинь эргээд бас өмгөөлөгчгүйгээр шүүх хуралдааныг явуулах нөхцөл байдал руу орчих вий дээ. Эргээд нөгөө хүний эрх, эрхийг хангана гэж ингэж том малгай доороо яриад байгаа хуулийн том өөрчлөлтүүд явж байгаа.

Гэтэл эргээд иргэнийг эрүүгийн хэрэг дээр бас өмгөөлөгчгүйгээр хэргийг нь шийдээд явчих, хурдан шуурхай асуудлыг шийднэ гэдэг үндэслэлээр, үндэслэлгүйгээр хурлын хойшлуулахгүй байх энэ нөхцөл бололцоог бүрдүүлнэ гэдэг энэ үүднээсээ ингээд өмгөөлөгчгүйгээр хурлууд явчих нөхцөл бололцоо үүсчих вий дээ гэсэн болгоомжлол байна.

Ер нь хэрэг хяналтын болоод давахын, анхан шатан дээр ер нь доод тал нь, дээд тал нь ямар хэмжээнд хэргүүд хойшилж байна вэ? Ер нь манайханд хэргийг хойшлуулах, санаатай, санамсаргүйгээр хойшлуулах, хугацаа хожих, энэний цаана хөөн хэлэлцэх хугацааг дуусгах ийм санаа, сэдлүүд байдаг шүү дээ хуралдаан дээр.

Тийм учраас энэ дээр бас энэний тэр тэнцвэртэй байдлыг хангах, мэдээж тодорхой шалтаг, шалтгаангүйгээр, үндэслэлгүйгээр хэргийг хойшлуулахгүй байх, өмгөөлөгч нарын хариуцлагыг бас дээшлүүлэх, сайжруулах, нөгөө талаасаа иргэний эрх талаасаа бас өмгөөлөгчгүйгээр хуралдааныг явуулахгүй байх. Энэ хоёрын тэнцвэрийг ер нь хэрхэн яаж, хангаж барьж ажиллах юм? Энэ хэрэгцээ, шаардлага нь ямар байгаа юм? Энийг та хариулж өгөөч гэж.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье Алтангэрэл сайд.

О.Алтангэрэл: Энэ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль дээр заавал өмгөөлөгч оролцох ийм нөхцөлүүдийг заагаад өгчихсөн байгаа. Тэгээд энэ заавал өмгөөлөгч оролцох нөхцөл дээр хүсэлт гаргасан бол оролцуулна. Харин

практик дээр шүүх хуралдаан хойшилж байгаа, шүүн таслах ажиллагаанд бас нэлээн хүндрэл учруулж байгаа юм. Би танд сүүлийн 1 жилийн статистикаас тоо дурдъя. Нийт 33154 эрүүгийн хэргийн анхан шатын шүүх хуралдаан товлөгдсөн байгаа юм. 33154 удаа. Энэнээс хойшилсон тоо нь 16851 удаа хойшилж байгаа юм. 16851 удаа. Энэ хойшилсноос энэ 16 мянгын 7141 нь буюу 42.3 хувь нь өмгөөлөгчөөс гаргасан хүсэлтийн улмаас шүүх хурал хойшилж байгаа юм.

Иргэний хэрэг дээр нийт товлөгдсөн шүүх хуралдааны тоо 59177, 59177. Өнгөрсөн жил Монгол Улсын хэмжээгээр жилд. Үүнээс 26525 нь хойшилсон байгаа юм. 26525. Харин өмгөөлөгчөөс шалтгаалж хойшилсон нь энэ дээр 17.4 хувь гээд.

Ингээд Захиргааны хэргийн анхан шатны шүүх, Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх гээд шүүх болгон дээр ийм статистик байгаагаас хамгийн өндөр нь энэ эрүүгийн хэргийн давж заалдах шатын шүүх дээр хойшилсон, яг хойшилсон нийт хуралдааны 51.2 хувь нь өмгөөлөгчийн гаргасан хүсэлтийн дагуу хойшилж байгаа юм.

Тэгэхээр энэ заавал өмгөөлөгч оролцуулахаар эрүүгийн хэргийн процессын хуульд заасан нөхцөлд өмгөөлөгчийг оролцуулна. Тэгээд хүн бол өмгөөлөгчгүй шүүгдэх гэдэг юм уу, эрх нь зөрчигдөх хүсэлт гарахгүй. Бид энэ эрүүгийн болоод иргэний процесс шүүх хуралдаанаар асуудлыг энэ эрүүгийн процессоор нэн ялангуяа асуудлыг шийдэхэд их олон удаа хойшилдог, үүнийх нь улмаас бас хүндрэл учирдаг энэ байдлыг өөрчилъе. Хүндэтгэн үзэх шалтгаан гэж юуг хэлэх вэ, ямар тохиолдолд хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хойшилж болох вэ гэдэг журмыг нь бид нар тодорхой болгоё гэж. Тэгээд энэ маань цаашаагаас бас уялдахдаа өнөөдөр эрүүгийн процессын хууль дээр орж байгаа зүйл маань уялдаад, цаашаагаас хуульчийн ёс зүйн дүрэм, бусад зүйлүүд дээр бас зохицуулагдаад уялдаад явчих зүйл байгаа юм.

Д.Амарбаясгалан: Нямтайширын Номтойбаяр гишүүн алга байна. Лхагвын Мөнхбаатар гишүүн асуулт асууя.

Л.Мөнхбаатар: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт орохоор орж ирж байна. Энэ их чухал өөрчлөлтүүд байгаа юм. Өнгөрсөн хугацаанд НҮБ-ын дур зоргоор саатуулахтай холбоотой асуудал хариуцсан ажлын хэсэг ирж Монгол Улсад ажилласан бас томоохон тайлан гаргасан. Үүнийг нь Улсын Их Хурал хэлэлцээд Мөнх-Оргил гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг ажиллаад Улсын Их Хурлын тогтоол гарсан юм. Энэ тогтоолын дагуу тодорхой хуулийн өөрчлөлт хийхээр тусгасан. Үүний дагуу Засгийн газар, Хууль зүйн сайд ажлын хэсгийн хамт оруулж ирж байгаа юм байна. Энд олон чухал асуудлуудыг хөндөж тухайн үед яригдсан асуудлуудыг бүгдийг нь багтаасан өөрчлөлтүүд байна. Мэдээж шүүх хурал хойшилдог, гэрчээр дуудаад шууд яллагчаар татаад явчихдаг асуудлууд. Энэ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын асуудлууд байна.

Мөн хүний эрхийг хангах чиглэлээр гээд их олон ер нь процесс ажиллагаагаас ч гэсэн боловсронгуй болгох чиглэлээр их олон чухал өөрчлөлтүүд орж байгаа ийм зүйл байна. Гэхдээ энд бас цаашдаа та бүгд маань хэлэлцэх

явцдаа бас боловсронгуй болгох шаардлага та хэдэд асуудлууд бас байх шиг байна. Би 2, 3 зүйлийг тодруулж асууя гэж бодож байна.

Энэ 14 дүгээр зүйлийн энэ 8 дээр нь ийм зүйл байгаад байх юм. Хэрэг бүртгэлтийн хэргийг хаах саналтай прокурорт шилжүүлсэн хэргийн материалыг прокурор 14 хоногийн дотор хянах ба зайлшгүй тохиолдолд зохих дээд шатны прокурор энэ хугацаагаа тухай бүр 14 хоногоор сунгаж болно гээд биччихсэн байна тээ? Энэ хэдэн удаа 14 хоногоор сунгаж болох вэ? Ингээд дээд хязгаарыг нь ямар хязгаар байхгүй бол 14 хоногоор сунгасаар байгаад бараг бүтэн жил ч байж болно шүү дээ тийм? Тэгээд энэ ийм зүйл харагдаж байна.

Дараагийнх нь энэ 9 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг дээр чинь байгаа. Энэ шүүгдэгч шүүх хуралдааныг орхих юм, явж шүүх хуралдаанд оролцохоос санаатай зайлсхийсэн бол шүүх энэ эзгүйд шүүх хуралдааныг үргэлжлүүлэн явуулж шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай эсэхийг эцэслэн шийдвэрлэж болно гэсэн биччихсэн. Тэгээд шүүгдэгчийн эзгүйд шүүх хуралдааныг үргэлжлүүлэн явуулахад шүүгдэгчийн өмгөөлөгчийг оролцуулна, оролцуулна гээд биччихээд байгаа юм. Ингээд оролцуулна гэдэг чинь заавал гэсэн үг шүү дээ тийм ээ? Оролцуулна. Ингээд биччихээр нөгөө их хүндрэл их үүсэхгүй юу та бүгдийн хувьд? Ингээд шүүгдэгчийн эзгүйд шийдэж байна гэсэн үг. Гэхдээ өмгөөлөгч нь оролцохгүй явж байвал шүүх хурал хийгдэхгүй юу?

Ер нь өмгөөлөгч, шүүгдэгч хоёр чинь л нэг тал шүү дээ. Нэг субъект. Тэгэхээр өмгөөлөгч нь ирэхгүй бол энэ шүүх хурлууд хойшлоод байдаг энэ тал руугаа ер нь цаашдаа ингээд бас яваад байх юм биш үү? Энэ чинь яг тийм та бүгдийн сургуулилах гээд байгаа чиглэл рүү чинь явж чадаж байна уу, үгүй юу? Дараагийнх нь ийм зүйл харагдаад байх юм агуулгыг нь бас ойлгож л байна. Өмгөөлөгчийн эрхийн асуудал дээр энэ 1 дүгээр зүйлийн энэ 2.4 дэх заалт дээр байгаад байна. Энэ 2.4 гэхсэн. Хууль зүйн туслалцаа үзүүлэх шаардлагатай эд зүйл, баримт бичиг, мэдээлэл, бусад баримтыг ингээд шүүхэд гаргаж өгөх юм байна л даа. Нотлох баримт л гэсэн үг шүү дээ. Энийг шүүхэд гаргаж өгөх ийм эрхийг өгөх, өгч ярьж байна. Тэгэхээр энэ яах вэ цагдан хорих асуудал дээр, таслан сэргийлэх асуудал дээр байж болох байх. Ер нь ингээд шүүхэд ийм нотлох баримтыг өмгөөлөгч байнга гаргаж өгөөд байх юм бол энэ нөгөөдөх хязгааргүйгээр нөгөөдөх шүүх хурал маань хойшилдог.

Ерөөсөө шүүх хурал дээр л нотлох баримт гаргаж өгөөд л, мөрдөн шалгах ажиллагаа явуулах хүсэлт гаргачихдаг. Ингээд яваад байдаг нөгөө шүүх хурал чинь эцэс төгсгөлгүй бас олон жилээр үргэлжилдэг юм руугаа бас энэ чинь явчихгүй юм биш байгаа? Энэ тал дээрээ бас манай энэ шүүх, прокурор ямархуу байр суурьтай байгаа бол? Энийг ямар хүрээнд авч үзэх вэ л гэдгийг би ярьж байгаа юм. Түүнээс биш яах вэ цагдан хорих юм уу, таслан сэргийлэх арга хэмжээн дээр ийм нотлох баримт байгаа юм, ийм юм гэж бас ярьж болох байх. Ер нь томоохон эрүүгийн хэргүүд дээр яг ингээд яриад явах юм бол энэ чинь ерөөсөө өмгөөлөгч бол шүүх хурал боллоо шүүх хурал дээр нэгэнт нотлох баримт гаргаж тавьдаг ийм асуудал бол.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: 1 минут нэмж өгье.

Л.Мөнхбаатар: Магадгүй хувийн мөрдөх мөрддөг ч гэдэг юм уу ийм асуудал руугаа ч явж магадгүй. Ингээд нотлох баримттай холбоотой энэ асуудлууд маань энэ зүг чигт төвөг учруулах юм биш байгаа гэсэн ийм зүйл харагдаж байна лээ.

Нөгөөдөх нь энэ цахимтай холбоотой бас нэлээн олон өөрчлөлтүүдийг хийж байгаа юм байна. Энэ цахим төхөөрөмжөөс өөрчлөгдсөн, устгасан мэдээллийг сэргээсэн тохиолдолд нотлох баримтад тооцогдоно гэдэг ийм шууд ингээд биччихэж. Энэ бас нэлээн асуудалтай шүү. Сайн бодож үзээрэй та хэд бас.

Цахим баримтыг устгасан, сэргээсэн үед заавал тусгайлсан журам хэрэгтэй шүү. Тэгэхгүй бол сэргээхдээ яаж ч сэргээж болно шүү дээ. Тодорхой ач холбогдолтой зүйлийг хасаж болно, эдит/edit/ хийж болно, нэмж бол болохгүй байх. Мэдээж тодорхой хэсгийг нь хасах, нэмэх, засварлах янз янзын боломжтой шүү дээ. Тэгээд шууд сэргээх, түүнийг нь нотлох баримтад тооцох гэдэг бол их асуудалтай шүү. Гэхдээ энийг тусгайлсан журмаар зохицуулах гэдэг юм уу энэ мэтчилэн бас нэлээд олон зүйлүүд байна. Цаг багтахгүй учраас ажлын хэсэг та бүгдийн байгууллагуудын хувьд нь бас тодорхой зарим саналуудыг хэлье. Ийм хэдэн тодруулах зүйлүүд байна.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье, Алтангэрэл сайд.

О.Алтангэрэл: Энэ олон оролцогчтой шүүх хурал явагдахаар нэг асуудал гараад байдаг. Өнгөрсөн удаад бид нар харсан Хөгжлийн банкны шүүх хурал дээр гэхэд чинь бүтэн чуулгын заалыг суллаж байгаад хурал хийдэг. Тэгээд аль ямар тохиолдолд байлцаж болох вэ, байхгүй байж болох вэ гэдгийг нь бид нар зохицуулахгүй болохоор өөрт нь ямар ч хамаагүй жишээлбэл 80 холбогдогчтой хэрэг байлаа гэхэд өөрт нь ямар ч хамаагүй 79 хүний үйлдлийн тухай тэр хүн олон хоног тэгээд сонсоод сууж байгаа юм. Тэгээд ер нь бай гэсэн шаардлага тавьдаг, шүүх хуралдаанд оролц гэнэ, дуудна, ирэхгүй байна гэж баална. Ингээд өөртэйгөө ямар ч холбогдолгүй хурлын тухай 10 хоног, 14 хоног, 20 хоног сонсоод сууж байгаа юм.

Тэгэхээр тэр хүнийг энэ олон оролцогчтой шүүх хурлыг хийхэд ер нь олон оролцогчтой шүүх хурлыг яаж хийдэг юм бэ гэдэг дээр бид нар бас судалгаа хийсэн. Энэ парламентын судалгааны хүрээлэнгээр судалгаа хийлгэсэн юм. Тэгээд энэ шүүх хуралдаанд оролцоод явахдаа хэрвээ өөртэй нь холбогдолгүй зүйл байвал энд суухгүй байх эрхийг нь нээж өгье. Холбоотой зүйл ярьж байна гэж үзвэл суух эрхийг нь бас нээж өгье гэдэг хүрээнд л түрүүний тэр зохицуулалт орж байгаа юм.

Энэ шүүх хурал дээр нэмэлт нотлох баримт гаргаж өгөх асуудал бол олон жил яригдаж байгаа юм. Өмгөөлөгч нар их хүсдэг, хүнийхээ эрх зүйн байдлыг дээрдүүлье, хүний эрхийн зөрчлийг нь арилгая гэхээр нотлох баримт гаргаж өгөхөөр болохгүй байна гээд маш олон жил яригдаж өнөөдөр бас орж ирж байгаа зүйл байгаа юм. Би энэ дээр Данзанноров өмгөөлөгчийг түлхүү энэ өмгөөлөгчид шинээр нотлох баримт гаргаж өгөх ямар хэрэгцээ байдаг талаар хариулах байх гэж бодож байна. Ажлын хэсгээс. Тэр эхний тавьсан асуулттай холбоотой тэр 14 хоногоор сунгаад байна, хэдэн удаа сунгах юм бэ гэдэг дээр манай прокурорын байгууллага хариулах байх.

Энэ нотлох баримтыг сэргээх асуудлыг бид нар тусгаж оруулж ирж байгаа. Ерөөсөө гэмт хэргийн нөхцөл байдал их өөрчлөгдөж байна. Залилангийн хэргийн маань нөхцөл байдал ер нь 50 хувиас дээш цахим залилан болж хувирч байна. Дэлхийн улс орнуудад залилангийн шинжтэй гэмт хэрэг 80 хувь руу цахим болж очиж байгаа юм. Тэгэхээр бидэнд ямар хэрэгцээ шаардлага гарч байна вэ гэхлээр энэ цахим нотлох баримтыг цуглуулах, сэргээх, энийгээ үнэлэх асуудал гарч ирж байгаа. Ингээд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх зорилгоор ийм цахим орчинд үйлдэгддэг гэмт хэргийг шалгая гэхээр нэн даруй юмнуудаа устгачихдаг, нуучихдаг, тэдгээрийг нь сэргээж гаргаж ирдэг.

Тэгээд энэ дээр жишээлбэл, үзлэгийн процесс яаж явагдах юм? Үзэхэд байхгүй байсан юмыг сэргээгээд гараад ирсэн зүйлийг бид нар нотлох баримтаар тооцохоос арга байхгүй. Энийгээ яаж тооцох юм гээд. Харин Мөнхбаатар даргын хэлж байгаа энэ дээр харин тэр хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой алдаа дутагдал гарах вий, холбогдох журам бэхжүүлэх журмаа сайжруулах ёстой гэсэн энэ зүйлүүдийг хүлээн зөвшөөрч байна. Тэгээд энэ холбогдох асуулттай холбоотой дарга энэ ажлын хэсгээс бас нэмж хариулъя.

Д.Амарбаясгалан: Өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгч Данзанноров, ажлын хэсгийн 4 дүгээр микрофон.

Л.Данзанноров: Нэмэлт тодруулга хийе. Энэ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүхий л шатанд өмгөөлөгчийн зүгээс нотлох баримт гаргаж өгөх энэ боломжийг энэ удаагийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр оруулж байгаа нь нэлээд ач холбогдолтой. Энэ Их Хурлаас баталсан 18 дугаар тогтоолын агуулга нь өмгөөлөгч, прокурорын эрх тэгш мэтгэлцээний энэ нөхцөлийг бүрдүүлэх ийм гол зорилго байгаа. Энэ тогтоолын 8 дугаар заалтад яг энэ талаар тодорхой зохицуулсан байгаа. Хамгийн гол шүүхийн шатад нотлох баримт гаргаж өгөх энэ эрх боломжийг яагаад нээхээр болсон бэ, энэ нь ямар ач холбогдолтой вэ гэхлээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөх болон яллах талууд хүч тэнцвэргүй нөхцөл байдалтай оролцдог. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилт яг энэ тухайн хүнийг яллаадах гэдэг энэ агуулга биш, хэргийн бодит байдлыг тогтоох л ийм агуулгатай. Гэтэл.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя 1 минутад хариулдаг байгаа.

Л.Данзанноров: Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мөрдөгчийн цуглуулсан баримтууд хэзээд ил тодорхой болдог вэ гэхлээр мөрдөн байцаалтын ажиллагаа бүрэн дууссанаар тодорхой болдог. Энд тухайн нөхцөл байдлыг үгүйсгэх, няцаах нотлох баримтуудаа өмгөөлөгч нь яг энэ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны төгсгөлд мэддэг учраас шүүхийн шатад болон прокурорын хяналтын шатад гаргаж өгөх энэ бололцоог нээснээр эрх тэгш мэтгэлцээний нөхцөл байдал бий болох юм гэж үзэж байгаа. Тийм учраас их ач холбогдолтой заалт гэж харж байгаа.

Д.Амарбаясгалан: Прокурорын байгууллагаас нэмэлт мэдээлэл өгье. Ажлын хэсгийн 10 дугаар микрофон.

М.Чинбат: Гишүүний асуултад тодруулъя. Тодруулга өгье. Энэ 30.14.8 дахь хэсэг дээр бол хэрэг бүртгэлтийн хэргийг хянах, прокурорын хугацааг зааж өгсөн

14 хоногийн дотор хэрэг бүртгэлтийн хэргийг хянана гээд зайлшгүй тохиолдолд дээд шатны прокурор 14 хүртэл хоногоор сунгаж болохоор энэ хуулийн нэмэлт зохицуулалтыг хийсэн учир нь бол хэрэг бүртгэлтийн хэрэг зарим тохиолдолд ээдрээ төвөгтэй нэлээд хугацаа шаардахаар ийм байдаг.

Тийм учраас ерөөсөө хүлээж аваад 14 хоногийн дотор хянах ийм боломжгүй нөхцөлд дээд шатны прокурор зайлшгүй тохиолдолд тухайн хэргийг хянах хугацааг хуульчилж өгөх энэ хуулийн зохицуулалтыг хөгжүүлэлт хийж, ингэж нарийвчилж, тодорхой болгож өгч байгаа юм.

Д.Амарбаясгалан: Нямтайширын Номтойбаяр гишүүн асуулт асууя.

Н.Номтойбаяр: Энэ Хууль зүй, дотоод хэргийн сайд Алтангэрэлийн өргөн мэдүүлж байгаа энэ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах энэ хуулийн төслийг дэмжиж байгаа. Гэхдээ хэдэн асуулт байна.

Сэжигтэн, яллагчаар татагдчихдаг. Тэгээд үндсэндээ энэний цаана хэчнээн сайхан хуульд ингээд хүний эрхийг онцгойлон тусгаад, хэм хэмжээг нь зааглаад өгсөн ч гэсэн яг амьдрал дээр төдийлөн хуульд заасан шигээ хэрэгжилтийг хангадаггүй. Тэгээд үндсэндээ хуулийн байгууллагын зүгээс тухайн иргэнийг ийм төөрөгдүүлэх, айлгах, залилах, хуурах, хууль, эрх зүйн мэдлэг муутайг нь далимдуулж эрхийг нь цаад утгаараа хохироох иймэрхүү асуудлууд өдөр тутмын л асуудал болчихсон. Тэгээд энэ дээрээ анхаарна биз.

Энэ 3 асуулт маань юу вэ гэхээр ер нь энэ хүний эрхийн эрх зүйн хөгжилтэй өнөөдрийн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх энэ хуулийн дүйцэл маань ер нь хэр хэмжээнд байгаа вэ? Адаглаад л сая энэ хүний эрхтэй холбоотой Цогтбаатар нарын 9 гишүүний хуулийн төслийг хэлэлцэхийг нь бид нар дөнгөж сая Их Хурлаар шийдлээ гэх мэтчилэн ер нь хүний эрхтэй холбоотой эрх зүйн хөгжилтэй энэ хууль маань хэр уялдаж, хэр хөл нийлүүлж алхах вэ, ер нь юун дээр цаашдаа анхаарах вэ гэдгээ бас бодмоор байна. Би бол бүрэн хангалттай хүний эрхийг хангах хууль биш гэж харж байгаа.

Хоёрт нь юу вэ гэхээр хэрвээ энэ хууль өмнө нь батлагдаад хүчин төгөлдөр мөрдөж байсан бол саяын олон нийтийн дунд шуугиан болдог ноорог гээд хэдэн залуучуудтай холбоотой асуудлууд гарсан. Тэгээд яах аргагүй хуульд заасан энэ процесс өнөөдрийн манай энэ цагдаагийн ажиллаж байгаа байдал, арга барил, мэдээллээ адаглаад ул мөргүй, үндэс суурьтай нягталж байгаа байдал, мэргэжлийн ур чадвар гэх мэтчилэн маш олон ийм сул талууд анзаарагдаж байлаа л даа. Хэрэв энэ хууль хүчин төгөлдөр байсан бол энэ нооргийн асуудалтай жишиж үзэхэд хэрхэн бодит амьдрал дээр өрнөх байсан бол Хууль зүйн сайд энэ дээр юу гэж бодож байна? Ийм л асуулт байна.

Дээрээс нь нэг зүйл байгаад байгаа юм. Энэ ингээд сэжигтэн, яллагчаар татчихдаг. Тэгээд санхүүгийн хүндрэл, бэрхшээлээс үүдэлтэйгээр хувийн өмгөөлөгч хөлсөлж авч чаддаггүй улсаас өмгөөлөгч гаргаад өгдөг. Харамсалтай нь нөгөө өмгөөлөгч маань төдийлөн эрх, үүргээ хариуцлагатайгаар гүйцэтгэдэггүйгээс үүдэлтэй тухайн хүн маш ихээр хохирдог. Энийг бас нэлээн анзаарахгүй бол үндсэндээ ийм түр саатуулах болон хоригдогч статустай олон залуучуудын дийлэнх нь бараг 60-аад орчим хувь нь улсаас олгогдсон өмгөөлөгчөөр эрхээ

хамгаалуулдаг, нөгөөдүүл нь мартаад явчихдаг, хэрэгтэй нь ердөөсөө танилцдаггүй, хөөцөлддөггүй ийм учир дутагдалтай зүйлүүд бас байгаа шүү. Үүнийг бас энэ Өмгөөллийн холбооны ерөнхийлөгч бас сууж байгаа дээр хэлэхийг хүсэж байна. Тэгээд байр суурийг нь бас сонсьё. Энийг өшөө яаж засаж залруулах ажлууд явагдаж байгаа юм, төлөвлөж байгаа юм уу, ер нь энийгээ мэдэж байгаа юм уу?

Д.Амарбаясгалан: Алтангэрэл сайд хариулт өгье.

О.Алтангэрэл: Энэ олон улсын жишигтэй харьцуулахад ямар түвшинд явж байна гэж асууж байх шиг байна. Манай энэ эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх процесс маань. Тэгээд олон шалгуураар үзэж болох байх. Энэ гэмт хэрэг, зөрчлийг мөрдөн шалгаж байгаа үр дүнгээр нэг ярьж болох байх. Хүний эрхийг хэрхэн хангаж байгаагаар нь бас ингээд авч үзэж болох байх. Тэгээд бид одоогийн байгаа процессоо бас яг хангалттай гэж хэлэхгүй ээ. Тэгэхдээ өнөөдөр яг энэ процессын дагуу өнгөрсөн он жилүүдэд Монгол Улсын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж ирсэн. Яг өнөөгийн хууль тогтоомжийнхоо хүрээнд бид нар аль өөрчлөлтүүдийг хийвэл хүний эрхийн шинэчлэлийн шинжтэй өөрчлөлт орох юм гэж судалсны үндсэн дээр өнөөдрийн өөрчлөлт орж ирж байгаа юм.

Ер нь би бас түрүүний тайлбарт дурдсан. Одоо бидэнд цаашдаа нотолгооны хууль, нотлох баримтыг яаж цуглуулах вэ, яаж үнэлэх вэ, нотолгоогоо бид нар юу гэж үзэх юм гэдэг энэ нотолгооны хууль, процессын хуульд нэмэлтээр нотолгооны хууль бидэнд хэрэгтэй байгаа.

Дээрээс нь мөрдөн шалгах ажиллагааны хяналт яаж явагдах вэ? Энэ дээр дан прокурорын байгууллага байх уу, эсвэл шүүхийн хяналтад аль хэсэг нь очих вэ гэдэг дээр боловсронгуй болгох шаардлага бидэнд байгаа. Одоо энэ хуулийн ажлын хэсэг гараад явж байгаа. Бид нар нийцүүлэх талаар нь цаашаа арга хэмжээ авна. Хангалтгүй зүйл байгаа гэдэг дээр Номтойбаяр гишүүнтэй санал нийлж байна.

Би энэ хууль батлагдсан байсан бол гэдгийг ганцхан хэрэг, кэйстэй холбогдуулж яримааргүй байна. Хэрвээ энэ хууль өмнө нь батлагдчихсан байсан бол нийгэмд олны анхаарал татсан олон хэргийг шүүгчид нь наад чинь АТГ-аас явж байгаа хэрэг шүү гээд цагдан хорих хорионы хурал нь явчихдаг. Ямар үндэслэлээр цагдан хорьж байгааг нь өмгөөлөгчид нь хэлдэггүй. Ийм явдал болохгүй байсан байх. Өөрөөр хэлбэл, олон хүмүүс учир шалтгаанаа мэдэхгүй, хоригдохгүй байсан. Энэ хууль өмнө нь батлагдсан бол өмгөөлөл авах хууль зүйн туслалцаа авах эрхээ эдэлж, олон хүн эдлэх ёстой байсан. Заавал өмгөөлөгч оролцуулах процессыг бид нар орж ирж байгаа. Энэ хууль өмнө нь хэрвээ батлагдсан байсан бол прокурор ямар үндэслэлээр татгалзсан тухайгаа хэлдэг, тэрэнд нь тохируулж өмгөөлөгч нар үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалдаг байх байсан байх. Энэ хууль урьд батлагдсан байсан бол шүүх хурал дээр өмгөөлөгч нар олон нотлох баримт гаргаж өгч хүмүүс эрх чөлөөтэй байсан байх байсан байх. Ингэж дүгнэж байгаа.

Өөрөөр хэлбэл, өнөөдрийн бид нар оруулж ирж байгаа өөрчлөлт болгоны ард хүний эрх, эрх чөлөөг хангах процессыг нийцүүлэх энэ зорилго явж байгаа. Тэр улсын өмгөөлөгчтэй холбоотой асуудал бас байгаа. Хууль зүй, дотоод хэргийн

яамнаас дөнгөж өчигдөр гэхэд улсын өмгөөлөгчтэй цуглуулаад энэ асуудлаа бас бид нар ярилцсан. Тэгээд төсөв, төлөвлөгөөнийхөө хүрээнд хийж байгаа мөн өмгөөлөгчдийнхөө пробоно буюу нийтэд тустай үйл ажиллагааг яаж энэ үйл ажиллагаанд хамруул батлах вэ гэдэг дээр Өмгөөлөгчийн холбоотой хамтарч ажиллаж байна. Журам баталж байна. Энэ асуудал дээр анхаарч ажиллаж байгаа. Тэгээд.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон.

Л.Данзанноров: Өмгөөлөгчдийн үйлчилгээ, үйлчилгээний чанартай холбоотой асуудлууд бас нэлээн яригддаг. Сая хөндөгдсөн асуудал бол улсын өмгөөлөгч буюу томилогдсон өмгөөлөгчийн асуудлууд яригдаж байгаа. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулиар бол сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид өмгөөлөгч томилж оролцуулах тусгай журам батлагдаад энэ хүрээнд өмгөөлөгч нар ажиллаж байгаа. Тэгээд энэтэй холбоотой үйлчилгээний чанартай холбоотой асуудлууд байвал яг үйлчлүүлэгчдийн зүгээс холбоонд гомдол гарч асуудлуудыг бас хэлэлцүүлж байгаа. Улсын өмгөөлөгчийг сонгон шалгаруулахтай холбоотой тусдаа журам, дээр нь орон тоог нэмэхтэй холбоотой асуудал дээр яам нэлээд бас анхаараад орон тоо нь бас нэмэгдээд явж байгаа. Хариуцлагатай холбоотой асуудлууд нь тодорхой манай мэргэжлийн хариуцлагын хороогоор бас орж хэлэлцэгддэг асуудлууд байгаа. Бид нар илүү боловсруулах, илүү чадавхжуулах талаар нэлээд бас анхаарч ажиллаж байгаа.

Д.Амарбаясгалан: Жаргалсайханы Золжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Золжаргал: Хүний эрхийг хангах чиглэлд сайжруулж байгаа ийм дэвшилттэй заалтууд оруулж ирж байгаад баяртай байна. Гэхдээ нэмж тусгах шаардлагатай зүйлс гээд бидний хэсэг нөхөд бас ярилцлаа. Ялангуяа энэ шалгаж байгаа нэрээр залхаан цээрлүүлдэг, янагладаг, дарамтлаад ингээд сунгаад байдаг энэ 20 дугаар зууны эхэн үеийн балиар арга хэлбэрийг халахын тулд хэд хэдэн ийм нэмэлт зохицуулалтууд хэрэгтэй юм байна гэж. Эдгээрээс хоёрыг нь төлөөлүүлээд асууя.

Нэгдүгээрт нь цагдаа, прокурор талаасаа 24 цагийн дотор шийдвэр гаргаад баривчилдаг. Нөгөө талдаа өө наадах чинь үндэслэлгүй ийм юм байна гээд өмгөөлөгч тал нь хүсэлт гаргахаар 14 хоногийн хугацаанд шийдвэрлэдэг. Тэгэхээр 1-ийг харьцах нь 14 гэсэн ийм хугацааны ялгаа үүсэж байна.

Өөрөөр хэлбэл, хэрэг шалган шийдвэрлэхэд оролцогч талуудын тэгш эрхтэй байх зарчим хангагдахгүй байна гэсэн үг. Тэгш эрх байхгүй болохоор хүний эрх зөрчигдөх үндэслэлүүд нь тасрахгүй байна гэж үзэж байгаа юм. Тэгээд энэ үүнээс үүдээд түрүүний энэ хамгийн их дуулиантай 2 хэрэг байна шүү дээ. Нөгөө бурхны хүү Баярбаатар яг яасан нь мэдэгдэхгүй олон нийтэд хүндэтгэлгүй үг хэлсэн гээд баригдсан. Нооргийнх байна. Мөрийтэй тоглоом юм уу, амиа хорлох ч байсан юм уу, үндэсний эв нэгдлийг хагалан бутаргасан юм уу, худал мэдээлэл тараасан юм уу гээд ингээд заваараад яваад байгаа. Тэгэхээр энийг байхгүй болгохын тулд яллагдагч тал, өмгөөлөгч талын түрүүн бас яригдаад байна лээ тэгш оролцооны зарчим хангагдах ёстой юм гээд. Энэ заалт дээр асуулт байна.

Хоёрдугаарт нь Зөрчлийг шалган шийдвэрлэх тухай хуулийн нэмэлт, өөрчлөлттэй хамт оруулж ирж болохгүй юм уу гэдэг асуулт. Зөрчлийн хэргээр анхан шатны шүүх нь шийдвэр гаргаад 10 хоногийн баривчлах ял өгчихдөг. Тэр хооронд нь давж заалдах шатны шүүхэд хандаад энийг хэрэгсэхгүй болгоно гээд хариу гарна. Тэр нь 14 хоног байна жишээлбэл. Гэтэл нөгөө хүн чинь 7 хоногийнхоо ялыг эдлээд гарчихсан ингээд хэлмэгдсэн байдалтай хохироод үлдэх ийм заалт байгаа гэж байгаа юм. Тэгэхээр эдгээртэй хамтад нь багцаар нь оруулж ирж болох юм уу гэдэг ийм асуулт байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье, Алтангэрэл сайд.

О.Алтангэрэл: Тийм, Золжаргал гишүүний зовнилыг ойлгож байна. Тэгэхдээ нөгөө энэ процесс ажиллагааны ялгаатай талуудыг бид нар бодох ёстой. Эхний дурдсан кэйс дээр зөрчлийн хэргээр явж байгаа. Зөрчил хянан шийдвэрлэх тухай энэ процессын дагуу л яваад л, Зөрчлийн хуульд гаргасан дагуу яваад шүүх ингээд шийдвэрээ гаргасан асуудал байгаад байгаа. Одоо бид нарын яг ярьж байгаа асуудал бол яг энэ эрүүгийн процессыг ярьж байгаа. Хүнийг шалгадаг, хүний эрх, эрх чөлөөтэй хамгийн ихээр холбогддог энэ процессыг бид нар ярьж байгаа.

Тэгэхээр энэ тэгш эрхийг хангах зарчим хөндөж байна. Тэгэхээр энэ өмгөөлөгч ажиллагаанд оролцож эхэлнэ гэдэг бол бас харьцангуй шууд хойшлуулшгүй ажиллагааны үеэр өмгөөлөгчөө авъя гээд өмгөөлөгчөө авдаг эрх зүйн мэдлэгтэй хүмүүс байна. Энд нь өмгөөлөгч нар оролцож байгаа тохиолдол байна. Энэ үйл ажиллагаа явагдсаны дараа бүүр хожим хэрэг үүсгэгдээд юм уу, яллагдагчаар татаад ингээд явсан тохиолдолд өмгөөлөгч авч байгаа тохиолдол ч байна. Энэ өөрчлөлтийн өнөөдрийн бид нар өөрчлөлтийн гол агуулга бол нэгэнтээ эрх зүйн туслалцаа авъя гэж байгаа бол тэрийг нь хангах, эрх зүйн туслалцаа аваад өмгөөлөгчтэй болчихсоны дараа тэр өмгөөлөгч нь нотлох баримтаа гаргаж өгөх, хүнээ хамгаалах аль ч шатад энэ боломж бололцоог нь бүрдүүлж өгөх гэсэн энэ тал руу байгаа юм.

Тэгэхээр энэ эрх тэгш байдлыг хангана гэдэг асуудал оролцогчдын хувьд ярихад түрүүний жишээ энд яг хойшлуулшгүй ажиллагаатай холбоотой зүйлийг хөндөж байх шиг байна. Энэ эрүүгийн процесс ажиллагааны бид нарын бас цаашаа анхаарах ёстой л зүйл. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт гаргаад бид нар Цагдаагийн албаны тухай хуульд ер нь түр саатуулна гэж юу юм, ямар агуулгатай юм бэ гэдэг энэ өөрчлөлтийг өнгөрсөн оны намрын чуулганаар бид нар оруулсан. Хойшлуулшгүй ажиллагааны журмыг цаашид ер нь хуульд яаж нийцүүлэх юм, тайлагнал нь ямар байх юм гэдэг энэ асуудал дээр бас бидэнд бодож байгаад дараа дараагийн хуулийн өөрчлөлт дээр оруулах ёстой гэж зорьж байгаа зүйлүүд бас байна.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг түрүүн бид нар Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулахыг хүний эрхийн багц хуулийн төсөлтэй холбогдуулан зарим хэсгийг нь өөрчлөхөөр бид нар оруулсан байгаа. Энэ дээр бас та энэ Зөрчил хянан шийдвэрлэх тухай хуультай холбоотойгоор саналуудаа хэлэх бололцоотой болох байх.

Нэг зүйлийг тодотгож хэлэхэд бид нар хүний эрхийг хангахтай холбоотойгоор Эрүүгийн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтөөр энэ эрүүдэн шүүлтээс ангид байх, бусдыг, бусдын нэр төрийг гутаах, ямар хэлбэрээр эрүүдэн шүүхгүй байх талын өөрчлөлтүүдийг бид нар энэ хүний эрхийг хангах холбоотой хуулийн төсөл дээр оруулж өгсөн. Энэ чиглэлийн сайжруулалтыг оруулж өгч байгаа энэ дээр бас гишүүдээс санал гаргаад ингээд цаашаагаа хэлэлцэхийг нь дэмжээд явсан, цаашдаа санал гаргаад улам боловсронгуй болгоод явна гэсэн ийм хүлээлттэй байгаа.

Д.Амарбаясгалан: Хариулт өглөө. Золжаргал гишүүн тодруулах юм уу, болчихсон уу? Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн асуулт асууна. Алга байна. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуулт асууя.

Х.Баасанжаргал: Орж байгаа багц хуультай холбоотой хэд хэдэн асуулт байна. Таслан сэргийлэх арга хэмжээтэй холбоотой, шүүгдэгчид авч байгаа таслан сэргийлэх арга хэмжээ нийт таслан сэргийлэх арга хэмжээний хугацаанд орж тоологддоггүй хэвээрээ байгаа. Тэр орж ирэх болов уу гэсэн тэр заалт орж ирээгүй байна. Тэрийг нэгдүгээрт тодруулж асууя.

Хоёрдугаарт бас таслан сэргийлэх арга хэмжээ хязгаарлалт тогтоодог таслан сэргийлэх арга хэмжээ байгаа. Хилээр орж, гарах, зарим газраар зорчихгүй байх гээд энэ ерөөсөө хуулиар хугацаа заагаагүй, бас сунгах тухай хугацаа ч байхгүй. Энэ дээр бас яагаад ерөөсөө хугацаа заадаг ийм процесс орж ирэхгүй байгаа юм бэ? Хоёр дахь асуулт.

Гурав дахь асуулт энэ 14.10.5, 14.10.14, 15 энэ тэр дээр шүүгдэгчид авч байгаа цагдан хорих, энэ хугацаа тоолоход би бол дордуулж орж ирж байна гэж харж байна. Хорих байранд хүлээн авсан өдрөөс эхлээд цагдан хорих хугацааг тоолно гэж байна.

Гэтэл олон улсын гэрээ конвенцоороо тухайн хүн өөрөө чөлөөтэй зорчих боломжгүй цаг үеэс эхлээд энэ хүнийг саатуулсанд тооцож явдаг. Гэтэл бид нар бүүр яг энэ бүүр хорих байр гээд ингээд яг ийм зүйлээр бид нар дандаа хязгаарлаж энэ хугацааг ингэж тоолж байгааг харах ёстой юм биш үү?

Дөрөвдүгээрт энэ 14.5.7.5 дээр энэ бүүр маш эргэлзээтэй заалт байна л даа. 5 дээр орж ирж байгаа шинэ заалт байна. Прокурорын гаргасан шийдвэр үйл ажиллагаанд гомдол гаргадаг энэтэй холбоотой процессыг 1-ээс 4 дүгээр зүйл дээр зохицуулж байгаа. Гэтэл доор нь дахиад шинээр дээд шатын Прокурорын газар шийдэхээр ийм зохицуулалтууд орж ирж байна. Хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах юм бол дээд шатын прокурорын газар нь шийднэ. Тэгэхдээ газар нь хэд хоногийн дотор шийдэх тухай ерөөсөө хугацаа бас заагаагүй.

Тэгэхээр өмгөөлөгчид прокурорын үйл ажиллагаатай холбоотой хэрэгсэхгүй болсонтой холбоотой гомдлыг дээд шатны прокурорт нь гаргачхаад, дараа нь дахиад энэ прокурорын газарт нь гаргах ийм процесс нэмж орж ирээд байгаа юм уу, ямар учиртай юм? Энэ ерөөсөө маш ойлгомжгүй ийм процесс, нэмэлт ийм процесс орж ирээд байна. Тэгээд энэ прокурорын энэ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тавьж байгаа хяналтын асуудлыг илүү боловсронгуй болгох, илүү тодорхой болгох, илүү хугацаатай болгох, хугацаа нь болж өгвөл богинохон болгох

ийм бодлого яагаад ерөөсөө барихгүй байгаа юм бэ гэдэг асуултыг энэнтэй далимдуулаад давхар асуучихъя.

30.14.8 дахь хэсэг дээр энэ 14 хоногийн дотор хянах ба зайлшгүй тохиолдолд 14 хүртэл хоногоор сунгана, дахиад 30.15 дээр 14 хүртэл хоногоор сунгана гээд ингээд нөгөө хэрэг, хэргийн ээдрээ төвөгтэй байдлыг харгалзаад яллагдагчаар татах энэ асуудал дээр тухайн шатын прокурор 3 хоногийн дотор шийдэж байгаа. Тэгээд дээд шатын прокурор нь шууд 14 хоногоор сунгахаар ингэж хугацаа орж ирж байна. Тэгэхээр энэ 14-өөс бага хоногийн хугацаатай байж болохгүй юу? Тэгэхээр энэ хоног, хугацаанууд дээр ер нь яг тусгайлан харж байгаа, барьж байгаа тийм бодлого юу байгаа вэ гэдгийг энэ дээрээ нэмээд тодруулаад хэлчхээрэй.

31.3 дээр яллах дүгнэлтээ гардаж авахаас татгалзсан бол энэ нь бол татгалзсан нь өөрөө саад болохгүй мөрдөн шалгах ажиллагаа үргэлжлүүлээд явуулна гэж байна. Гэтэл энэ хүн чинь яллагдагчаар татагдаж байгаа тохиолдолд гомдол гаргадаг. Энэ гомдлын хугацаа дууссаны дараа энэ мөрдөн шалгах ажиллагаа явагдахгүй юм уу? Ерөөсөө энэ хүний гомдол гаргах эрхийг ерөөсөө хангахгүй нэлээн ийм хязгаарлагдмал зохицуулалтууд орж ирж байгааг анхаарвал ямар вэ?

Ингээд хамгийн сүүлд 34.16 дээр шууд өмгөөлөгч шүүх хуралдаанд оролцохгүй хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр өмгөөлөгч нь оролцоогүй бол шууд өмгөөлөгч томилж оролцуулна гэж байна. Энэ нөгөө өмгөөлөгчөө чөлөөтэй сонгох эрх яасан бэ? Яагаад ингэж ер нь дордуулж оруулж ирээд байгаа вэ гэдгийг.

Д.Амарбаясгалан: Алтангэрэл сайд хариулт өгье.

О.Алтангэрэл: Энэ нөгөө түрүүний хамгийн эхний асуулт дээр тэр нөгөө хорих байранд, цагдан хорих байранд хүлээж авснаар гэдэг энэ заалт яг хоригдлын тухай зааж байгаа тээ? Өөрөөр хэлэх юм бол хорих ялаар шийтгэгдээд, одоо 14 дээр нь хоригдолд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан үед хорих ялын хугацаа дуусахаар бол энэ зүйлийн 7-д заасан журмын дагуу цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ авах эсэхийг шүүх шийдвэрлэнэ гээд хоригдлын тухай ярьж байгаа. Угаасаа хориотой байгаа хүний тухай ярьж байгаа.

Тэгээд цагдан хорих байранд өөрөөр хэлэх юм бол хорих байгууллагаас, шоронгоос цагдан хорих байгууллагад хүргэгдэх юм бол энэ хугацааг нь тэндээс нь авхуулж тоолъё л гэсэн энэ утгаар оруулж ирж байгаа. Яг хоригдож байгаа, хорих ялыг шийтгэгдсэн этгээдэд хамааралтай зохицуулалт байгаа.

Энэ хугацаа тоолохтой холбоотой тэр 30.14.8-ын хоног тоолохтой хугацаатай болон энэ гомдол гаргах процесстой холбоотой зүйлүүд дээр манай ажлын хэсгээс нэмж хариулаарай. Зарим нэг зүйлүүд дээр хоног хугацааг өөрчлөх, хэлэлцүүлгийн явцад ярилцах зүйлүүд бидэнд байгаа. Харин тэр 31.3-ын сэжигтэн эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах тогтоолтой танилцах, гарын үсэг зурах, гардан авахаас татгалзсан мөрдөн шалгах ажиллагаа явуулахад саад болохгүй гэсэн заалтыг амьдрал дээр бид нар бүгдээрээ мэднэ. Би үзэхгүй ээ, танилцахгүй, зурахгүй гэдэг.

Тэгэхээр нэгэнтээ танилцаагүй зүйл дээр гомдол гаргах энэ процесс нь яаж явахыг би бас сая сайн ойлгосонгүй гишүүн ээ. Тэгээд үзэхгүй ээ, танилцахгүй ээ, би зурахгүй ээ, наадхыг чинь очихгүй гээд ингэж байгаа байхгүй юу. Тэгэхээр бололцоог нь хангах чиг үүргүүд нь хууль дээр байгаа. Яаж танилцуулах юм, гомдлыг нь яаж гаргах юм, татгалзвал яах юм гэдэг бүх журам нь байсаар байтал би энэ дээр үзэхгүй, гарын үсэг зурахгүй. Гарын үсэг зурахгүй байж болно. Тэрийг бид мэддэг. Танилцахгүй гээд ингээд суугаад байвал танилцахыг нь хүлээж процесс удахгүй л гэдэг утга санаагаар орж өгсөн. Бусад тэр хоног, хугацаатай холбоотой зарим нэг санал дээр шууд аваад хэдүүлээ хэлэлцэх эсэхийг шийдвэрлээд бас ярилцахаар зүйлүүд байна гэж харж байна. Ажлын хэсгийн зүгээс прокурорын байгууллагын зүгээс сая тэр гомдолтой холбоотой зүйлүүд дээр нэмэлт хариулт өгчихье.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 10 дугаар микрофон.

О.Мөнхбаатар: Улсын Ерөнхий прокурорын туслах прокурор Мөнхбаатар гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр Эрүүгийн хянан шийдвэрлэх тухай хуульд эрүүгийн хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчдын гомдлыг хүлээн авах, шалгах, шийдвэрлэх гээд нийтлэг журмыг хуульчилчихсан байгаа. Энэ журмынхаа дагуу бид оролцогчдын гомдол, хүсэлтийг шийдвэрлэж явж байгаа.

Энэ хуулийн төсөл дээр энэ дээд шатны прокурорын газар нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан, хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан, хэргийг хэрэгсэхгүй болгосон шийдвэрийг эс зөвшөөрч гарсан гомдлыг хянан шийдвэрлэнэ гэж оруулсан. Энэ зохицуулалт маань өөрөөр хэлбэл ажиллагааны явцад гарч байгаа оролцогчдын гомдол, хүсэлтийг тухайн шатны хэрэгт хяналт тавьж байгаа хяналтын прокурор, тухайн шатны дээд шатны прокуророор шийдвэрлэж дуусгавар болно л гэсэн зохицуулалт.

Хоног хугацаа угаасаа энэ нийтлэг журамд заасныхаа дагуу 14 хоногийн дотор шийдвэрлэнэ. Шаардлага.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн, өө биш Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн.

Х.Баасанжаргал: Уг нь манай хуулийн салбарынхан миний асуултыг аягүй сайн ойлгож байгаа л даа. Тэгээд та хэд маань энэ дээр яг хариултаа яг тодорхой хэлээд өгчихмөөр байх юм булзааруулахгүйгээр. Ялангуяа тэр таслан сэргийлэх арга хэмжээ, цагдан хориотой холбоотой хоног, хугацаа, тэр шүүгдэгчийг цагдан хориод байгаа хугацааг яагаад нийт цагдан хорих хугацаанд оруулсан өөрчлөлтийг одоо болтол яагаад ерөөсөө оруулахгүй байгаа юм бэ? Тэр хязгаарлалт тогтоогоод байгаа таслан сэргийлэх арга хэмжээ дээр яагаад хугацаа ерөөсөө тавихгүй байгаа юм бэ?

Дээрээс нь хамгийн сүүлд бас нэг бүлэг асуулт асуугаадахъя. Энэ хүүхэд эрүүгийн хэргийн гэмт, эрүүгийн процессын ажиллагааны оролцогч, хохирогч, холбогдогч хэн ч байсан хүүхэд оролцож байгаа тохиолдолд энэ хөнгөрүүлсэн ийм заалтууд, бүлгүүд ерөөсөө манай энэ хууль Эрүүгийн процессын хуульд тусгайлж ерөөсөө орж ирэхгүй байна. Тэгэхээр энэ хүүхэдтэй холбоотой асуудал дээр бас

ямар бодлого, эсвэл зүйл барьж байгаа юм бэ гэдэг асуултыг тодруулаад асуучихъя.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье Алтангэрэл сайд.

О.Алтангэрэл: Энэ хязгаарлагдах тогтоох арга түрүүн харин дутуу хариулчхаж. Энэ хязгаарлагдах тогтоох, таслан сэргийлэх арга хэмжээний асуудал бас хүнд байгаа. Энэ чинь нөгөө Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага биелүүлэх ёстой. Тэгээд 2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хязгаарлалт тогтоох, таслан сэргийлэх арга хэмжээг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хуульд заачихсан учраас хэрэгжүүлээд л явж байна.

Гэтэл нөгөө хугацааны тодорхойгүй байдлын улмаас ажлын ачааллаа зөв тооцох, тэгээд шаардлагатай албан хаагчдын орон тооны асуудал дээр бас хүндрэл гарсан, төсөв хөрөнгө дээр хүндрэл гарсан. Тооцоод оруулаад ирсэн юмыг манай гишүүд маань төсвийн үеэр яг шийдвэр гүйцэтгэх байгууллагын тэр орон тоотой холбоотой зүйлийг хасчихсан. Ингээд энэ дээр гүйцэтгэхэд хүндрэл байгаа. Тэгэхээр маш товчхондоо энэ хязгаарлалт тогтоох, таслан сэргийлэх арга хэмжээг хугацаатай болгоё, тэр шүүгдэгчийг цагдан хоригдож байгаа хугацаанд байх хүүхэдтэй холбоотой энэ асуудал дээр дэвшил гаргая гэдэг таны саналыг бүрэн дэмжиж байна. Одоо бид нар энэ эрүү.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо Цогтбаатар даргаа, Хууль зүйн байнгын хороон дарга энэ Эрүүгийн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн асуудал өнөөдөр ингээд хэлэлцэгдээд хэлэлцэх эсэх асуудал дэмжигдэхээр энэ дээр энэ хуульч гишүүдийг оролцуулсан өргөн хүрээний ажлын хэсэг байгуулаад энэ хүний эрхтэй холбоотой асуудлаар Улсын Их Хурал бодлогынхоо төвд ажиллаж байгаа энэ нөхцөл байдал дээрээ нийцүүлж энэ өөрчлөлтийн асуудлыг илүү чанартай болгох тал дээр нь хөндөгдсөн хэмжээнд нь анхаарч ажиллах шаардлагатай байгаа шүү. Гишүүд угаасаа энэ дээр их тийм анхаарал тавьж оролцож байгаа шүү дээ тийм ээ? Тэгье.

Одоо ингээд хуулийн төслүүдийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж болон бүлэгт харьяалагддаггүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу үг хэлнэ, байр сууриа илэрхийлнэ. Нэр өгсөн дарааллын дагуу үг хэлэх зөвшөөрөл өгнө өө.

Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн үг хэлье. Индэрт урьж байна. 2 дугаар индэр. Хуулийн төсөл санаачлагч руу харж, хандаж хэлнэ одоо.

С.Эрдэнэболд: Энэ Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний халдашгүй, чөлөөтэй байх болон өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах үндсэн эрх улам бүүр баталгаажна гэсэн ийм ач холбогдлыг, мөн мөрдөн шалгах ажиллагааны явцад хүний эрхийн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх эрх зүйн орчин улам боловсронгуй болно гэсэн.

Гуравдугаарт шүүхийн үйлчилгээний чанар сайжирна гэсэн ийм үндэслэлүүдийг бол дэмжиж байгаа. Гэхдээ яах вэ нэг бодит нөхцөл байдлыг

хэлмээр байна. Юу гэхлээр бид нарт бол энэ цаасан дээр хуулиуд хангалттай байгаад байгаа юм. Бүүр наад зах нь Үндсэн хууль дээрээ хүний халдашгүй байдлын маш тодорхой зүйл, заалтууд байгаад байгаа. Улсын Их Хурал нэг талаасаа хууль боловсруулж батлахаас гадна түүний хэрэгжилтэд хяналт тавьдаг байх ёстой гэж үзэж байгаа. Энэ бүрэн эрхээ хэрэгжүүлэхийн тулд бас сая өнгөрсөн жил бид 11 сард Улсын Их Хурлын хүн төвтэй байх энэ стратегийг боловсруулаад энэ стратегийнхаа хүрээнд энэ хуулийн, орчны экосистемийн цусны эргэлт нь жигд тархдаг, гүйдэг байх тухай байнга л ярьж байгаа. Тэгээд энэ тохиолдолд нэг том асуудал байгаад байгаа нь энэ хэрэгжүүлэлтийн асуудал байгаад байгаа.

Ер нь бид нар хууль тогтоохдоо хөнжлийнхөө хэрээр хөлөө жийнэ гэдэг зарчмыг бас толгойноосоо авч хаямаар байгаад байгаа юм. Өөрөөр хэлбэл, бодит нөхцөл байдалд тааруулж хууль батлах гэхээсээ илүүтэйгээр ямар тохиолдолд хүний эрхийг хангах ёстой бөгөөд тэр хүрээнд тухайн хуулийн импелментэйшн буюу хэрэгжүүлэлтийг яаж хангах вэ гэдэг дээр бид нар маш их ач холбогдол өгдөг байх ёстой. Сүүлийн жилүүдэд байнга тохиолдож байгаа нэг эмгэнэлтэй зүйл бол энэ эрүүгийн хэргийн хянан шийдвэрлэх процесс цагаан дээр хараар бичсэн хуулийн хэм хэмжээнд явахаас илүүтэйгээр гэнэтийн гарсан дуулиан шуугиан, скандалд хөтлөгдөж тодорхой Пи Ар/PR/-чидийн мөнгө төлсөн ийм зохион байгуулалттай ажиллагааны үндсэн дээр шүүхийн шийдвэрлэх энэ процесс, энэ хуулийн хууль ёсоороо хэрэгжих процесст нь гаж үзэгдэл бий болгохуйц ийм зүйл бий болсон. Маш олон хэргүүдээр бид нар харж байгаа. Заримдаа энэ хуулийн процесс өөрөө сонголттой юм шиг олон нийтэд үзэгддэг болсон. Зарим хэргийг бол барин тавин баримтууд нь гарч ирээд байхад шалгадаггүй, зарим хэргүүд бол гэрлийн хурдаар явдаг. Энэ тохиолдолд бол цагаан дээр хараар бичигдсэн хуулийн хэрэгжилт гэхээсээ илүүтэйгээр улс төрийн динамик өөрчлөлтөөр энэ зүйл нь шийдэгдээд байгаа юм.

Тийм учраас хуулийн үзэл санааг дэмжиж байгаа ч гэсэн энэ хуулийн хэрэгжилт дээрээ ажлын хэсэг маш сайн анхаараасай гэж хүсэж байгаа. Тэгэхгүй болохлоор маш олон кэйсүүд дээр бид дуулиан шуугиан, хэвлэл мэдээллийн энэ динамик өөрчлөлт дээр шийдвэр гаргалтууд яваад байгаа юм. Энэ бол маш аюултай үзэгдэл гэж үзэж байгаа. Алхам алхмаар сөөм сөөмөөр эрх зүйт төрийнхөө үнэт зүйл, зарчмыг гээгдүүлж байгаа, сүүлдээ түүндээ дасал болж байгаа сүүлдээ түүндээ итгэл үнэмшилтэй болж байгаа, сүүлдээ түүнээ хуулийг давсан хувь хүний үзэл, субъектив хандлагыг бид нар тоохоо больж эхэлж байгаа ийм аймшигтай үзэгдэл болж байгаа. Тийм учраас хуулийн сайд энэ төслийг оруулж ирж байгаа хүмүүс хуулийн хэрэгжилт яг энэ цаасан дээр байгаа энэ идеологио бодит амьдрал дээр хэм хэмжээ болгох дээр анхаараарай гэж захиж хэлье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баатаржавын Мөнхсоёл гишүүн үг хэлнэ. 1 дүгээр индэрт урьж байна.

Б.Мөнхсоёл: Сайн байна уу Алтангэрэл сайд? Өдөр билүү, өглөө билүү гэдэг шиг. Бүгд...микрофон хаалттай байна. Бүүр эхнээс нь эхэлье. Сайн байцгаана уу? Бүгдэд нь өглөөний мэнд хүргэе. Алтангэрэл сайд зөв, хэрэгтэй хууль санаачилсанд талархаж байна. Тэгээд өмнө нь үг хэлсэн, асуулт асуусан хүмүүсийнхтэй утга, агуулга давхардуулахгүйн тулд 3 гол санааг л хэлмээр байна.

Нэгдүгээрт нь энэ хүний эрх гэдгийг яг энэ Эрдэнэболдын хэлсэнчлэн бүүр энэ байдаг л асуудал гээд үл ойшоох байдал газар авч байна. Өөрөөр хэлэх юм бол иргэд бас юунд санаа зовж байна вэ гэхээр тухайн хүн албан тушаал ахих тусмаа, эрх мэдэл авах тусмаа хүний эрхийг дээдлэх энэ нөхцөл байдал бас буурч байна шүү гэдэг ийм шүүмж явдаг. Тэгэхээр нэгдүгээрт одоо төр, төрийн өмчит үйлдвэрийн газрууд, бусад төрийн байгууллагууд, компаниуд, энэ нийгэмд оролцоотой явж байгаа бүх байгууллагууд жил бүр улсынхаа хэмжээнд хүний эрхийг авч хэлэлцдэг, тийм ярилцдаг тогтолцоо руу оруулаарай гэдгийг хэлмээр байна.

Хоёрдугаарт нь бид нар бүгдээрээ олон жил ярьсан хэлмэгдүүлэлтийн асуудлыг янз бүрийн өнцгөөр, янз бүрийн цаг үед оноож ярьдаг. Тэгэхээр бүгдээрээ өнгөрсөн үеийн сургамж юу байв хүний эрхийн талаар, тэгээд хэлмэгдүүлэлтийн нөхцөл байдал ямар байгаад өнөөг хүртэл бид нар ямар үр дүн, байдалд хүрэв? Энэ дээр үнэлгээ, дүн шинжилгээ бас хийх ёстой юм болов уу гэдэг ийм санал байна.

Гуравдугаарт нь болохоор хүний эрхийг хэлэлцдэг тийм цахим платформтай болмоор байна. Хүний эрх яагаад зөрчигддөг вэ гэхээр ил зүйлүүд ойлгомжтой байдаг. Жишээлбэл хүүхэд гудамжинд явж байгаад дээрээс нь юм унаад бурхан болчихлоо ч гэдэг юм уу, эсвэл тоглоомын талбайд тоглож байгаад гэнэт осолд орох гээд энэ мэт ил физикал гэдэг биеийн ийм байдалтай осол, гэмтэлд өртөж байгаа энэ хүний эрх зөрчсөн асуудлуудыг нийгмээрээ хардаг, ярьдаг, шуугдаг, өнгөрдөг. Бүүр далд хэлбэртэй хүний эрх зөрчдөг үйл явцууд маш их байдаг шүү. Тийм учраас би энэ үнэлгээг чухалчлаад байгаа юм. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн үг хэлнэ 1 дүгээр индэрт урьж байна.

Ж.Чинбүрэн: Бүгдэд нь энэ өдрийн мэнд хүргэе. Би бас дэмжиж үг хэлэх гэж байна. Алтангэрэл сайдад баярлалаа. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг бүхлээр нь дэмжиж байна. Ер нь удаан хүлээгдсэн.

Тийм учраас энэ чухал цаг үеэ олсон асуудал орж ирж байна. Шүүх, прокурор, мөрдөн шалгах байгууллага хэрэг хянах шийдвэрлэх ажиллагааг цахим платформ ашиглаж явуулах боломжийг хуульчлах зохицуулалтыг оруулж ирж байгаа нь бүүр их том дэвшилтэй зүйл харагдаж байна. Энэ зохицуулалт нь технологийн хөгжилтэй нийцсэн, иргэн төвтэй, ил тод шуурхай ажиллагааг дэмжих чухал алхам болох нь тодорхой. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлыг бууруулах, цаг хугацааг хэмнэх, алслагдсан бүс нутгийн иргэд оролцогчид тэгш боломж олгож байгаагаараа бас чухал нөлөөтэй байна. Цахим шийдлүүдийг хуульчлан нэвтрүүлснээр баримтжуулалт сайжирч, нотлох баримтыг ил тод байдалд оролцогчдын эрхийг хамгаалах боломж нэмэгдэж байгаагаараа бас давуу талтай.

Би энэ дээр харин нэмээд бас хэдэн зүйлийг бас сануулан хэлье гэж бодож байна. Ялангуяа сая Эрдэнэболд гишүүний хэлдэгтэй яг санаа байгаа. Олон нийтээр, олон нийтийн сүлжээгээр явсан зүйл хамгийн их үнэн байдаг юм шиг

аливаа нэг хэрэг шүүхдээ аль нэг талд нь илүү жин дарж оролцох байдал, нөлөөлөлд автах байдал ийм зүйл болчих вий гэдгээс их санаа зовж байна. Ялангуяа нийгэмд үүсээд байгаа 2 шатны шүүхээр гянданд хоригдох ял эдлэхээр болоод байгаа Батчулуун эмчийн хэргийн асуудал яг энэнтэй уялдаж байгаа. Бид ер нь энэ манай эрүүл мэндийг хамгаалах эмчийн ёс зүйтэй асуудлууд их нэлээд өргөн яригддаг.

Дээрээс нь эрхийг нь яаж хамгаалах асуудал нь байдаггүй. Олон олон сувилагч нар, зөвхөн эмч нар ч биш сувилагч нар, эмч нар хүн аврах гэж яваад нөхцөл байдал нь хангагдаагүй, технологи шийдэгдээгүй ийм байдлаас болоод гэмт хэрэгт холбогдох, гянданд хоригдох асуудал нэлээн хурц болоод олон олон сувилагч эмч нар ялыг нь эдэлж байна. Энэ нь өөрөө буцаагаад эрүүл мэндийн салбарт итгэх итгэлийг ард иргэдэд бууруулж байна. Олон нийтийн санал асуулгаар хамгийн их итгэл төрүүлэхгүй байгаа салбарууд гэхлээр шүүхийн салбар байгаад байгаа шүү дээ. Одоо нэмээд эрүүл мэндийн салбар орж байна. Би бас 26 оны төсөв яригдах учраас Алтангэрэл сайдад бас хэлэх гээд байгаа зүйл бол би БЗД-ийнхээ шүүхийн байгууллагуудаар явж үздэг, ордог, уулздаг дэндүү их ачаалалтай, асар их ачаалалтай. Прокурорын байгууллагууд нь олон хэргийг ганц хүн дээр тохдог. Тэрийгээ амжуулах гэж, ажиллах гэж асар их ачаалалтай байдаг учраас энэ төсөв, санхүүжилт дээрээ хэдүүлээ анхаармаар байгаа юм. Энэ санхүүжилт нь хангалттай байгаад олон олон энэ хэрэг бүртгэлийн асуудлууд нь шуурхай хийгдэж чаддаг. Дээрээс нь жижиг хэрэг гэж 5 сая гаруй төгрөгийн хохирол авсан иргэдийн асуудлыг шийдэхгүйгээр бүр 4, 5 жил болсон тохиолдлууд зөндөө байгаа шүү дээ. Энэ болгоныг цэгцлэхгүй бол энэ итгэл хэзээ ч дээшлэхгүй.

Тийм учраас энэ дээр бүүр онцгой анхаарч ажиллаасай. Мөн бас манай эрүүл мэндийн салбарын амбулаторийн үзлэг хийх, иргэнд хүнд хагалгаа энэ тэр хийхийн өмнө заавал зөвшөөрөл авдаг. Энэ зөвшөөрлийн процесс дээр видео бичлэг энэ тэр оруулах тал дээр Эрүүл мэндийн яам өөрөө анхаарал, санаачилгатай ажиллах ёстой. Энийг баримтжуулж заримдаа хэлсэн зүйлийг сонсоогүй энэ тэр байх, эс үгүй бол иргэд маань сандарсан, тэвдсэн ойлгохгүйгээсээ болоод ийм юм ярьсан бил үү, яриагүй билүү эд нар гэдэг. Тийм учраас бидэнд баримт чухал.

Тийм учраас эрүүл мэндийн салбарууд том том хагалгаа хийж байгаа байгууллагуудаасаа эхлээд видео бичлэг хийдэг, амбулаторийн зөвлөгөө өгч байхдаа тэрийгээ баталгаажуулж архивладаг энэ нь буцаад хэрэг хянан шийдвэрлэхэд бас нотлох баримт болдог байх ийм чухал зүйлүүдэд энд анхаарал татмаар санагдаж байна. Ингээд хэдүүлээ бас энэ хуулиа дэмжээд, хуулийн төслөө дэмжээд цааш нь хэлэлцье.

Д.Амарбаясгалан: Батбаярын Жаргалан гишүүн үг хэлнэ. 1 дүгээр индэрт урьж байна.

Б.Жаргалан: Улсын Их Хурлын 18 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангахтай холбоотойгоор Засгийн газраас өргөн мэдүүлсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж байгаа. Гэхдээ Үндсэн хуульд тусгалаа олсон тулгуур зарчим болох хүний шударгаар шүүлгэх эрх, шүүхийн өмнө хүн бүр эрх тэгш байх, хүний халдашгүй байдлыг бататгах, өөрийгөө

өмгөөлөх эрхийг хангахад чиглэсэн реформын шинж чанартай өөрчлөлт хангалттай тусаагүй гэж үзэж байна.

Энэ Их Хурал хуулийн засаглалыг бэхжүүлэх, хүний эрхийн зөрчлийг арилгах тал дээр яг ийм реформын шинж чанартай өөрчлөлт хийх итгэл үнэмшилтэй байгаа гэж ойлгож байгаа. Гэтэл Улсын Их Хурлаас Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг 2017 онд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болгон албан ёсоор өөрчилсөн боловч 1963 оны эрүүгийн байцаан шийтгэх харилцааны хэм хэмжээ, зохицуулалтууд өнөөг хүртэл амь бөх хэвээр байна. Хэргийн бодит байдлыг шүүх мэтгэлцээний үндсэн дээр тогтоох зарчмыг 2017 онд Эрүүгийн процессын хуульд оруулсан хэдий ч хэрхэн хэрэгжих талаар хуулийн нарийвчилсан зохицуулалтыг орхигдуулсны улмаас мэтгэлцэгч талууд шүүхийн өмнө эрх тэгш байх зарчим ноцтой алдагдсан хэвээр байна.

Тодруулбал, мөрдөгч, прокурор нь эрүүгийн гэмт хэрэгт ямар баримт авах, авахгүй байхыг үзэмжээрээ шийддэг онцгой эрх мэдэлтэй хэвээр байсаар байгаа нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шударга ёсны зарчмыг ноцтой алдагдуулж байгаа.

Түүнчлэн хуульд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдах хугацааг хэр уртаар тогтоосон нь орчин цагийн хэлмэгдүүлэлт үүсэх, мөрдөх, яллах, байгууллагын дур зоргоор аашлах нөхцөлийг бий болгож байна.

Тухайлбал, хөөн хэлэлцэх хугацааг 5 жилээр тогтоосон хэргийн тухайд хэрэг бүртгэх хугацаа 5 жил, мөрдөн байцаах хугацаа 10 жил, шүүхээр шийдэгдэх хугацаа 2 жил гэж тооцоход тухайн гэмт хэргийг шийдвэрлэх хуулийн хугацаа даруй 22 жил болж байна. Энэ хугацаанд яллагдагчид хилийн хориг гэх мэт таслан сэргийлэх арга хэмжээ аваад мартчихдаг тал бий. Энэ хүнийг шударгаар шүүлгэх эрхэд ноцтой халдсан эрүүгийн журмаар хүнийг залхаан цээрлүүлэх, дуугүй байлгах ноцтой хэм хэмжээ юм.

Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг тогтоож яллагдагчаар татсан атлаа мөрдөн байцаалт нэрээр дахин 10 жил шалгах аар ийнхүү хуульчилсан нь эхлээд хүнээ олоод, дараа нь хэрэг тохих хуучны арга барил одоо цагт амилах аюулыг дагуулж байна. Үндсэн хуульд заасан иргэн өөрийгөө өмгөөлөх эрх гэдэг нь шүүх хуралдаанд өөрийгөө өмөөрч мэдүүлэг өгөхөөр хязгаарлагдахгүй ба хүн ямар хэрэгт буруутгагдаж байгаагаа мэдэх, өөрийгөө цагаатгах баримт гаргаж өгөх, хуульд заасан хүрээнд баримтыг цуглуулах, цуглуулахыг шаардах, нотлох баримтыг шалгуулах, хууль зүйн туслалцаа авах гэх мэт олон хүчин зүйлсийн нийлбэр байдаг.

Гэтэл хүн өөрийгөө өмгөөлөх эрхийг эдэлснийх нь төлөө төрөөс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулсан гэж үзэх, цагдан хорих үндэслэл болох гэх мэт хүний үндсэн эрхийн зөрчил арилахгүй байна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд яллах тал болох мөрдөгч, прокурорын эрх мэдэл багадаагүй. Тэдгээртэй шүүх дээр тэгш мэтгэлцэгч тал болох өмгөөлөгч нь мөрдөгч, прокуророосоо баримт цуглуулахыг гуйдаг, хүсдэг хуулийн зохицуулалтууд амь бөхтэй байсаар байна. Энэ нь шүүхийн өмнө талууд эрх тэгш байх зарчмыг ноцтой алдагдуулсан хэвээр байна. Хүн өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхтэй хэдий ч эрх зүйн мэдлэгээс хамаарч тухайн хувь хүний тухай

өөрийн эсрэг мэдүүлэг өгөх боломжтой байдаг. Үүнийг олон улсад дуугүй байх эрхээр баталгаажуулдаг. Манай улсын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх эрх зүйд хүний дуугүй байх эрхийг баталгаажуулсан заалт одоог хүртэл орохгүй байсаар байна.

Мөн прокурорын албыг Үндсэн хуульд шүүх эрх мэдлийн бүлэгт хамааруулж, зөвхөн хараат бус хуульч ажиллахаар хуульчлан тогтоосон ч прокурорын үйл ажиллагаа нь гүйцэтгэх эрх мэдлийг буюу захирах.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд үг хэлж дууслаа.

Одоо Байнгын хорооны саналаар санал хураалт явуулахаар байгаа. Гишүүдийг танхимд урьж байна. Үдээс өмнөх хуралдаанаараа саналаа хураагаад эцэслээд шийдээд явах нь зүйтэй гэж үзэж байгаа. Гишүүдийг танхимд цугларах хооронд дараачийн асуудлыг танилцуулж байя. Дараагийн асуудлыг хэлэлцэж эхэлж байя.

11.49 цаг

Өмгөөллийн тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Гончигдоржийн Уянгахишиг танилцуулна. Индэрт урьж байна.

Г.Уянгахишиг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Өмгөөллийн тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хууль болон хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан журмын хүрээнд боловсрууллаа.

Хууль санаачлагчийн зүгээс тус хуулийн төслийн хэрэгцээ, шаардлага, үндэслэлийг судлах зорилгоор холбогдох мэргэжлийн байгууллагын байр суурь, саналыг сонсох, хуульчдаас ирүүлсэн гомдол, хүсэлтийн судалгааг авах, мөн Өмгөөллийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.3 дахь заалттай холбогдуулан Үндсэн хуулийн цэцээс явуулсан маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны үр дүн, шийдвэр, дүгнэлттэй танилцах зэрэг холбогдох судалгааг хийж, дүгнэлт гаргасан болно.

Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Өмгөөллийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.3-д хуульчийг өмгөөлөгчийн шалгалтад оруулахаас татгалзах тохиолдлын нь энэ хуулийн 15.1.12, 15.1.13-д заасан өмгөөллийн үйл ажиллагаатай хавсран эрхэлж болохгүй ажил, албан тушаал эрхэлж байгаа гэж заасан нь шалгалтад орох хуульчийн эрхийг зөрчиж Монгол Улсын Үндсэн хуульд заасан ажил, мэргэжлээ чөлөөтэй сонгох эрхийг хязгаарласан бодит нөхцөл байдал үүсэж байгаа бөгөөд иргэний Үндсэн хуулиар олгогдсон эрхийг хангах зорилгоор энэхүү хуулийн төслийг боловсрууллаа.

Энэхүү хуулийн төсөл нь 2 зүйлээс бүрдэх ба 1 дүгээр зүйлд Өмгөөллийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.3 дахь заалтыг хүчингүй болсонд тооцох тухай тусгасан. 2 дугаар зүйлд хуулийн хүчин төгөлдөр мөрдөж эхлэх хугацааг заасан болно.

Өмгөөллийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.3 дахь заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл батлагдсанаар аливаа хуульч нь өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхийн шалгалтад хууль бус хязгаарлалтаас ангид хамрагдах боломж бүрдэж, хуулийн зорилгыг гажуудуулсан, хуулийн бусад зүйл, заалттай зөрчилдсөн зохицуулалт засварлагдана гэж харж байна.

Иймд уг хуулийн төслийг хэлэлцэж шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Төслийн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Мөнхтөрийн Нарантуяа-Нара танилцуулна. Индэрт урьж байна.

М.Нарантуяа-Нара: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишигээс 2025 оны 3 дугаар сарын 17-ны Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Өмгөөллийн тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Хууль зүйн байнгын хороо 2025 оны 4 дүгээр сарын 02-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиар өмгөөллийн үйл ажиллагаатай хавсран эрхэлж болохгүй ажил, албан тушаал эрхлэлтийн зохицуулалт нь өмгөөлөгчийн шалгалтад орох хуульчийн эрхийг зөрчиж, Монгол Улсын Үндсэн хуульд заасан ажил, мэргэжлээ чөлөөтэй сонгох эрхийг хязгаарласан бодит нөхцөл байдал үүсгэсэн байх тул иргэний Үндсэн хуулиар олгогдсон эрхийг хангах зорилгын хүрээнд уг хуулийн төслийг боловсруулсан байх бөгөөд хуулийн төсөл батлагдсанаар хуульч нь өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхийн шалгалтад ороход хууль бус хязгаарлалт тавигдахгүй байх боломж бүрдэж, хуулийн бусад зүйл, заалттай зөрчилдсөн зохицуулалтыг арилгана гэж үзсэн байна.

Хуулийн төслийг d.parliament цахим хуудсанд байршуулж, иргэд, олон нийтийн саналыг авч байгаа болно. Байнгын хорооны хуралдаанаар уг асуудлыг хэлэлцэх үеэр Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжиж байгаа талаар үг хэллээ.

Өмгөөллийн тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Өмгөөллийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарлаа хандуулсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэгт болон бүлэгт харьяалагддаггүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. 2 гишүүн байна.

Нямтайширын Номтойбаяр асуулт асууна. Асуулт цуцлагдлаа. Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн алга байна. Ингээд гишүүд асуулт асууж дууслаа.

Хуулийн төслийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай гишүүд бас үг хэлэх дэгтэй. Урьдчилж нэр ирээгүй байна.

Одоо Байнгын хорооны саналаар Өмгөөллийн тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжих эсэх талаар санал хураалт явуулахаар байгаа. Гишүүд суудлаа эзэлье. Санал хураалт эхлүүлье.

Байнгын хорооны саналаар Өмгөөллийн тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна. Санал хураалт.

1.Байнгын хорооны саналаар Өмгөөллийн тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

Санал хураалт. Санал хураалтыг цуцаллаа. Үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

Энэ тийм байна. Энэ төхөөрөмжөө, сая би эндээс бас давхар удирдчихсан чинь гацчих шиг боллоо санал хураалтыг нь. Үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

63 гишүүн буюу 58.3 хувиар санал дэмжигдлээ.

Мөн Жигжидийн Батжаргал гишүүнийг дэмжсэнээр протоколд тэмдэглээ.

Ингээд Өмгөөллийн тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг гишүүдийн олонх дэмжсэн тул төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүллээ.

12.01 цаг

Өмнөх асуудлын санал хураалтыг явуулъя. Санал хураалт Байнгын хорооны саналаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

60 гишүүн буюу 55.6 хувиар санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

60 гишүүн буюу 55.6 хувиар санал дэмжигдлээ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг гишүүдийн олонх дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүллээ. Дараагийн асуудалд оръё.

12.03 цаг

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Хууль санаачлагчийн илтгэлийг Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ням-Осорын Учрал танилцуулна. Индэрт урьж байна.

Н.Учрал: Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна гэж, 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт Үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн гэж тус тус заасан.

Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 11.4 дэх заалтад заасны дагуу төлбөр таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх бөгөөд 2022, 2023 онд хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас 3 компанид тусгай зөвшөөрөл олгосон байдаг.

Харин Монгол Улсад казино байгуулах, ажиллуулахыг хориглох тухай 1999 оны 1 зүйлтэй хууль хүчин төгөлдөр үйлчилж байгаа бөгөөд Эрүүгийн хууль болон

Зөрчлийн тухай хуулиар мөрийтэй тоглоом тоглох, зохион байгуулахыг хориглож, хүлээлгэх хариуцлагыг тогтоосон.

Үндэсний статистикийн хорооноос хийсэн судалгаагаар 2023 оны байдлаар эдийн засгийн гэмт хэрэг 200 бүртгэгдэж, 2024 онд эдийн засгийн гэмт хэргийн улмаас нийт 417.2 тэрбум төгрөгийн хохирол учирч, эдийн засгийн гэмт хэргийн хохирогчийн 9.2 хувийг 18-29 насны бүлэг, 47,7 хувийг 30-39 насны бүлэг, 24.6 хувийг 40-49-ний насны бүлэг эзэлж байна.

Мөрийтэй болон бооцоот тоглоомын үйл ажиллагаа эрхлэх замаар мөнгө угаах, бусдыг залилах, татвар төлөхөөс зайлсхийх зэрэг эдийн засгийн гэмт хэргүүд ихээр үйлдэгдэж, давхардсан тоогоор сүүлийн 3 жилийн хугацаанд манай улсад хууль бус мөрийтэй тоглоомын 350-450 орчим сайт идэвхтэй үйл ажиллагаагаа явуулж байна.

Цагдаагийн байгууллагаас ирүүлсэн мэдээллээр тусгай зөвшөөрөл авахгүйгээр үйл ажиллагаа эрхэлж байгаа спортын бооцоот тоглоомын 1xBet сайтаар дамжуулан гэмт хэргийн замаар олсон хууль бус хөрөнгийг гуйвуулах, нуун далдлах, оффшор эргэлтэд оруулах, авлига, албан тушаалын гэмт хэргийн замаар олсон мөнгийг угааж байгаа нөхцөл байдал тогтоогдсон.

Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны явцад Арабын Нэгдсэн Эмират, Хонконг зэрэг улсуудад бүртгэлтэй хуулийн этгээдээр дамжуулан Монгол Улсын нэр бүхий аж ахуйн нэгжтэй 6 мянгаас 77 мянган доллар хүртэл гэрээ байгуулж, манай 1xBet манай улс руу зар сурталчилгааны зорилгоор 3.3 тэрбум төгрөг шилжиж ирсэн хэдий ч 2024 оны байдлаар манай улсаас 1.7 их наяд төгрөг буюу гадаад валютын нөөцийн 10 хувьтай тэнцэх хэмжээний дүн болох 500 сая ам.доллар, 2025 оны эхний 2 сарын байдлаар 87 сая ам.доллар гадаад улс руу шилжсэн байна. Энэ мөнгөн шилжүүлгийг 1xBet-тэй гэрээ байгуулан мөнгөн шилжүүлгийн 2-50 хувийг шимтгэлд авч, төлбөр тооцооны данс, гар утасны дугаар, цахим хаяг зэргийг ашиглан зуучлалын үйл ажиллагаа явуулдаг 110 агентаар дамжиж гарсан тоон мэдээ байна.

Гадаад улс орнуудын цахим мөрийтэй болон бооцоот тоглоомыг хүлээн зөвшөөрч байгаа эсэх талаар 2024 оны 9 дүгээр сард гаргасан жагсаалтад манай улстай нийгмийн үнэлэмж, соёл уламжлалын хувьд ижил төсөөтэй Ази Номхон далайн бүс нутгийн улс орнуудыг судалж үзэхэд нийт 46 улс орны 21 улс нь цахим мөрийтэй болон бооцоот тоглоомыг хууль бус гэж үзэж, эдгээр улс орны тоонд Япон, БНСУ, БНХАУ, Тайланд, Вьетнам, Индонез, Мальдив, Непал, Лаос, Бангладеш зэрэг улсууд багтаж байна.

Мөн мөрийтэй болон бооцоот тоглоомоос эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн хувьд олон улсын сэтгэцийн эмгэгийн жагсаалтад F63.0 онош буюу мөрийцөх донг хамааруулсан байдаг бөгөөд СЭМҮТ-д хандаж мөрийцөх дон оноштойгоор 2021 онд 8 хүн амбулаториор үзүүлж, 10 хүн хэвтэн эмчлүүлсэн. 2022 онд 75 хүн амбулаториор үзүүлж, 37 хүн хэвтэн эмчлүүлсэн. 2021 онд 101 хүн амбулаториор үзүүлж, 45 хүн хэвтэн эмчлүүлж жил ирэх тутам энэ чиглэлээр эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах иргэдийн тоо огцом нэмэгдсээр байна.

Иймд манай улсын нийгэм, эдийн засаг, иргэдийн эрүүл мэндэд ихээхэн хэмжээний хохирол учруулж, эдийн засгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж байгаа үйлдлийг таслан зогсоох зорилгоор Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсруулж, төлбөрт таавар, бооцоот тоглоом, цахим мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа эрхлэхийг бүрэн хориглохоор тусгалаа.

Үүнтэй уялдуулан Эрүүгийн хууль, Зөрчлийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, төлбөрт таавар, бооцоот тоглоом, цахим мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа эрхлэх, зуучлах, өөрийн нэр дээр бүртгэлтэй төлбөр, тооцооны данс, харилцаа холбооны сүлжээний дугаар, цахим хаяг зэргийг бусдад ашиглуулах үйлдлийг гэмт хэрэгт тооцох, төлбөрт таавар, бооцоот тоглоом, мөрийтэй тоглоомыг сурталчлах, үйл ажиллагааг нь эрхлэх, уриалах үйлдлийг зөрчилд хамруулахаар зааж хүлээлгэх хариуцлагыг тогтоолоо.

Мөн мөрийтэй болон бооцоот тоглоомоос олсон хууль бус хөрөнгийг гуйвуулах, нуун далдлах, оффшор эргэлтэд оруулах, мөнгө угаахаас урьдчилан сэргийлэх зорилгоор Банкны хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, төлбөрт таавар, бооцоот тоглоом, цахим мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа эрхлэх, зуучлах, цахим залилангийн гэмт хэргийг мөрдөн шалгах явцад Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу эрх бүхий байгууллагаас шаардсан тохиолдолд мэдээлэл солилцох, хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах нөхцөлийг бүрдүүлэхээр хуулийн төсөлд тусгалаа.

Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэхийг шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Төслүүдийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Отгоншарын Батнайрамдал танилцуулна.

О.Батнайрамдал: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 3 дугаар сарын 26-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Эдийн засгийн байнгын хороо 2025 оны 4 сарын 1-ний өдөр хуралдаанаар авч хэлэлцлээ.

Хууль санаачлагчийн зүгээс Монгол Улсын иргэд цахим гэмт хэрэг, мөрийтэй тоглоом, залилах гэмт хэргийн хохирогч болж эд хөрөнгөө их хэмжээгээр алдах эрсдэлээс урьдчилан сэргийлэх, валютын гадагш чиглэсэн хяналтгүй урсгалыг зогсоох, эдийн засгийн аюулгүй байдлыг хангах зорилгоор Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулжээ.

Хуулийн төслийг d.parliament.mn цахим сайтад байршуулж иргэд олон нийтийн саналыг авч байна. Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд олон нийтийн телевизээр явагддаг эд мөнгөний хонжвортой сугалаатай холбоотой асуудалд судалгаа хийгдсэн эсэх, төлбөрт таавар, бооцоот тоглоом, цахим мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа эрхлэх, зуучлах зорилготой олон удаагийн үйлдэлтэй сэжигтэй гүйлгээг хориглох. Үүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Номинчимэг төлбөрт таавар, тооцоот, бооцоот тоглоом, цахим мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа эрхлэхийг хориглохоос гадна иргэдийн санхүүгийн боловсролыг сайжруулах, донтолтоос урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг үе шат дараатай зохион байгуулах. Хууль батлагдсаны дараах хэрэгжилтийг хэрхэн хангах, хэн хариуцах, Харилцаа холбооны зохицуулах хороо энэ асуудалд ямар үүрэгтэй оролцох, нийтийн цахим сүлжээнд явагддаг зөвшөөрөлгүй хонжворт сугалааны нийтийн цахим асуудлыг хэрхэн шийдвэрлэх, банкны гадаад гүйлгээний хяналтын дүн шинжилгээ хийсэн эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Уянгахишиг Зөвшөөрлийн тухай хуульд төлбөрт таавар, бооцоот тоглоом, цахим мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа эрхлэхийг хориглосон, тусгасан нь хууль зүйн техникийн хувьд зохисгүй бөгөөд уг асуудлыг тусгайлан хуулиар зохицуулах нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Жаргалан бооцоот тоглоом, цахим мөрийтэй тоглоом, хялбар аргаар мөнгө олох сэдлээр тоглож байгаа тул иргэдийн орлогыг сайжруулах арга хэмжээ авах, ажлын байрыг нэмэгдүүлэх, мөрийтэй тоглоомын талаарх хууль, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, хуулийн төслийн танилцуулга, үзэл баримтлалд тодорхой 1 компанийн нэрийг дурдаж 1 компанид чиглэсэн байдлаар хууль тогтоомж батлах нь зохимжгүй байгааг цаашид анхаарах. Банкны гадаад гүйлгээг хэрхэн хянах талаар, Улсын Их Хурлын гишүүн Сэддорж хуулиар хориглох, хориглохоор болж буй төлбөр, таавар, бооцоот тоглоом гэсэн агуулгад бооцоот морин уралдаан болон бусад спортын тэмцээн уралдааны бооцооны асуудал хамаарах эсэх талаар асуулт асууж, хариулт авлаа.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Номинчимэг үүсээд байгаа асуудлаар хуулиар хориглох арга хэмжээ авч байгаа нь зүйтэй боловч хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллахад голлон анхаарах, шинэ төрлийн гэмт хэргийн талаар судалгаа тооцоо хийж, иргэд, цахим гэмт хэрэг, залилангийн хохирогч болох эд хөрөнгийн их хэмжээгээр алдах эрсдэлээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг оновчтой зохион байгуулах талаар, Улсын Их Хурлын гишүүн Уянгахишиг Засгийн газрын хууль тогтоомжийн төсөл боловсруулахдаа хууль зүйн техник болон холбогдох хуулийн зарчмыг баримталж цахим гэмт хэргийн талаарх тусгайлсан хуулиа өргөн мэдүүлэх, хуулийн төслийг хамт өргөн мэдүүлсэн Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр мөрдөн шалгах байгууллага дансны мэдээлэл гаргуулж авч байгаа асуудлыг холбогдох хуульд нийцүүлж тодорхой зохицуулах нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Мөнхсоёл мөрийтэй тоглоомд хэт донтсоноос болж гэр бүлийн өрх, өрхийн эдийн засаг болон сэтгэл зүйн асуудлууд, гэр бүлийн салалт гэх мэт нийгмийн олон асуудал үүсэж байгаагийн зэрэгцээ, мөн Монгол Улсаас гарах гадаад валютын томоохон урсгал үүссэнээс төлбөрийн тэнцэлд сөрөг нөлөө үзүүлж байгаа нь зохицуулалт шаардлагатайг илэрхийлж, цахим мөрийтэй тоглоомтой холбоотой асуудлыг баримтжуулан олон нийтэд түгээх, мэдээллээр хангах ажил хийгдэх, өргөн мэдүүлсэн төсөл нь хууль хоорондын зөрчил үүсгэж болзошгүй талаар

зарим хуульч гишүүн хэлж буйг харгалзан үзэж аливаа хөндлөнгийн хөндөж буй асуудлыг цогц байдлаар шийдвэрлэх нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Энхцэцэг ард иргэдийнхээ эрхийг хамгаалахын тулд хуулийн төслийг маш яаралтай батлах нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Батнайрамдал цахим мөрийтэй тоглоомоос болж иргэдэд, нийгэмд хор хохирол, хохирол учирч байгаа энэ хуулийн зохицуулалтыг яаралтай батлах нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Жаргалан прокурорын байгууллагын зөвшөөрөлгүйгээр цагдаагийн байгууллага иргэдийн дансны мэдээллийг шууд гаргуулан авах эрхийг нээж өгч байгаа зохицуулалтыг дэмжихгүй байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Учрал цахим, мөрийтэй тоглоом зохицуулах хууль, эрх зүйн орчныг сайжруулах хуулийн төслийг Улсын Их Хурлаар яаралтай хэлэлцүүлэн баталж, төрийн байгууллагуудын чиг үүргийн дагуу ажлаа хийх боломжийг бүрдүүлэх шаардлагатай талаар саналаа илэрхийлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зар сурталчилгааны хуульд нэмэлт оруулах тухай, Банкны хуульд нэмэлт оруулах тухай, Онцгой албан татварын хуульд өөрчлөлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татварын хуульд өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Ням-Осорын Учрал Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Ганболдын Энхтайван Монголбанкны Дэд ерөнхийлөгч, Батаагийн Батцэцэг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Нармандахын Жамъянхүү Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга, Хаш-Эрдэнийн Сүрэнхорол Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын Засгийн газрын ахлах референт, Баатарчулууны Золбоо Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого зохицуулалтын газрын референт, Тойруулын Батболд Харилцаа холбооны зохицуулах хорооны зохицуулалтын газрын дарга, Сайнбуянгийн Тайван Цагдаагийн ерөнхий газрын Кибер гэмт хэрэгтэй тэмцэх газрын дарга, Цэрэндэлгэрийн Тэрбиш Монополын эсрэг газрын хэрэглэгчийн эрхийг хамгаалах зар сурталчилгааны газрын дарга, Баатарсүрэнгийн Батзориг Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга, Цэрэнсүрэнгийн Лхагвацэнд Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Нийтийн эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн.

Ингээд Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан бүлэгт болон бүлэгт харьяалагддаггүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асуухаар байна. Нийт 22 гишүүн нэрээ ирүүлсэн байна.

Эхний асуулт Өлзийхүүгийн Шижир гишүүн? Алга байна. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя.

Б.Бат-Эрдэнэ: Хуулийн төслийг дэмжиж байна. Нэмэлт, өөрчлөлт хийнэ, мөрийтэй тоглоомтой холбоотой, хор хохиролтой холбоотой асуудлууд байгааг ойлгож байгаа.

Гэхдээ 1 асуулт байгаа. Аливаа зүйл зохицуулалттай байснаараа шийдвэрлэгддэг. Сая бас хууль санаачлагчийн зүгээс явж байгаа илтгэлүүдийг сонслоо. Донтолтын тухай ярьж байгаа. Донтолт гэдэг бол шууд хуулиар хориглосноор донтолт алга болно гэдэг ойлголт байхгүй. Жишээлэх юм бол архины хэрэглээ архинд донтогчдын асуудал ч гэсэн байгаа шүү дээ. Архийг хориглосноор архи уух багасдаггүй, найт клуб/night club/-уудыг хааснаар ахуйн хэрэглээний архидалт ихсэж, хүчирхийлэл ихэсдэг болохоос биш бүр ор байхгүй болдоггүй.

Тэгэхээр бид нар энэ зохицуулалтыг хийх, хаах8 боох гэхээсээ илүүтэй тодорхой хэмжээний зохицуулалтыг хийх боломж байгаагүй юу гэдгийг би асуух гэж байгаа юм. Яагаад гэхлээр сая яах вэ ингээд мэдээллүүд нь байна л даа 500 сая доллар агентуудаар дамжаад гадагшийгаа гарч байна. Гэтэл нөгөө талдаа 1xBet манай улс руу зар сурталчилгааны зорилгоор 3 тэрбум 345.4 сая төгрөг буюу 976779 ам.доллар руу шилжүүлсэн боловч эргээд гарч байгаа мөнгөн дүн их байна, иргэдийн хохирол өндөр байна, мөрийтэй тоглоомоос болж хохирсон иргэдийн тоо өндөр байна гээд ингээд явж байгаа.

Гэхдээ нөгөө талдаа бид нар гадагшаа гарч байгаа урсгалуудаа бас тооцох ёстой. Өнөөдөр дотор Монгол Улс зохицуулалтыг хаах, боох хэлбэр дээр явуулснаар хууль бус мөрийтэй тоглоом нөгөө талдаа оролцоо өндөрсөнө. Гадаадын сайтууд руу хандах хандлагууд өндөрсөнө. Магадгүй гадаад руу гарч мөрийтэй тоглоом тоглох хэлбэр бас ихсэх, төрийн хяналт бол маш хатуу, хяналт чанга байх ёстой болж эхэлж байгаа юм.

Тэгээд бид нар хаана, бооно гэхээс илүүтэй нөгөө архины хэрэглээг зөөлрүүлэх софт/soft/ хэрэглээ рүү шилжүүлнэ гэдэг шиг зарим хаахыг нь хаагаад, зохицуулалтын хэлбэр дээр зохицуулалт хийх боломжтойг нь зохицуулалт хийх боломжтойгоор нь байгаад эдийн засгийн үр өгөөжийнх нь тооцоонуудыг их сайжруулаад явах боломж байгаагүй юу? Тэр татвартай холбоотой асуудал яригдаад байна лээ л дээ. 3 тэрбумын татвар тухайн 3 аж ахуйн нэгж төлөөгүй шүү дээ гээд. Үгүй энэ аж ахуйн нэгжүүдийг чинь тэгээд ямар аж ахуйн нэгжүүд нь 3 тэрбум төгрөгийн татвар төлөхгүй яваад болоод байдаг. Ямар аж ахуйн нэгжүүд нь 5, 10 сая төгрөгийн өртэй болохоор данс нь хаалгачхаад үйл ажиллагаагаа явуулж чадахгүй хэлбэрт орчихоод байдаг юм. Энэ бас их сонирхолтой. Цагдаагийн байгууллагынхан өөрсдөө үүн дотор оролцсон гэдэг мэдээллүүд яваад байгаа шүү дээ. Тэгээд энэ өөрөө цаашдаа төрийн хяналт сайжрах түвшин дээрээ илүү нарийн зохицуулалттай өнөөдрийн энэ эрх зүйн орчны өөрчлөлт орсноороо илүү

их нарийн зохицуулалт руу шилжиж ядаж энэ төрийн хяналтын байгууллагын албан тушаалтнууд оролцохгүй байх асуудлууд бүрэн шийдвэрлэгдэж яг чадах юм уу? Тэгэхээр зохицуулалтын хэлбэр дээр ямар түвшний судалгаа, шинжилгээнүүдийг хийгээд энэ бол үнэхээр болохгүй юм байна гэдэг дүгнэлт гаргаад энийг бүгдийг нь хаая гэдэг шийдвэрийг хуульд оруулахаар оруулж ирж байгаа вэ гэдгийг асуух гэж байгаа юм. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье Учрал сайд.

Н.Учрал: Зөвшөөрлийн хууль дээр төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг Хууль зүйн сайд олгодог. Тэгэхээр энэ агуулгаараа өөрөө Монгол Улс хуулиар бооцоот тоглоомыг зөвшөөрсөн гэсэн агуулга мөн үү гэвэл бас мөн шүү.

Тийм учраас бооцоот тоглоомын үйл ажиллагаа бид нар явуулж байна гээд цахим мөрийтэй тоглоомын хэв шинжтэй үйл ажиллагаануудыг эрхэлдэг аж ахуйн нэгж байгуулдаг, ашиг олох зорилгоор. Тэгээд нөгөө тэр 1 аппликэйшн дээр цахим мөрийтэй тоглоом, бооцоот тоглоомд зуучлахын тулд 110 агент байгуулагдчихсан. Агент дундаас нь 2-5 хувийн шимтгэл авдаг.

Тэгэхээр 500 сая доллароос 110 агент хуваагаад 2-5 хувийн шимтгэл авсан зуучилснаараа шүү дээ. Тэгээд энэ гадагшаа гарчхаад байгаа 500 сая доллар гэдэг чинь яг үнэндээ яг бүртгэлтэй гарч байгаа урсгал нь шүү дээ. Тэрнээс бүртгэлгүйгээр буюу нөгөө крипто валютаар, нөгөө бидний ярьж заншсан койноор, утаснаас утасны хооронд шилжүүлж байгааг хэн ч тоолж чадаагүй шүү дээ. Тэр дээр хэдий хэмжээний мөнгө гараад явчихсаныг хэн ч мэдэхгүй. Энэ бүртгэлтэй буюу арилжааны банкаар дамжихсан. Тэр дунд нь байгаа агентууд бол цахим хаяг ашиглуулдаг юм байна. Гар утасны дугаар вань тайм паспорт/one time passport/ гээд нэхэж аваад ингээд үйл ажиллагааг нь дэмждэг юм байна. Тэгээд дээрээс нь данс ашиглуулдаг юм байна. Данс руу мөнгөө хийгээд гаргадаг юм байна. Ингээд эхлэхээр чинь нөгөө Монголбанк дээр ирж байгаа нэгдсэн статистик дээр тэр 500 сая доллар гарч байгаа юм. Үүнийг нөгөө тал нь юу гэж тайлбарладаг вэ гэхээр 1xBet гээд байгаа газар чинь Монголын аягүй олон спортын багийг, аягүй олон юмыг дэмжээд байна гээд. Үнэхээр тэгээд дэмжээд байгаа юм уу гэсэн чинь тэр нь 3.3 тэрбум төгрөг орчим төгрөгийг л нийт зар сурталчилгаагаар спонсорлох нэрийдлээр олж ирснээ буцаагаад 500 аваад гарчихсан.

Тэгэхээр 1 гараараа валютынхаа нөөцийг нэмэгдүүлье гээд Засгийн газар зүтгээд байдаг, нөгөө гараар нь ингээд алдаад байдаг, доллар шатаагаад байдаг. Тэгээд энэ болохоор нийгмийн хор аюул нь өөрөө 23 онд гэхэд 417 тэрбум төгрөгийн хохирол учирчихсан эдийн засгийн гэмт хэргээс, тэгээд 1.7 их наяд гараад явчихсан байхад төр юу ч хийхгүй, энэ бол чөлөөтэй байх ёстой, энэ хувь хүний асуудал биш үү гээд хаяж болохгүй шүү дээ. Тоглож байгаа хүний буруу гэж ерөөсөө хаяж болохгүй юм байна лээ.

Яагаад гэхээр энэ чинь өөрөө энэ инфляцад нөлөөлж байгаа юм 1.7 чинь. Ээ үнэ, бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлтөд нөлөөлж байгаа юу? Нөлөөлж л байгаа шүү дээ. Тэгэхээр энэ байдлыг бол бид нар хуулиар зогсоогоод, чадвал хуулийн байгууллага, харилцаа холбооны салбар, технологийн байгууллага,

гүйцэтгэх засаглал бүтнээрээ ажиллаж чадвал 65 хувь бууруулах юм байна л гэдэг ийм үндэслэлээр хуульд өөрчлөлт оруулж байгаа.

Д.Амарбаясгалан: Бат-Эрдэнэ гишүүн тодруулж асууя.

Б.Бат-Эрдэнэ: Харин тийм Учрал сайд аа одоо яг наадах чинь л яриад байгаа байхгүй юу. Би танаас асуусан асуултыг та яг эсрэг талаас нь хариулчихлаа. Албан ёсны бүртгэлтэйг нь та хэд маань мэдээд байгаа байхгүй юу. Албан ёсны бүртгэлгүй нь хэд вэ гэдгийг ерөөсөө тооцож чадахгүй шүү дээ. Бүртгэл байхгүй шүү дээ.

Тэгэхээр өнөөдөр эрх зүйн орчин Зөвшөөрлийн тухай хуулиас авхуулаад энэ эрх зүйн орчинд өөрчлөлт орсноороо миний асуугаад байгаа асуулт бүртгэлтэй хэсэг чинь хумигдаад, бүртгэлгүй хэсэг чинь бүүр ихэсчих юм биш үү энэ чинь хар зах зээл. Хар зах зээл илүү хөгжих процесс руугаа орчих вий дээ. Тэгэхээр та хэдийн бүртгэл бол бүртгэлтэй хэсэг дээр авсан тоогоо яриад байгаа болохоос биш, бүртгэлгүй хэсэг нь үүнээс илүү байгаа байх гээд байгаа байхгүй юу. Тэгээд одоо хориглох заалтууд оруулчихаар бүртгэлгүй хэсэг чинь бүр ихэсчих юм биш үү. Энэ дээр тооцоо судалгаа хийсэн зүйл байгаа юу л гэж би асуугаад байгаа юм.

Д.Амарбаясгалан: Тийм дээрээс нь ер нь яах вэ гарч байгаа гээд дүн яриад байна шүү дээ. Бас ордог урсгал гэж байна уу? Тэр дүн ер нь ямар байдаг юм? Учрал сайд хариулт өгье.

Н.Учрал: Одоо Зөвшөөрлийн хуулиараа 3 компанид тусгай зөвшөөрөл өгсөн байна л даа бооцоот тоглоомын. Хэрвээ ингээд нээлттэй, одоо бол энэ чинь хуулийн, Зөвшөөрлийн хуулиараа зөвшөөрөл олгоод ингээд явж байна шүү дээ. Тэгвэл ийм байхад өнөөдөр 3 компани Онцгой албан татварын хуулиар энэ чинь сар болгон бараг 36 сая төлнө гээд 3 тэрбум төгрөг татвар төлөхөөс огт төлөөгүй л ингээд яваад байгаа байхгүй юу. Одоо угаасаа л ийм байгаа. Тэр хориглосон ч, хориглож байж энэ үйлдэл бол бодитой болно.

Хоёрт, гаднаас яг тэр 1xBet дээр 500 гарчихсан бол орж ирж байгаа 3.3 тэрбум төгрөг л орж ирсэн юм байна лээ. Өөр 3.3 тэрбум төгрөг л орж ирсэн өөрөөр орж ирсэн тийм урсгал байхгүй. Тэгээд энийг Монголбанкнаас бас нэмж хариулж болох байх.

Д.Амарбаясгалан: Монголбанкны Дэд ерөнхийлөгч Энхтайван хариулт өгье. Ажлын хэсгийн 9 дүгээр микрофон.

Г.Энхтайван: Асуултад тодруулъя. 2021-24 онд гадаад гүйлгээний тайлангийн мэдээллээс харахад Монгол Улсын эдийн засгийн харьяат болон харьяат улсын хооронд хийгдсэн крипто валютын гүйлгээг тодруулахад цэвэр дүнгээр 21 онд 120 сая ам.доллар, 22 онд 198 сая доллар, 23 онд 430 сая доллар, 24 онд 578 сая доллар буюу энэ өнгөрсөн 4 жилийн хугацаанд нийт тэгээд 1.3 тэрбум долларыг гадагшаа шилжүүлсэн байгаад байгаа юм. Дотогшоо хожоод орж ирж байна уу гээд Их Хурлын дарга асууж байна. Энэ ерөөсөө хожоод орж ирдэггүй.

Яагаад гэхээр тухайн тоглогч маань өөрөө ямар нэгэн хэлбэрээр хожоод дансандаа мөнгөө авсан, 1 удаагийн тоглолтоор хожоод мөнгөө авсан боловч тэрийгээ дараагийн тоглолт дээрээ хэрэглээд л буцаагаад л алдчихдаг буюу Монголд буцааж мөнгөө оруулж ирээд кайш/cash/ хэлбэрээр буцаагаад гаргаж ерөөсөө авдаггүй. Тайлан дээр ерөөсөө ийм буцаж хожиж орж ирсэн тийм мөнгөний.../минут дуусав./

Д.Амарбаясгалан Тэгээд энэнтэй холбоотой. Ер нь энэ хэлэлцүүлгийн шатад Монголбанкнаас айхтар нууцлалын зэрэггүй зүйлүүд байдаг бол гишүүдэд бас дэлгэрэнгүй мэдээлэл өгөөрэй. Ганцхан энэ хариултаар бас нэг талыг нь сонсоод явахад бол бас өрөөсгөл байх.

Яагаад гэхээр бас Улсын Их Хурлын гишүүд энэ өргөн баригдсан хуулийн төсөл, хамт өргөн мэдүүлсэн төслүүдтэй холбоотойгоор хууль зүйн энэ техник талаасаа бас асуудлууд яриад байгаа юмнууд байгаа. Тэгээд түрүүн Бат-Эрдэнэ гишүүний хэлээд байгаа нэг бол болно, нэг бол болохгүй гээд шууд ингээд яваад байгаа байдалтай ч холбож хүмүүс бас их юм яриад байна лээ. Тэгэхээр энэ нэлээн хэлэлцүүлэг өрнөх шинжтэй юм байна лээ.

Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн дахин тодруулж асууя.

Б.Бат-Эрдэнэ: Монголбанкныхан маань л хариулаад өгчихмөөр байна л даа. Одоо энэ чинь санхүүгийн зах зээлтэй холбоотой асуудал яригдаад байгаа байхгүй юу. Ганцхан мөрийтэй тоглоомтой холбоотой асуудал яригдаагүй гэж ойлгож байгаа. Тэгэхээр санхүүгийн зах зээлтэй холбоотой асуудлуудыг яригдаж байхад энэ өөрөө хэдий хэмжээний зах зээл юм, хэдий хэмжээний энэ зах зээлийн хууль ёсны гэж та нарын яриад байгаа чинь хэдэн хувь нь юм, хэдэн хувь нь хууль бус юм? Хориглогдсоноор нөгөө тэмдэглэгдээгүй, бүртгэгдээгүй байгаа зах зээл чинь хэдий хэмжээгээр өргөжих гээд байгаа юм? Та хэд сая өөрсдөө хэлчихлээ шүү дээ. Кripto валютаар хэдий хэмжээний урсгал явж байгааг бид нар мэдэхгүй. Койноор хэдий хэмжээг бид нар хянах боломж байхгүй гээд байгаа байхгүй юу. Гарсан нь тодорхойгүй. Тэр мөрийтэй тоглоомоос орж ирж байгаа мөнгө чинь магадгүй буцаад гарахдаа, эсвэл тэр койны зах зээл рүү хэдий хэмжээ нь орж байгаа вэ гэдгийг та нар тодорхойлсон бол тэр нь ийм юм гээд тодорхойлолтоо хэлчихмээр байгаа байхгүй юу. Та хэд ганцхан мөрийтэй тоглоом гэхээс илүүтэй санхүүгийн зах зээлийн нэг хэсэгтэй холбоотой асуудлуудыг яриад байгаа учраас та хэдийн гараад байгааг ойлгоод.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Энхтайван Дэд ерөнхийлөгч хариулт өгье.

Г.Энхтайван: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Хэдий хэмжээний зах зээл орж байгаа юм бэ, kripto валютаар бас мөнгө шилжээд байгааг та нар барьж чадахгүй байна гэж байгаа. Энэ арилжааны банкны энэ гадаад гүйлгээний тайлан гэдэг маань зөвхөн арилжааны банкаар буюу kripto валют нь өөрөө мөнгөн тэмдэгт рүү, төлбөрийн хэрэгсэл рүү шилжиж хөрвөөд явж байгаа тайланг нь энэ дээр гарч байгаа. Түүнээс биш kripto валют, kripto валют хоёрын хооронд хоорондоо шилжиж байгаа дээр ямар ч энэ дээр баримт, гүйлгээний баримт энэ тэр гарахгүй. Энийг дэлхий дээр хаана ч гаргаж чадахгүй.

Гэхдээ крипто валют чинь өөрөө төлбөрийн хэрэгсэл биш учраас ямар нэгэн хэлбэрээр аль нэгэн улсын валют руу хөрвөж байж л энэ нь өөрөө хөрвөх, худалдан авах чадвартай болно. Тэгэхээр крипто валют нь өөрөө төлбөрийн хэрэгсэл биш учраас энийг крипто валютаас крипто валют руу шилжүүллээ гээд манай валютын нөөцтэй холбоотой, гарч байгаа урсгалтай холбоотой ямар нэгэн зүйлс ерөөсөө гарахгүй энэ дээр.

Д.Амарбаясгалан: Болсон уу? Ер нь тэгээд энэ асуудал чинь их олон жил яригдсан асуудал шүү дээ. Энэ крипто валюттай холбоотой, койнтой холбоотой, өнөөдөр энэ цахим мөрийтэй тоглоомтой холбоотой асуудал яригдаад байгаа. Тэгээд л зохицуулалтыг хийж чадахгүй явсаар байгаад л нэлээн том хэмжээний валютын нөөц дээр хохирол учрууллаа гэдэг зүйл гарч ирж байж өнөөдөр энэ асуудал албан ёсоор яригдаж эхэлж байх шиг байгаа юм. Тэгээд энэ дээр нэлээн нарийвчлаад сайн ярих хэрэгтэй.

Гишүүдийг бас энэ асууж, сонирхож байгаа олон асуудал дээр нь нарийвчилсан хариултуудыг мэдээллийг Монголбанкны зүгээс бас сайн өгөх хэрэгтэй шүү Энхтайван Ерөнхийлөгч өө. Гишүүд угаасаа анхан шатын мэдээлэл энэ тал дээр хомс байгаад байгаа шүү дээ. Гадна талд зохицуулалт хийж байгаа байдлыг ч гэсэн бас харьцуулалт хийх хэрэгтэй. Хэчнээн улс орон энийг ингэж хориглолт хийж байгаа юм, хэчнээн улс орон зохицуулалтыг хийгээд байгаа юм, хэчнээн улс орон нээлттэй байгаад байгаа юм гэх мэт энэ олон талын харьцуулсан судалгаа, мэдээллийг өргөн хүрээгээр өгч байж асуудал шийднэ шүү. Бидний нэг сул тал чинь бүрэн дүүрэн судалгаа хийж чадаагүй байж байж болно, болохгүй гэдэг шийдвэрийг гаргаад л хааж, боогоод л хориглоод л хаячихдаг. Эргээд л дагасан асуудал үүсэж байдаг. Тийм, тэгэхээр энэ дээрээ их сайн ярина гэдгийг бас хэлье.

Ингээд үдээс өмнөх чуулганы нэгдсэн хуралдаан өндөрлөлөө. Үдээс хойших чуулганы хуралдаан 15 цагт эхэлнэ. Даргын дэргэдэх зөвлөл хуралдаж ирэх долоо хоногт хэлэлцэх асуудал болон хэд хэдэн Засгийн газраас болон Улсын Их Хурлын гишүүдээс өргөн мэдүүлэх гэж байгаа хуулийн төслүүдийн үзэл баримтлалын талаар ярилцана. 13.30-аас Даргын дэргэдэх зөвлөл хуралдана. 15 цагаас.

12.30 цаг

Баасан гараг 04 Дөрөвдүгээр сар 2025

Төрийн ордон “Их хуралдай” танхим 15 цаг 00 минут

**ҮДЭЭС ХОЙШИХ НЭГДСЭН
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ**

Б.Пүрэвдорж: Монголынхоо ард түмний болон Улсын Их Хурлын гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Үдээс хойших хуралдаан эхэлж байна.

Гишүүд асуулт асууж байгаа. Одоо Улсын Их Хурлын гишүүн Батнайрамдал. Ажлын хэсгээ оруулаарай. Ажлын хэсэг орж байна уу? Учрал сайдыг дуудаарай. Нэлээн олон хүмүүс байсан биз дээ ажлын хэсэг?

Отгоншарын Батнайрамдал гишүүн асуулт асууя.

О.Батнайрамдал: Та бүхэндээ өдрийн мэнд хүргэе. Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах энэ хуулийг 100 хувь дэмжиж байгаа. Цахим мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа эрхлэх, энэ сурталчлан уриалахыг ер нь бид нар аль түрүүн л хориглочихсон байх ёстой байсан юм л даа. Энэ зөвхөн Монгол Улсад тулгамдаж байгаа асуудал биш юм. Яг манайх шиг ийм асуудалд тулгамдаж байгаа зөндөө олон орнууд байгаа. Ер нь тулгамдсан орон болгоныхоо толгойны өвчинд л орчихсон явж байгаа. Өнөөдөр бид нар валютын урсгалаар их яриад байна л даа. Гарч байгаа урсгал, орж байгаа урсгал байгаа юм уу.

Ер нь эндээс бид нар ямар ашигтай бизнес хийх гэж байгаа биш. Яагаад гэх юм бол энэ цахим мөрийтэй тоглоом энэ өөрөө алгоритмаар манипуляц хийсэн платформ байхгүй юу. Нэг утгаараа энэ цахим мөрийтэй тоглоом өөрөө залилан, дээрээс нь бас оюутан, залуучуудын дунд энэ чинь өөрөө донтолт болдог. Энгийнээр ер нь үндэстэн дамнасан мөнгө угаалтын л хэрэг юм л даа. Тэгэхээр энийг төр гэж байдаг л юм бол яаралтай зохицуулалтаа хийх ёстой. Түрүүн тоонууд дурдагдаад л байна л даа. Энэ сүүлийн 5 жилийн хугацаанд 1.3 тэрбум доллар валютын урсгал гадагшаа явлаа гээд. Гэхдээ 1.3 тэрбум доллар гадагшийгаа урсаж байгаа валют болгон чинь хэн нэгэн айлын өр болж үлдээд байгаа байхгүй юу. Энэ чинь бэлэн мөнгөтэйдөө, илүүдэл мөнгөтэйдөө тоглож байгаа 1 ч хүн байхгүй шүү дээ. Дандаа хэн нэгнээс зээл авч, байраа барьцаанд тавьж, тэр битгий хэл сургалтын төлбөрөөрөө тоглосон оюутнууд хүртэл зөндөө байгаа шүү.

Тэгэхээр тэр олон 10 мянган айлын, амьдралын санхүүгийн хувьд сүйрэл авчирч байгаа залилан шүү дээ ер нь. Тэгэхээр энэ тоон дүнг нь аваад үзэх юм бол энэ чинь 2024 онд 578 сая доллар гэж байгаа юм. Тэгэхээр 2024 онд 578 сая доллар айл өрхийн нэмэлт өр болоод л үлдэж байна гэсэн үг байхгүй юу. Тэр айл өрхийг бид нар яах юм. Олон мянган залуучууд энд бас донтоод үлдэж байгаа юм. Энэ өөрөө алгоритмаар манипуляц хийгээд маш өндөр ашиг хийдэг залилангийн л бизнес шүү дээ. Хохирогчдыг нь аваад үзэхээр дийлэнх нь 18-30 насны залуучууд байгаа. Дөнгөж амьдралаа эхэлж ядаж яваа залуучуудыг буруу зам руу л түлхэж байгаа бизнес байхгүй юу. Тэгэхээр энэ дээр бид нар яаралтай зохицуулалт хийх ёстой. Алдаж байгаа мөч хором болгон хэн нэгэн айлын өр болж л үлдэх, хэн нэгэн айлын салалт, хэн нэгэн айлын хэрүүл болж үлдээд л байгаа юм л даа.

Ер нь буцаад донтолттой тэмцэнэ гэдэг буцаад өөрөө энэ чинь маш том асуудал. Сэтгэл зүйн маш том асуудал болно. Ганцхан энэ хуулийг бид нар баталлаа гээд асуудал тэр чигээрээ шийдэгдчихгүй. Цаана нь үлдэж байгаа үр дагавартай бид нар хэрхэн тэмцэх вэ? Буцаад энэ оюутан, залуусын дунд ч гэсэн санхүүгийн боловсролын асуудал бас яригдана. Тэгэхээр иймэрхүү төрлийн шинэ гарч ирж байгаа гэмт хэргүүд, шинэ гарч ирж байгаа донтолт, залилангуудтай бид нар ер нь цаашдаа хэрхэн тэмцэх вэ? Тэгэхээр энийг бид нар ардаас нь хөөцөлдөөдөх биш, дараа нь илүү урдаас нь төлөвлөж бусад орны жишгийг яаралтай оруулж ирж, энэ чинь зөндөө олон орон хууль дээрээ хориглоод арга

хэмжээ авчихсан байгаа юм л даа. Тэгэхээр ардаас нь хөөцөлдөж биш бид нар болж өгвөл урдаас төлөвлөж, урьдчилан харж арга хэм.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Учрал сайд хариулья.

Н.Учрал: Тийм. Батнайрамдал гишүүн их олон талаас нь бас их зөв зүйлийг хөндөж байна. Энэ нэг талаасаа бас эдийн засгийн аюулгүй байдлын асуудал, нөгөө талаасаа бол хүн амын эрүүл мэнд, хүний эрхийн бас томоохон зөрчил. Ази Номхон далайн бүс нутгуудын 46 улс дээр бид нар судалгаа хийж үзсэн. Энэ 46 улсаас 21 улс энэ цахим мөрийтэй тоглоомыг ч тэр, бооцоот тоглоомыг ч тэр, төлбөрт тааврыг ч тэр хуулиар хориглодог. Ингээд хуулиар хориглоод эхлэхээр хууль хяналтын байгууллагууд, харилцаа холбооны салбар, технологийн компаниуд, гүйцэтгэх засаглал нь ч тэр хамтарч ажиллах бололцоо бол бүрддэг, хурдан шуурхай арга хэмжээ авах бололцоо бүрддэг. Ингэснээр мэдээж энэ цахим мөрийтэй тоглоомын нийгэмд үзүүлж байгаа хор хохирол багасдаг.

Тэгэхээр энэ хууль гарлаа гээд 100 хувь бүрэн шийдэгдэхгүй хэдий ч ажиллах бололцоо бүрдэнэ. Тэр хууль хяналтын байгууллагынхан 65 хувиар шууд бууруулах бололцоо бий гэдгийг бол илэрхийлсэн. Энэ 46 улсаас 7 л хуулиар зөвшөөрдөг юм байна лээ. 7. 6 орон хэсэгчлэн зохицуулалтуудыг хийсэн, 13 нь бол огт зохицуулалтгүй үлдээчихсэн байгаа.

Тийм ч учраас бид энэ Ази Номхон далайн бүс нутгууд, Япон, Солонгос, Хятад, Тайланд, Вьетнам, Индонез, Непал, Лаос, Бангладеш, Индонез гээд энэ улсуудын жишгээр ер нь цахим мөрийтэй тоглоомыг бүхэлд нь хориглоё гэдэг ийм л Засгийн газар нэгдсэн байр суурьтай байгаа. Хуулиар хориглосноороо өөрөө хариуцлага нэмэгдэнэ. Энэ Эрүүгийн хууль, Зөрчлийн хуулиар бол хариуцлага нэмэгдээд эхэлж байгаа.

Тийм ч учраас энэ хууль гарсны дараа нэгэнт цахим мөрийтэй тоглоом, бооцоот тоглоом хориглогдчихсон учраас олон улсын гаднын апп стор/app store/, плэй стор/play store/, гүүгл/google/-ийн аппликэйшн татдаг стор/store/-ууд бүхлээрээ хуулиар хоригдчихсон учраас манай харилцаа холбооны салбар бол энэ төрлийн үйл ажиллагааг манайх хориглосон гэдэг хууль, эрх зүйн орчноо тухайн гаднын байгууллагууд руу илгээснээр тухайн байгууллага манай дотоодын хууль тогтоомжийн дагуу Апп стор/app store/-оос ороод 1xBet шиг ийм цахим мөрийтэй тоглоомын хэв шинжийг агуулдаг бүх төрлийн аппликэйшнүүдийг манай байршил дээр татахыг бүрэн хориглоно гэсэн үг. Тэгэхээр маш том бас дэвшил бол хуулиар хориглосноороо гарна гэдгийг бас хэлье.

Б.Пүрэвдорж: Отгоншарын Батнайрамдал гишүүн нэмж асууя.

О.Батнайрамдал: Тэгэхээр өнөөдөр бид нар бүгдээрээ гар утсандаа бараг дунджаар зарим тохиолдолд 7, 8 цаг зарж байгаа. Тэгэхээр энэ тоглоомын бас асуудал нь 24/7 шөнө ч гэсэн ороход дандаа дэлгэцэн дээр нь байж байдаг. Тэгэхээр ер нь энэ цахим цаашаагаа энэ технологи хөгжих тусам бид нарт нэг ёсондоо шинэ эрсдэлүүд гарах л байхгүй юу. Энэ цахим мөрийтэй тоглоом яг тэдний шүү дээ. Тэгэхээр өнөөдөр бид нарт дараа нь буцаад Монгол Улсын Засгийн газраас авах арга хэмжээний хувьд ч гэсэн бүх юм тодорхой биш байж болно.

Гэхдээ зарчмын хувьд, арга хэмжээнүүдээ аваад л явах ёстой юм. Тэгэхээр аль болох л хоцорч биш, урьдчилан харж бусад орны жишгийг яаралтай судлаад л арга хэмжээ бас авч явах ёстой гэдгийг дахин хэлмээр байгаа юм.

Б.Пүрэвдорж: Үг хэллээ. Одоо Сандагийн Бямбацогт гишүүн асуулт асууна.

С.Бямбацогт: Бас иргэдийнхээ мэдэх эрхийг хангах үүднээс асууж байгаа юм шүү. Тэгэхээр энэ төлбөрт таавар, мөрийтэй, цахим, мөрийтэй тоглоом энийг Засгийн газраас өргөн барьж байгаа, хориглож хязгаарлаж байгаа. Тэгээд яах аргагүй ингэх цаг нь болсон, анхаарах ёстой асуудал болсон.

Сая ярилаа 1.3 тэрбум доллар буюу монгол төгрөгөөр 4.5 их наяд төгрөг сүүлийн 5 жилд гараад явчихсан байна гэж. Энийг энгийн хэллэгээр тооцоод үзэх юм бол приус машиныг 30 сая төгрөгийн үнэтэй гэж үзэх юм бол 150 мянган приус машинтай тэнцэх хэмжээний мөнгө гадагшаа гараад явчихжээ. 150 мянган айл өрх 150 мянган машингүй болчихжээ. Тэр айлын чинь гэрийн эзэн тэр айлын чинь ер нь голцуу эрчүүд л тоглож байгаа шүү дээ. Өрөнд орж байгаа тэгээд. Жилдээ аваад үзэх юм бол жилдээ 500 сая доллар. 24 онд 500 сая доллар гарсан гэж байна. Энэ 500 сая доллар чинь бас 50 мянган приус машин. Орон сууцаар аваад үзэх юм бол 100 сая төгрөгийн үнэтэй, орон сууцаар үзэх юм бол 45 мянган айлын орон сууц, 45 мянган айл орон гэргүй болж байна. 150 мянган айл машингүй болж байна, амьжиргааны эх үүсвэргүй болж байна. Ийм л ноцтой үр дагавартай асуудал болчихоод байгаа учраас энийг хориглоод, хязгаарлах нь зөв.

Гэхдээ энэ дээр бас нэг асуудал байгаад байгаа юм. Одоо бид нар нөгөө и спорт гэж и спортоор Монголын залуучууд хүүхдүүд бас үнэхээр дэлхийд алдартай болсон. Дэлхийд эхний 3, 4-д эрэмбэлэгддэг ийм баг, тамирчидтай болсон. Мөн бас Ази тивдээ тэргүүлдэг болсон байж байгаа манай Монгол хүүхдүүд маань, Монгол залуучууд маань. Гэтэл энэ и спортоор хичээллэх, энэ спортоор хичээллэхдээ Монгол Улсын Засгийн газраас тодорхой бодлого авч хэрэгжүүлсэн, үр дүн гарсан. Багийн спорт, волейбол, сагс, дээрээс нь олимпын төрлийн спортуудад хувийн хэвшлийнхэн, баялаг бүтээгч, татвар төлөгчид маань маш их хэмжээгээр хөрөнгө зарцуулдаг болж байна. И спорт ч үүнтэй адилхан зарцуулж байгаа.

Тэгвэл и спортод энэ контор страйк/counter strike/ тоглоод дэлхийд тэргүүлж байгаа, нөгөө пабжи/PUBG/ тоглоод тэргүүлж байгаа энэ багуудыг дэмждэг улсууд нь бас яг энэ цахим мөрийтэй тоглоом эрхэлдэг компаниуд байх шиг байгаа юм. Тэгтэл нэг талд нь энэ компаниуд маань и спортыг яаж цааш нь дэмжих бодлого барих вэ? Энэ дээр бас бодож зохицуулах боломж юу байдаг юм бол? Энийг хариулж өгөөч. Монгол залуучууд маань өнөөдөр ингээд тодорхой хүчин чармайлт гаргаад, тодорхой дэмжлэг аваад дэлхийд и спортоо тэргүүлдэг болчихлоо. Энэ хүрсэн түвшнийг унагамааргүй байна. Энийг хариулж өгөөч.

Хоёрдугаарт нь Зөвшөөрлийн тухай хууль гээд Учрал сайд хариуцаж байгаа. 2022 онд нэр бүхий гишүүдийн хамт Зөвшөөрлийн тухай хуулийг батлуулсан. 1600 тусгай зөвшөөрөл байдаг байсныг 360 болгож 5 дахин бууруулсан. Энэ тусгай зөвшөөрөл болгон цаад талд нь ерөөсөө л хүнд суртал, шан харамж, авлигал байдаг байсан. Зөвшөөрснөөс бусад нь чөлөөтэй байх

ёстой, зөвшөөрөөгүй бусад нь ийм үзэл баримтлал байх ёстой байтал зөвшөөрөлтэйгөөс бусад нь хориотой гэдэг ийм үзэл баримтлалаар олон жил хандаж ирсэн. Ерөөсөө л тусгай зөвшөөрөл маш хүнд сурталтай, зөвшөөрөл авахгүй бол үйл ажиллагаа явуулж болдоггүй, зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж болдоггүй. Тэгвэл үүнийг цэгцэлсэн, үндсэндээ зөвшөөрлийг маш цөөхөн өгье, хүнд сурталгүй болгоё гээд Зөвшөөрлийн тухай хууль баталсан. Харамсалтай нь өнөөдөр тусгай зөвшөөрлийн тоо дахин нэмэгдэж байна. Хуулиас давсан журмаар бас 250 төрлийн тусгай зөвшөөрлийн 122 нь хуулиас давсан журмаар зохицуулагдаж байна.

Бүртгэл нэрийн доор зөвшөөрөл олгодог, зүгээр бүртгэж байгаа нэртэй тусгай зөвшөөрөл өгдөг, нөгөө гарын үсгээ үнэлдэг ийм асуудлуудыг хэрхэн яаж шийдвэрлэх вэ? Энэ яах аргагүй энэ хүнд суртал, шан харамж, авлигал үүний цаана гарын үсгийн цаад талд яваад байгаа. Тэгээд гарын үсгийг яаж үнэ цэнгүй болгох вэ? Яаж хурдан шуурхай, хууль зөрчихгүй хурдан өгдөг болгох вэ? Энэ зөвшөөрлийг үнэлдгийг хэрхэн бас цааш нь дахиж ямар арга хэмжээ авах вэ?

Б.Пүрэвдорж: Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Зөвшөөрлийн хууль өнгөрсөн парламентын яг энэ регуляторын реформ хийхэд маш том дэвшил авчирсан хууль. 360 зөвшөөрөл болчихсон байсан. Тэгэхэд 2 жил хүрэхгүй хугацаанд салбарын хуулиудыг дагалдуулж зөвшөөрлийг нэмсээр байгаад 18 зөвшөөрөл шинээр нэмэгдсэн байна лээ. Дээрээс нь Зөвшөөрлийн хуулийн концепцыг алдагдуулсан эрх олгосон олон журмууд. Ингээд бид өнгөрсөн хугацаанд өнөөдрийн байдлаар 60 гаруй журам хүчингүй болголоо. Зөвшөөрлийн хуулийг нэг мөр хэрэглэх ёстой. Зөвшөөрлийн хуулийн хугацааг эрх олгосон журмаар сунгаж болохгүй. Дээрээс нь Зөвшөөрлийн хуулийг дагалдуулж эрх олгосон журмаар шаардлагуудыг үүсгэж болохгүй гэдэг ийм л концепцтой.

Гэтэл Зөвшөөрлийн хуулийг давж гарсан олон журам байсныг цуцалсандаа өнөөдөр салбаруудад хуулийнхаа хугацаанд зөвшөөрөл олгогдож байгаа. Үүний бараг 60 орчим хувийг нь цахимаар буюу зөвхөн хүсэлт авах биш автоматаар хариулдаг, шийдвэр нь гардаг, хүн оролцоогүй болох ажлууд хийгдээд явж байна.

Дээрээс энэ хаврын чуулганаар Засгийн газрын зүгээс Зөвшөөрлийн хуулийг Зөвшөөрөл мэдэгдлийн хууль гэдэг шинэ концепцтойгоор оруулж ирж, 80 гаруй хуульд өөрчлөлт оруулж, эрх олгосон журмуудыг хүчингүй болгоно. Ингэснээрээ зөвшөөрөл хүнд сурталгүй болгох ажлууд хийгдэнэ. Энэ удаа яагаад бид нар Зөвшөөрлийн хуулийг хөндөөд энэ цахим мөрийтэй тоглоом, бооцоот тоглоом, төлбөрт тааврын үйл ажиллагааг хориглож байна вэ гэхээр тухайн үед Зөвшөөрлийн хуулийг баталж байхад бооцоот тоглоом, төлбөрт тааврыг зөвшөөрөлтэй болгоод энэ хуульд оруулснаараа Монгол Улс бооцоот тоглоомыг зөвшөөрсөн байхгүй юу агуулгаар.

Гэтэл Зөвшөөрлийн хууль дээр байгаа энэ бооцоот тоглоом, төлбөрт тааврыг хэрвээ зүгээр шууд энэ Зөвшөөрлийн хуулиас аваад хаячихвал ямар асуудал үүсэх гээд байна вэ гэхээр Зөвшөөрлийн хуулийн концепц нь энэ хууль бичигдээгүй л бол зөвшөөрөгдөнө гэсэн концепц. Тэгэхээр төлбөрт таавар, бооцоот тоглоомыг аваад орхичихвол төлбөрт таавар, бооцоот тоглоомыг

зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа эрхлэхийг нь зөвшөөрч байгаа гэдэг ийм хэлбэр, ойлголт бий болно.

Тийм учраас энэ заалтыг аваад хориглох заалтыг Зөвшөөрлийн хуульд нь бичиж байж Эрүү, Зөрчлийн хууль дээр бид нар хариуцлагыг тооцож байгаа юм. Тэгэхгүйгээр өөр хууль дээр энэ бичигдэхгүйгээр хариуцлага нэмэгдүүлэх Хууль тогтоомжийн хуульд заасны өөр боломж байхгүй. Тийм учраас энэ хууль гарснаар ийм өөрчлөлт гарна.

Хоёрт, Зөвшөөрлийн хууль дээр бид нар ашиг олох зорилгоор цахим мөрийтэй тоглоом, бооцоот тоглоом, төлбөрт тааврыг хориглож байгаа. Тэрнээс биш тэр спортынхоо зарчмаар хөгжиж байгаа и спортод энэ төдийлөн хамааралтай биш, ашиг олох зорилго бол байхгүй. Тийм учраас и спорт болоод энэ цахим спортыг бол Засгийн газар бол мэдээж дэмжээд явна.

Б.Пүрэвдорж: Би доор сууж байгаад суудал дээрээсээ асуулт асууна. Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууя.

П.Сайнзориг: Баярлалаа. Энэ хуулийн төслийг хэлэлцэхийг зарчмын хувьд дэмжиж байна. Бас энэ ер нь мөрийтэй тоглоомын асуудал нэлээн асуудал үүсэж байгаа сөрөг үр дагаврууд их авчирч байгаа. Тэгэхдээ бид хэд бас энэ олон нийтэд зөв мэдээлэл өгмөөр байна. Энэ нөгөө спорт бэтинг/betting/ гэхээсээ илүүтэйгээр спорт бэт/bet/-ийн хууль бус сайт ажиллуулдаг нөхдүүд дамжуулж линк байршуулах замаар цахим казинод оруулж төвлүүлээд байгаа байхгүй юу. Ерөөсөө л тэр.

Тэгэхээр өнөөдөр энэ 500-гаад сая доллар гадагшаа гарсан гээд байгаа боловч 60 орчим сая нь спорт бэт/bet/-тэй холбоотой, 430-аад сая доллар нь цахим казино руу орсон гэдэг сураг байгаад байгаа юм. Тэгэхээр энэ хуулиар энэ сөрөг үр дагавартай зүйлүүдийг цахим мөрийтэй тоглоомын асуудлыг бүрэн хориглолоо гээд хэлж байгаа. Шийдэх бололцоотой эсэхийг хуулийн төсөл санаачилж байгаа хүмүүс маань хэлээ. Энэ хуулийг батлаад өглөө гэж бодоход энэ сөрөг үр дагавар яг 100 хувь зогсох уу? 100 хувь зогсохгүй бол дараа нь ямар хэн хариуцлагыг нь хүлээх вэ гэдэг зүйлийг бас тодорхой хэлж өгөөч. Энэ Ви Фи Эн ч гэдэг юм уу, Ай Пи Ай-гийн өөрчлөлтүүд ороод ирдэг бүгд олон улсын банкны карт аваад улам гадагшийгаа мөнгө чинь урсах юм биш биз дээ? Ийм зүйлүүд дээр яг энэ хууль бүрэн хаалт болж чадах уу? Энийг бас тодорхой хэлж өгөөч.

Харин бусдаар тэр яг энэ эжент/agent/-ээр ажиллаж байгаа хүмүүс буюу зуучлах, утасны дугаараа ашиглуулах, дансны дугаараа ашиглуулах энэ зүйлүүд дээр хариуцлагын асуудлыг оруулж ирж байгааг дэмжиж байна. Учрал сайд ч гэсэн энийг бас байнга ярьж байгаа бас зөв байх гэж бодож байгаа. Энийг дэмжиж байгаа гэдэг зүйлийг хэлмээр байна.

Хоёрдугаарт тэр спортын эдийн засаг гэж байдаг. Сая Бямбацогт гишүүн бас и спортын асуудал ярьж байна. Тэгээд өнөөдөр бас Монголд ч гэсэн бас олон төрлөөр энэ спортыг зөв хөгжүүлэх бололцоо байна. Тэгэхээр энэ хуулийн Зөвшөөрлийн хуулийг баталсан тохиолдолд энэ бооцоот морин уралдааны асуудал зөвшөөрөгдөх үү, эсвэл зөвшөөрөгдөхгүй гэж үзэж байгаа юу? Зарим залуучууд чинь хөрөнгө оруулалтаа гаргаад морин тойруулга бариад байдаг. Бид

хэд энд зөрүүлээд хөрөнгө оруулалтыг нь байхгүй болгох хууль баталж байгаа юм биш биз дээ? Энэ яг хууль санаачлагч бас хариулж өгөөч. Бооцоот морин уралдааныг зохион байгуулж болох уу? Эсвэл үнэхээр хориглож байгаа бол энэ хуулийн үйлчлэлд хамгийн их түрүүлж өртөх нь манай уяачид л болж таарч байна л даа. Бооцоо тавиад жоохон уралддаг. Бүгд л янз бүрийн байдлаар хууль хяналтын байгууллагад шалгагдаад явах вий дээ гэдэг ийм болгоомжлол байх юм.

Тэгээд энэ эжент/agent/ гээд байгаа 100 гаруй хүмүүс байдаг гээд сая Учрал сайдын бас танилцуулгад явж байна. Энэ эжент/agent/-үүд ерөнхийдөө явсаар байгаад 2, 3-хан хүн дээр очиж байна гэсэн. 2, 3 хуулийн этгээд дээр. Энэ хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч нь ямар хүмүүс байдаг юм бэ? Энийг зарлаж болохгүй юу? Ямар хүмүүс энэ үйл ажиллагааны яг ард нь бат ингэж зогсчихоод ийм зүйлүүдийг хийгээд байдаг юм бэ? Тэгэхээр энэ эцсийн өмчлөгчдийг Учрал сайд энийг хэлж болох байдаг бас хэлээд өгөөч гэдэг зүйлийг бас хэлмээр байгаа юм.

Тэгээд энэ хонжворт сугалааны асуудлыг уг нь бас цэгцэлье гээд, энэ спорт бооцоот тааврын асуудлыг цэгцэлье гээд миний бие уг нь хуулийн төсөл боловсруулж байгаа юм бооцоот морин уралдаан. Тэгэхээр энэ хууль гараад явах юм бол бас энэ хуулиудыг өргөн барих хэрэгцээ шаардлага байна уу гээд бас би жоохон эргэлзээд байгаа. Тэгэхээр ер нь зүгээр энэ хуулийг гарсны дагуу спорт бэт/bet/-ийг хориглож байгаа гэж ойлгож болох уу? Бооцоот морин уралдааныг явуулж болохгүй гэж бас ойлгож байна. Энэ бас зөв үү гэдэг зүйл дээр бас хариултуудыг бас та хэлээд өгөөч ээ. Аливаа зүйлийг хориглоод явж болно. Энийгээ бас бүрэн шийдчих бололцоог ингээд явж болж байна, бас дэмжиж байна.

Харин боломжгүй энэ тохиолдолд уг нь зөв зохицуулалтыг нь хийгээд илүү их хяналттай болох бололцоо байгаагүй юу? Энэ дээр ямар байр суурь байгаа юм? Заримдаа ч энэ асуудлыг уг нь Хууль зүй, дотоод хэргийн яам нь илүү аваад явж байсан ч үе бий. Өмнөх парламент дээр бас хуулийн төсөл өргөн баригдаад хэлэлцэж чадаагүй буцсан. Тэгээд тодорхой тохиол.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Сайнзориг гишүүний зарим асуултад хариулъя. Тэгэхээр ийм юм байгаа юм. Энэ хуулиар бол одоо байгаа зохицуулалттай асуудлыг нэмж зохицуулалтыг нь сайжруулах гээд байгаа зүйл биш.

Б.Пүрэвдорж: Учрал сайд сууж байгаарай.

Б.Жавхлан: Огт зохицуулалтгүй байгаа хууль бус гэж тодорхойлоход бас хэцүү. Хуулийн ямар ч зохицуулалт байхгүй. Тэгэхдээ энд асар их эдийн засаг эргэж байна, мөнгө эргэдэг болсон байна. Жилдээ энэ чинь 500-гаад сая доллар гэхээр 1.7 их наяд буюу бүтэн манай 1.4 сая хүүхдүүдийн маань мөнгийг жил бүр өгдөг төсвийн энэ мөнгөтэй тэнцэх хэмжээний хөрөнгө жил бүр доллар болоод гадагшлаад яваад байгаа юм. Ямар ч татвар байхгүй, ямар ч бүртгэл байхгүй бүүр нүдэн дээр ийм том урсгал бий болжээ.

Тийм учраас ямар ч байсан энэ өөрөө цаанаа тэр 1xBet гээд энэ платформ уг нь бол спортын бооцоот тоглоомын сайт гэж өөрсдийгөө ярьдаг гэсэн. Гэтэл ороод үзэхээр энэ ерөөсөө казино байгаа байхгүй юу. Ингээд манай дотоодын

зарим зөвшөөрөл авсан ийм сайт энэ платформуудыг ашиглаад тэрүүгээр дамжуулаад ингээд маш том сүлжээ үүсгэчихсэн энэ асар том ийм далд эдийн засаг эргэдэг болчихжээ. Энийг ямар ч байсан хуулиар маш тодорхой энэ зохицуулалтгүй ийм салбар шүү, энийг хориглож байна гэдгийг ингээд бид хуульчилна гэсэн үг.

Харин яригдаж байгаа энэ спорт, спортын эдийн засаг гарцаагүй бид өнөөдөр бас ярих ёстой асуудал. Тэгэхээр спортын холбоод маань энийг зөв ойлгох хэрэгтэй. Нээх бас спонсороо алдчихлаа гэж үзэж болохгүй. Энэ хууль ёсны урт хугацааны тогтвортой ийм эх үүсвэр, дэмжлэг бол энэ биш шүү биш. Олон ч спортын холбоонууд ийшээ татагдан орсон. Мэдэж орсон ч байгаа, мэдээгүй ч орсон байгаа, огт ороогүй ч холбоонууд байгаа. Тэгэхээр эндээс сайн дураараа татгалзахыг бас уриалж уриалж байна.

Харин нөгөө талдаа бид татварын зохицуулалтаар бид маш том боломжуудыг тавьж өгч байгаа. Эдийн засаг тэлэхийн хэрээр татвар төлөлтийн хэмжээ тэлэхийн хэрээр бид татварын зохицуулалт буюу нийт орлогын 1 хувиар нь хязгаарлаад татвар дээрээсээ шууд тодорхой салбарууд дээр ялангуяа спортын салбарууд дээр спорт, спортууд, олимпын төрлийн спортууд дээрээ маш том хөрөнгийн эх үүсвэр, боломжуудыг татварын зохицуулалтаар тавьж өгч байгаа. Энийг тодорхой компаниуд энэ жилийн эцсээр тайлан дээрээ эхнээсээ ирүүлсэн байна. Маш сайн ойлгож, ашиглаж, спорт руу хөрөнгө оруулалт, дэмжлэгүүд явж эхэлсэн байна гэх мэт ийм зөв, эрүүл ийм санхүүжилт бүхий боломжууд гарч ирж байгаа учраас энэ рүүгээ илүү их анхаараарай гэж захиж хэлье.

Тэр эцсийн өмчлөгч гэж хэлж асууж байна. Учрал сайд.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Жавхлан сайдад 1 минут нэмж өгье.

Б.Жавхлан: Учрал сайд ч бай, хэн ч бай энийг одоохондоо хэлэх боломжгүй л дээ. Энэ маань өөрөө ямар ч зохицуулалтгүй учраас бид юу юугүй энийг зарлах эрх зүйн ийм орчин байхгүй байна гэж үзээд энэ хуулийг гаргаж ирж байгаа. Энэ хуулийн бас санаачлагч болж бидний хувьд ингэж явж байгаа шүү.

Тийм учраас ямар ч байсан хуулийн тодорхойлолттой, хуулийн тодорхойлолт нь харин энэ төрлийн ийм казино ажиллуулж болохгүй шүү, энэ хууль бус шүү, үүгээр эргэлдэж байгаа энэ хөрөнгө, мөнгө бол цаашдаа хууль бус бөгөөд энийг өөр бусад Эрүүгийн хууль, бусад хуулиудаар ингээд хязгаарлана гэдгийг маш ойлгомжтой тодорхой болгочхож байна гэсэн үг.

Б.Пүрэвдорж: Сайнзориг гишүүн тодруулъя.

П.Сайнзориг: Жавхаа сайд аа би гол нь яах вэ ойлголоо. Энэ морин тойруулгын асуудал хориглоод байна уу, энд орчхоод байна уу, орохгүй байна уу гэдэг зүйлийг бас тодорхой хариулчхаач.

Дээрээс нь спортын асуудал дээр та бэт/bet/ нь гайгүй цаагуураа казинод ордог гэдгийг өөрөө бас сая тайлбараар хэллээ. Тэгээд энэ завсарт нь яагаад энэ спортын бэт/bet/ нь ингээд хамт чирэгдэж ороод хориглолтод орчхож байгаа юм

бэ? Сөрөг үр дагавар нь ерөөсөө тэнд линк байршуулаад цахим казино дахь покер, өөр казиногийн төрлийн тоглоом руу л орж байгаа асуудал шүү дээ.

Тэгэхээр энийг уг нь зохицуулаад уг нь явах, зөвхөн баг бол компанийн тэр дэмжлэгээс шалтгаалах биш. Уг нь энэ бас зөв зохион байгуулаад энийг дагаад спортын авлигалыг шийдэх ёстой, спортын үйл явдлуудыг манипуляц хийдэг, энэ нөлөөлдөг байдлуудыг нь зохицуулах ёстой юм. Тэрнээс биш уриалаад болиорой гэхээр бас больчихдог зүйл биш байх. Тэр дээр уг нь ийм л зүйлүүд байх юм. Тэгээд яг энэ миний 2, 3 асуултад тодорхой хариулаад өгчхөөч.

Хоёрдугаарт, төр хийх зохицуулалтаа ингээд банканд үүрүүлж байгаа нь бас буруу байна. Уг нь энэ дээр ядаж.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Тэр зөвшөөрөл бүхий спорт бэт/bet/-үүдийн сайтууд чинь ер нь энэ 2 чинь ингээд л 1 зоосны л 2 тал болчихоод байгаа юм. 1 зоосны л 2 тал. Ингээд шууд ерөөсөө ингээд ажлыг нь хийж өгдөг ийм ийм платформууд болчихсон байгаа учраас гарцаагүй энэ хуулиар бүгдээрээ л зогсохоос өөр арга байхгүй. Ялангуяа спортын энэ харамсалтай нь энэ бэт/bet/ тавьдаг зөвшөөрөл бүхий энэ нэгжүүд маань яг гарцаагүй хамгийн том цаана нь өөрөө зах зээл, ийм боломжууд байдаг энийг нь ашиглаад яах аргагүй ингээд гар, хөлөө болгочихсон байгаа учраас энийг 1 удаа ингэж зогсоолгохоос өөр арга байхгүй.

Харин дараа энийг яаж зөв голдирлоор нь яаж зөв эхлүүлэх вэ гэдэг дээр дараагийн алхам дараа юмаа бид харах хэрэгтэй бас зэрэгцээд. Ингэж бодож байгаа. Тэр морин спорт тэр шинээр яригдаж байгаа энэ асуудлууд ч гэсэн ер нь үүгээр хязгаарлагдана. Өөрөөр хэлбэл, тэр рүү яв.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Одоо болно. Бүр шал ондоо юм асуугаад яваад байна. Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн асуулт асууя.

Л.Соронзонболд: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. Ерөнхийдөө бид ниргэсэн хойно нь хашхирав гэдэг шиг л арга хэмжээ авч байгаа юм. Ер нь энийг бол дэмжиж байгаа.

Тэгэхээр энэ ер нь арилжааны банкнууд энэ сэжигтэй гүйлгээний дүрмээрээ ийм иймэрхүү гүйлгээг илрүүлээд Санхүүгийн мэдээллийн алба руу явуулдаг тэгээд цаашаагаа шалгадаг. Нөгөө энэ сэжигтэй гүйлгээ хийгээд байгаа улсууд маань болохоор арилжааны банкнуудыг ингээд тойроод л данс нээгээд ингээд хийгээд яваад байдаг. Тийм учраас энэ ажиллагааг нь зогсоохын тулд энэ хуулийн төслийг санаачилсан гэж ойлгож байгаа.

Гэхдээ хамгийн гол нь энэ сэжигтэй гүйлгээ хийгээд байгаа энэ улсуудыг эрсдэлтэй харилцагчийн жагсаалтад оруулаад, энийг нь бусад арилжааны банк, банк бус сангийн байгууллагууд мэдэгдээд ийм урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах талаар ер нь ямар ажил төлөвлөж байгаа юм бэ гэж нэгдүгээр асуулт.

Нөгөө талаасаа болохоор энэ олон улсын энэ аппликэйшнүүд чинь ихэнх л хүн олон улсын картын төлбөр тооцоонд холбоод л төлбөр тооцоогоо авчхаад

байгаа болов уу гэж би бодож байгаа. Тэгэхээр яг цаад талын тэр төлбөр хүлээж авч байгаа байгууллагынх нь эрсдэлийн түвшнээс хамааруулаад тодорхой хэмжээний хязгаарлалт хийх ийм бодлого байна уу? Хоёрдугаар асуулт.

Гуравдугаар асуулт болохоор юу байна вэ гэхээр энэ зөвхөн бид нар энэ юуг яриад байна бооцоот тоглоом, хонжворт таавар эд нар яриад байна л даа. Мөрийтэй тоглоом. Гэтэл энэ онлайн сошиалаар сугалаа маш их явуулж байна, телевизороор шууд ингээд сугалаа явуулж байна. Энэ бас л цаанаа олон хүнийг өрийн дарамтад оруулж байгаа, өрөнд оруулж л байгаа юм байна лээ. Тэгэхээр энэ асуудлыг ер нь ажлын хэсэг энэ хэрвээ хуулийн төсөл дэмжигдэх юм бол ажлын хэсэг дээр энэ талаар тусгахаар бодож байгаа зүйл байна уу?

Б.Пүрэвдорж: Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Одоо яг энэ 500 сая доллар бүртгэгдээд гаргачихсан байгаа энэ 1xBet-ийг хөхүүлэн дэмжигч дундаас нь 2-5 хувийн шимтгэл авдаг агентууд нэг ёсондоо энэ онлайн казино руу бусдыг уриалан дууддаг, дансаа ашиглуулдаг, харилцаа холбооны сүлжээний дугаар ашиглуулдаг, цахим хаягаа ашиглуулдаг, энэ дундаас нь ийм бизнес хийдэг ийм бүлэглэлүүд бий болчихлоо л доо. 1xBet өөрсдийгөө юу гэж тайлбарладаг вэ гэхээр бид нар казиногийн үйл ажиллагаа явуулаагүй бид нар спортын бооцоот тоглоомын сайт шүү дээ гэж нэрлэдэг өөрсдийгөө. Яг яваад орох юм бол энэ өөрөө зөвхөн спорт тоглоомын, спорт бооцоот тоглоомын сайт биш шүү. Энэ бол казино, энэ бол мөрийтэй.

Гэтэл яг нэр томъёоныхоо тайлбар дээр бооцоот тоглоом гэдэг үр дүнг нь урьдчилан таамаглаж болдгийг хэлдэг. Нэг ёсондоо хоёр баг тоглож байхад нэгэн дээр нь тавьсан мөнгө хэрвээ энэ тал нь хожих юм алдана. Хэдээр алдах нь ойлгомжтой. Мөрий гэдэг эрсдэлийг урьдчилан тооцож болдоггүй үүгээрээ ялгаатай. Гэтэл технологийн хувьд бол үүнийг ялгах бол үнэхээр хэцүү байгаа юм.

Тэгэхээр бид хэрвээ энийг үлдээвэл, бооцоот тоглоомыг хэрвээ үлдээчихвэл энэ мөрийтэй тоглоомын хэв шинжтэй үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагууд чинь өөрсдийгөө бид нар бооцоот тоглоомын л үйл ажиллагаа явуулж байгаа, бид нар мөрий биш шүү дээ гэж хэлнэ. Технологийн хувьд ч ялах бололцоо байхгүй, эрх зүйн хувьд ч энийг ялах бололцоо байхгүй байхгүй юу. Тэгэхээр эхний түвшинд бооцоот тоглоомыг ч тэр, төлбөрт тааврыг ч тэр, цахим мөрийтэй тоглоомыг ч тэр бүхэлд нь хориглоод шийдвэр гаргах хэрэгтэй. Ингэж байж арга хэмжээнүүд авсны дараа тэр Монголбанк дээр байгаа Санхүүгийн мэдээллийн албан дээр гарч байгаа урсгал дээр нь жишээ нь Хууль зүйн яам энэ хууль хяналтын байгууллагууд ажилладаг шүү дээ. Тэн дээр нь хязгаарлах, царцаах, хууль зөрчсөн үйл ажиллагаанд оролцож байгаа мөнгө төгрөг гадагшаа урсчихсан байвал хязгаарлаж иргэддээ учирч болзошгүй хохирлоос урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг авах зайлшгүй ийм шаардлага бол үүсдэг. Тийм учраас бүхэлд нь хориглоё гэдэг ийм шийдвэрийг гаргасан.

Сайнзориг гишүүн болон бусад гишүүдийн ярьж байгаа хуулиуд хэрвээ гараад үнэхээр тавигдах шаардлага, стандарт, тэр урьдчилан сэргийлэх ажлуудыг нь нарийвчлан хуульчлаад явбал цаг ирэхэд ийм хууль зөвхөн спорт төлбөрт таавар дээр ч юм уу, бооцоот тоглоом дээр ч юм уу гаргаад явахыг үгүйсгэхгүй. Өнөөдөр энэ цаг нь биш. Бид нар ажлын хэсэг байгуулаад арга хэмжээ авах гэсээр

байтал 2 сарын хугацаанд 87 сая доллар гарчихлаа шүү дээ. 2-хон сарын хугацаанд шүү дээ. Нэгээс өнөөдрийг хүртэл.

Тийм учраас хурдан арга хэмжээ аваад энэ төрийн байгууллагуудыг шахаж шаардаж та бүхэн ард иргэдээ хамгаал гэдэг ийм шаардлага тавихаас өөр гарц бол Засгийн газарт байгаагүй гэдгийг хэлье. Ажлын хэсгээс бас нэмж хариулах байх.

Б.Пүрэвдорж: 9 номер ажлын хэсэг хариулъя.

Г.Энхтайван: Соронзонболд гишүүний асуултад хариулъя. Гишүүн тэр гадаадын банкны төлбөрийн карт ашиглаад энэхүү арилжааг хийгээд байх юм биш үү гэдэг асуудлыг хөндөж байна. Ер нь одоо дан ганц гадаадынх гэлтгүй дотоодын арилжааны банкнаас гаргасан олон улсын эрхтэй картаар ч гэсэн гүйлгээ хийх нь нээлттэй байгаад байгаа юм. Яагаад гэхээр одоо энэ хууль дээр, Банкны тухай хууль дээр болон Зөвшөөрлийн тухай хууль дээр энэ төрлийн үйл ажиллагааг хориглосон ерөөсөө ямар ч тийм зохицуулалт байхгүй байгаад байгаа юм.

Ер нь цаашдаа арилжааны банкнууд ч тэр бусад санхүүгийн байгууллагууд ч тэр үйлчилгээ үзүүлэгч тэр хэрэглэгчийг таньж мэдэх үйл ажиллагаа явуулдаг. Бид хүнээ Кей Вай Си гэж нэрлэгддэг. Тэгээд ингээд тодорхой давтамжтайгаар яг энэ төрлийн бооцоот тоглоомын чиглэлийн гүйлгээг хэрвээ аль нэгэн төлбөр хүлээн авагч нь давтамжтайгаар хүлээж аваад байх юм бол. Мэдээж энэ хуулиар хориглогдсон үйл ажиллагаа учраас арилжааны банк дээр гадаад төлбөр тооцооны дээр нь бас хязгаарлалт аваад явах бүрэн бол.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Соронзонболд гишүүн нэмж тодруулъя.

Л.Соронзонболд: Би гол нь яриад бас эхлээд асууж байгаа нь сэжигтэй гүйлгээ хийгээд байгаа этгээдийг хар жагсаалтад оруулаад дараагийн банк дээр очоод ингээд данс нээгээд байна шүү дээ. Энэ үйл ажиллагааг зохих талаар юу хийж байгаа юм бэ гэж асуусан шүү дээ бас.

Б.Пүрэвдорж: 9 номер ажлын хэсэг.

Г.Энхтайван: Ер нь энэ сэжигтэй гүйлгээтэй холбоотой асуудлыг бид бүхэн араас нь хөөгөөд л явж байгаа. Одоо ингээд яг ингээд хараад явахаар тухайн яг энэ чиглэлийн гүйлгээ хийж байсан этгээд өмнө нь жишээлбэл Голомт банк дээр гүйлгээ хийж байсан бол яг банк дээр нь хяналт шалгалт ирээд яг юуны үйл ажиллагаа зогсонгуут яг нэрээ солиод дараагийн эжент/agent/-ээрээ дамжаад дараагийн банк дээрээ яваад л байгаа. Энэ бүгдийг ингээд л ингээд л араас нь өөрчлөөд л хянаад л явж байгаа.

Жишээлбэл, 2022 онд хамгийн их өндөр гүйлгээг Худалдаа хөгжлийн банк хийж байсан бол 24 онд огт хийгээгүй байгаа. Яг энэ чиглэлийн гүйлгээ гэх мэтчилэн. Энэ арилжааны банк дээр нь тавьж байгаа хэрэглэгчийг таньж мэдэж байгаа энэ үүрэг, функцүүдээ чангатгаад нөгөө талдаа төв банканд мэдээлж байгаа сэжигтэй мөнгөн гүйлгээнийхээ загвар дээр яг энэ чиглэлийн гүйлгээг ингээд давтамжтайгаар оруулаад ирэх үеэр энэ арилжааны банк тус бүр дээр маш багасаад явж байгаа.

Б.Пүрэвдорж: Соронзонболд гишүүн тодруулъя. 2 дахиа тодрууллаа шүү.

Л.Соронзонболд: Энэ миний түрүүн хэлээд байгаа нь дотоодын ч карт бай, олон улсын карт ч ялгаагүй л дээ. Төлбөр хүлээн авч байгаа тэр байгууллагынх нь өөрийг нь жишээлбэл иймэрхүү эрсдэлтэй түвшний үйл ажиллагаа хийж өгвөл тэрийг чинь кюзи каш ч гэдэг юм уу ийм ангиллууд байгаа шүү дээ. Тэр ангиллаар нь бид нар ингээд хязгаарлаад барих боломжтой юу?

Хоёрдугаарт болохоор энэ сэжигтэй гүйлгээ хийж байгаа хүнийх нь нэрсийн жагсаалтыг нь ингээд арилжааны банк, санхүүгийн байгууллагад өгчхөөч гээд байхгүй юу. Тэгэхгүй бол цагдаагийн байгууллага санхүүгийн мэдээлэл өөрсдөө шалгаад л илэрснийх нь дараагийнх нь бүүр гүйлгээ гараад явсных нь дараагаар дандаа шалгалтаа хийдэг. Араас нь хөөсөн юм хийгээд байхгүй юу. Тэгэхгүйгээр анхны Голомт банк дээр гүйлгээ гарсан л юм бол тэгээд л голомт дээр ийм гарсан, хүн ийм хүн байгаа шүү гээд л өгчихөд нөгөө банкнууд чинь эрсдэлтэй харилцаж байгаа жагсаалтад оруулаад хязгаарлах юмаа хийгээд эхэлнэ шүү дээ гээд байхгүй юу. Би тэр талын юманд их хоцрогдсон байдаг юм байна даа л гэж хараад байгаа юм. Үг хэлсэн шүү.

Б.Пүрэвдорж: Ер нь энэ чинь миний ойлгосноор энэ гүйлгээг шууд харах боломжийг цагдаагийн байгууллагад олгож байх шиг байна. Тэгэхээр энэ чинь хувь хүний нууцтай холбоотой асуудал байгаа. Прокурорын зөвшөөрөлтэй байх ёстой. Тэгэхээр энэ асуудлыг шууд Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцээд хувь хүний эрх, эрх чөлөөтэй Хууль зүйн байнгын хороогоор шийдэх ёстой тэр юмыг ингээд явчхаж болж байгаа юм уу? Тийм учраас яг энэ яг тэр асуудал дээрээ бас Хууль зүйн байнгын хороог оролцуулж шийдэх ёстой шүү.

Мөнхчулууны Энхцэцэг гишүүн асуулт асууя. Батжаргалын Заяабал гишүүн асуулт асууя.

Б.Заяабал: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. Тэгэхлээр энэ цахим мөрийтэй тоглоомыг хориглох тухай хуулийн төсөл орж ирж байгааг ерөнхийд нь зарчмын хувьд дэмжиж байгаа. Цахим мөрийтэй тоглоомоос болоод олон иргэд хохирч байна. Төрийн байгууллагууд бас хяналт шалгалтаа тавихад бас хүндрэлтэй асуудал үүсэж байна. Монголын эдийн засаг бас энэ төлбөрийн баланс дээр бас ийм асуудал үүсгээд байна гэдэг ийм зүйлийг ярьж байгаа юм.

Тэгэхдээ энэ дээр бид нар бас ийм 2 зүйлийг анхаарч үзмээр байгаа юм л даа. Нэгдүгээрт нь энэ төр ер нь энэ дээр хориглох, аливаа зүйлийг хориглох амархан л даа. Бид нар хүртэл эцэг эхчүүд хүүхдэдээ боль гэж хэлэх амархан. Яагаад болих ёстой вэ гэдгийг ойлгож ухааруулах жоохон хэцүү.

Тэгэхлээр төр ч гэсэн өөрөө бас энэ дээр бас дүгнэлт хийх ёстой гэж ингэж үзэж байгаа юм. Өнөөдрийн энэ Засгийн газрын энэ хууль санаачлагчийн оруулж ирж байгаа танилцуулгыг аваад үзэхэд үндсэндээ нийт 75 орчим хувь нь 30-49 насныхан буюу 1990-2005 оны хооронд боловсрол эзэмшсэн 10 жилийн ерөнхий боловсрол эзэмшсэн ийм үеийнхэн л энд хамрагдаад байна л даа.

Тэгээд энэ дээрээс бид нар бас энэ судалгаа хийж үзэх ёстой юм болов уу гэж ингэж бодож байгаа. Төр өөрсдөө бас энэ өөрсдийгөө бас дүгнэж үзэх ёстой юм болов уу гэж ингэж бодож байгаа юм. Энэ боловсролынх нь программ нь болохгүй байгаа юм уу? Энэ тоглож байгаа хүмүүсийн боловсролын түвшин нь ер нь ямар байгаа юм, санхүүгийн боловсрол нь эдгээр хүмүүсийн хувьд бас ямар байгаа юм, ямар ажил хөдөлмөр эрхэлж байгаа юм, яагаад хүмүүс ийм мөрийтэй тоглоомыг хожих ямар ч боломжгүй ийм тоглоомыг тоглоод байгаа юм гэдэг ийм асуудлаар нь бас төр бас ингэж өөр дээрээ дүгнэлт хийж дараа дараагийн асуудлуудыг хаахын тулд бас энэ сургалтын программ гэх мэтчилэн бусад зүйлдээ бид нар бас энэ анхаарал тусгаж авч явах нь зөв болов уу гэсэн ийм бодолтой байгаа. Ийм санал бас хэлж байна.

Одоо бол хориглонгуут ингээд хориглохоос аргагүй ингээд хориглонгуут 60-65 орчим хувь нь хяналтад орно гэж байгаа юм. 35-40 хувийг нь хянаж чадахгүй гэдэг ийм зүйлийг бас өмнө нь танилцуулахад бас ярьж байсан. Тэгэхлээр Монголд ингээд гүйлгээг нь давтамжтай болоод байвал хориод эхлэнгүүт одоо нөгөө агентууд чинь гадаадад данс нээгээд Монголоос гадаадынх нь тэр агентынх нь данс руу нь мөнгө шилжүүлээд нөгөө агентууд нь Монголдоо биш гадааддаа гэмт хэрэгтэн болдог, мөнгө угаасан ийм өөрийнхөө иргэнийг бас гадагшийгаа ийм гадаад орны бас гэмт хэрэгтэн болгодог ийм зүйл рүү бас оруулчих вий дээ гэсэн бас ийм болгоомжлол бас надад яваад байгаа юм. Энэ дээрээ бас манай энэ төрийн хууль санаачилж орж ирж байгаа энэ Засгийн газрынхан, Засгийн газрын холбогдох түвшний хүмүүс анхааралдаа авах нь зүйтэй гэдэг ийм зүйлийг хэлье. Ингээд энэ чиглэлээрээ бас олон нийтийг бас энэ соён гэгээрүүлэх энэ чиглэлийн сургалт, мэдээллийг олгох чиглэл дээрээ бид нар бас түлхүү анхаарах хэрэгтэй.

Мөрийтэй тоглоом гэдэг бол өөрөө бас ингээд онлайн болон оффлайн гэсэн ийм 2 хэлбэртэй. Тэгээд онлайн нь бол ингээд хянах боломжгүй энэ аль ч улсад хянахад хэцүү гэдэг ийм зүйл ярьж байгаа. Гэтэл оффлайн буюу нөгөө ширээ, тусгай төхөөрөмжтэй тусгай газар болдог нөгөө казино гэж ярьдаг энэ бол боломжтой. 2022 онд байх Засгийн газар яг энэ Хөшигийн хөндийн чөлөөт бүс гэдэг агуулгаар энэ казиногийн хуулийг оруулж ирнэ гээд нэлээн бэлдэж байсан. Ингээд сураг тасраад дахиж татаж аваад дахиад өөр хувилбараар оруулж ирнэ гээд алга болчихсон. Ингээд цахим мөрийтэй тоглоомтой холиод энийг бас ингэж алга болгож болохгүй байх л гэж бодож байна л даа. 2019 оны та бүхний оруулж ирж байгаа танилцуулга дээр Солонгос Улс яг энэ казиногийн шугамаар 860 орчим сая долларыг оруулж ирсэн, татварт 251 сая долларыг авсан гээд та бүхний оруулж ирсэн танилцуулга дээр байгаа юм. Тэгээд аялал жуулчлалыг нэмэгдүүлье, эдийн засгийг нэмэгдүүлье, ажлын байрыг нэмэгдүүлье гэж байгаа юм бол бас энэ төр энэ зохицуулалтаа хийгээд.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Нэмэлт 1 минут өгье.

Б.Заяабал: Оффлайн энэ мөрийтэй тоглоомын асуудал оруулж ирэхгүй юм уу гэдэг нэгдүгээр асуулт байна.

Хоёрдугаарт нь энэ бооцоот таавар, тоглоомын асуудал бэтинг/betting/ гэдэг асуудал байгаа. Онлайныг нь манайх бас хянаж чадахгүй юм байна гэдэг ийм зүйл ярьж байгаа. Онлайны энэ бэтинг/betting/-ийн цаана нь дахиад ингээд нөгөө мөрийтэй тоглоом чинь яваад байна даа ийм учраас хянаж чадахгүй байна гэж.

Тэгвэл бодитой болж байгаа яг бооцоот тоглоомуудыг нь, бооцоот таавар тоглоомуудыг нь яагаад оруулж болохгүй байгаа юм бэ? Энэ морин уралдаан чинь бага насны хүүхэд унахыг хориглохоор нэлээдгүй нийгмийн тийм асуудал үүсэж байгаа. Насанд хүрсэн хүн морь унадаг ийм асуудал руу орох юм байна. Морин тойруулгын газруудыг цаашдаа хөгжүүлэх морин уралдаан ч гэж, морин тойруулга маягаар уралдаан хийх, бооцоот уралдаан хийх, бооцоот хэлбэрээр мэргэжлийн бокс шиг энэ бөхчүүдийгээ барилдуулах энэ үндэснийхээ спортуудыгаа хөгжүүлэх чиглэлээр энэ бооцоот таавар, тоглоомыг явуулж болохгүй юм уу? Эцэст нь энэ.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Тойргийнх учраас 1 минут нэмж өгье.

Б.Заяабал: Баярлалаа. Дахиад энэ дээр ийм асуудал байгаа юм. Өнөөдөр яг энэ нийгэм дээр яг ийм, өнөөдөр нийгэмд ямар асуудал байна вэ гэвэл яг хөдөө орон нутагт яаж байна гэхээр 1, 1 хонь үүрч ирээд хоорондоо тоглодог. Тэгээд мотоцикл хожоод явдаг. Хожсон нь мотоцикл хожоод явдаг ийм байдал бол байгаа шүү дээ. Энэ цэнгэлдэх хүрээлэн, бусад газрууд дээр бас энэ мөрийтэй шаар хагалуулаад тоглодог гэх мэтчилэн ийм зүйлүүд байгаад байгаа.

Тэгээд энэ хуулийн чинь цаана энэ нийгэмд байгаа энэ зүйлүүдийг бас давхар хорьчихоор зэрэг зүгээр энгийн иргэдийгээ бид нар дахиад гэмт хэрэгтэн болгочих ийм асуудал руу түлхчих юм биш үү гэсэн ийм болгоомжлол байгаа юм. Энэ бүхэн дээр хариулж өгөөч баярлалаа.

Б.Пүрэвдорж: Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Заяабал гишүүний асуултад хариулъя. Тэр бид ингээд хорьж цагдахаасаа зэрэгцээд бас соён гэгээрүүлэх ёстой гэдэг дээр 100 хувь санал нийлж байна. Ямар ч байсан ингээд болохгүй байгаа юмнуудыг нь хориглоод авъя. Соён гэгээрүүлэх ажлыг бид улс даяараа хийх ёстой. Тэр дээр одоо байгаа хуулийн зохицуулалтууд ч байгаа. Нэмж хийх зүйлүүд дээр бүх гишүүд энэ дээрээ санаачлаад явахад нээлттэй гэж ингэж харж байна.

Энэ хуулиар олон зүйлийг хаанаа хаана. Тэгэхээр бас дагаад олон юм хаагдчих вий гээд, болж байгаа зүйлүүд нь хаагдчих вий гээд болгоомжилж байх шиг байна. Цахим орчин руу шилжүүлчихсэн тэр нь ингээд 1xBet гэх мэт ийм хууль бус ийм формат руу яваад орчихсон. Энийгээ л бид хориглож байгаа.

Тэрнээс биш ийм цахимаас гадуур тэр ахуйн хүрээнд явж байгаа тэр 1 хонио үүрч ирээд тэнд гэр бүлийн хүрээнд энд ийм зүйлүүд рүү бол тэрийг хууль бус гээд ч юм уу тодорхойлоод тэрийг эдийн засаг дээр нь тооцоолж гаргаад ингээд явж байгаа зүйл байхгүй л дээ.

Тэгэхээр нэгэнт бид харсаар байтал энэ чинь бараг жилдээ энэ чинь 2 их наяд, зөвхөн харж байгаа нь шүү, банкин дээр гүйж байгаа нь 2 их наяд төгрөг. Банкнаас гадуур койн ч байдаг юм уу, өөр ямар ч хэлбэрээр явдаг юм бүү мэд. Энэнээс ч давсан хэлбэрээр ийм далд эдийн засаг үүссэн байхад бид нар харсаар байтал өөр зүйлүүдтэй жишиж байгаад ингээд давхар юмнууд нь, болж байгаа юмнууд нь хоригдчих вий эд нар гээд ингээд бид нар хойшлуулж болохгүй гэж

харж байгаа. Ямар ч байсан хаагаад авъя. Өөр цаашаагаа шаардлагатай эрүүл орчинд зохицуулалттай ийм зүйлүүдийг бол цаашдаа өөр хуулиар зохицуулаад явж болох байх гэж ингэж харж байгаа шүү.

Б.Пүрэвдорж: Хассуурийн Ганхуяг гишүүн асуулт асууя.

Х.Ганхуяг: Энэ өдрийн мэндийг хүргэе. Пүрэвдорж гишүүн бид хоёр Зөвшөөрлийн хууль дээр олон жил хамт сайхан ажилласан. Тэгээд бид нар бас бизнес, хувийн хэвшилдээ боломжийг илүү нээлттэй болгох, Бямбацогт гишүүн бас санаачилж оролцсон байгаа. Энэ дээр гол нь бид нар авлигал, хүнд суртлын бууруулах, эрсдэл бүхий үйл ажиллагаануудыг зөвшөөрөлтэй болгох, зөвшөөрөл шаардлагагүй асуудлууд дээр зөвшөөрөлгүй болгох гээд иймэрхүү ажлууд хийгдсэн юм. Үндсэн концепц бол хуулиар хориглоогүй бол үндэсний аюулгүй байдал, хүн, амь насны тодорхой хэмжээний эрсдэлтэй үйл ажиллагаа дээр зөвшөөрөл олгох харилцааг Зөвшөөрлийн хууль зохицуулдаг юм. Нэг ёсондоо хуулиар хориглоогүй бол гэж орсон байгаа.

Тэгэхээр зөвшөөрлийн хуульд хориглох заалт өөрөө байхгүй гэсэн үг. Тэгэхээрээ нөгөө бусад хуулиар л энийг хориглох боломжтой гэсэн үг. Тэгэхээр энийгээ та нар Эрүүгийн хууль дээр оруулах, нөгөө хууль зүйн техник талаасаа энийг бид нар хэрвээ цаашаа хэлэлцээд явна гэх юм бол энэ ажлын хэсэг болон манай Учрал сайд ч тэр Зөвшөөрлийн хууль дээр тэр юм оруулах боломж байхгүй. Эрүүгийн хуулиа аваад энэ зөвшөөрлийн хуулийн харилцаатай холбоотой асуудал дээр анхаарахгүй бол болохгүй. Хууль хоорондын зөрчил үүснэ. Үүнээс цааш бүх л нөгөө хориглох үйл ажиллагаа Зөвшөөрлийн хууль руу оруулдаг болох гээд байгаа юм. Тэр чинь Эрүүгийн хууль дээрээ байж байгаа байхгүй юу. Эрүүгийн хууль руугаа оруулах зохицуулалттай юм шүү. Энэ дээр бас анхаараад өгөөрэй гэж байгаа юм.

Асуулт юу байна гэхээр энэ төлбөрт таавар, бооцоот тоглоом, цахим мөрийтэй тоглоом гэсэн байдал дээр энэ дээр хориглох 1 заалт орж ирэх гэж байгаа юм байна гэж ойлголоо. Тэгэхээр энэ дотор ямар ямар ер нь үйл ажиллагаануудыг хэлээд байгаа юм бэ гэдгийг тодруулчихмаар байна. Нөгөө уяачид хоорондоо бооцоотой морь уралдуулдаг энд орох уу, орохгүй юу гэх мэтчилэн ер нь олон юмнууд байна. Энэ дээр яг юу юу орж байгаа гэдгийг тодруулчихмаар байна.

Хоёрдугаарт, Алтангэрэл сайд байхгүй байна. Тэгэхээр Засгийн газрыг төлөөлөөд Учрал сайд хариулах ёстой юм болов уу, яах ёстой юм? Би энийг сайн мэддэггүй. Ноорог гэж залуучуудыг зүйл, заалтыг нь зүйчлээд олон янзаар зүйчилж байгаад нэгийг нь хорьчих шиг болсон. Тэгээд хамгийн сүүлийн үндэслэл нь болохоор энэ төлбөрт бооцоот тоглоом явуулсан гэдэг үндэслэлээр хорьсон. Гэсэн мөртөө өнөөдөр энэ хориглох заалт нь хууль нь өнөөдөр л өргөн баригдаж байгаа байхгүй юу.

Тэгэхээр хуулийн зохицуулалтгүйгээр ингээд хүүхдүүдийг аваад хорьчихсон юм уу? Эсвэл нөгөө хүнийг нь барьж байгаа шалтгаан олох гээд байгаа юм уу? Энийг би тодруулчихмаар байна. Энэ чинь бид нар сая цагийн өмнө Хүний эрхийн тухай хууль батлаад л байсан, зөвшөөрөлгүйгээр хорьж болохгүй гээд л яриад л байсан, хуулийн зүйлчлэл, заалтыг өөрчилж болохгүй гээд л яриад л байсан.

Тэгээд яг ингээд бодит өнөөдрийн энэ сая 2 долоо хоногийн өмнө, 3 долоо хоногийн өмнө болсон асуудал өнөөдөр бид нар хэлэлцээд сууж байгаа юм. Одоо энийг харах юм бол өнөөдрийг хүртэл энийг хориглоогүй юм байна. Хориглоогүй болохоор бид нар гадагшийгаа мөнгө алдаад байгаа юм байна. Тэгээд бусад нь яахаараа энэ дээр хариуцлага хүлээхгүй, ганцхан тэр хэдхэн хүүхдийг ингээд аваад хорьчихсон бэ гэдэг би нэг хариулт авчихмаар байна.

Гуравдугаарт болохоор ер нь энэ бооцоот тоглоомыг хориглох нь зөв эсэхийг бид нар бас нэлээн сайн ярилцах нь зөв юм. Бүүр нөгөө далд руугаа орчих вий. Ер нь энийг яагаад энэ дээр Зөвшөөрлийн хууль дээр үлдээсэн бэ, ямар нөхцөлөөр үлдээсэн бэ гэхээр би Их Хурлын протоколд ч байгаа, ажлын хэсгийн протоколд ч байгаа салбарын хуулийг өргөн барьтал 1 ч зөвшөөрөл олгохгүй шүү гэсэн. Нэг ёсондоо салбарын хуулийг баталтал зөвшөөрөл олгохгүй. Энэ үйл ажиллагааг Засгийн газар зөвшөөрлийн хуулийн дагуу хориглох, түдгэлзүүлэх боломжтой байсан. Түдгэлзүүлэх боломжтой байсан. Нэг ёсондоо шинээр зөвшөөрөл олгохгүй байх боломжтой байсан гэсэн үг. Тэгэхээр Сангийн яаман дээр энийг би уулзахдаа ч хэлж байсан.

Б.Пүрэвдорж: Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Тийм, энэ Ганхуяг гишүүн энэ Их Хурал дээр ажлын хэсэг ахлаад тухайн үед Зөвшөөрлийн хуулийг баталж байхад 360 зөвшөөрөл боллоо. Тэр мянга тав, зургаан зуун зөвшөөрөл чинь багаслаа гээд. Тухайн үед маш том дэвшил гарсан. Гэтэл тухайн хууль дээр Зөвшөөрлийн зөвлөл Ерөнхий сайдын дэргэд ажилладаг, Зөвшөөрлийн сан нь Эдийн засгийн сайдын дэргэд байдаг. Тэгээд зөвшөөрлийн зөвлөлөөс хэрвээ дүгнэлт аваагүй тохиолдолд салбарын ямар ч хуулиудыг дагалдуулж зөвшөөрлийг нэмэхгүй, дээрээс нь зөвшөөрөлд заасан хугацааг янз бүрийн эрх олгосон журмаар сунгаж болохгүй, нэмэлт шаардлага тавьж болохгүй. 360 зөвшөөрөлд дурдагдаагүй л бол бусад төрлийн үйл ажиллагааг эрхлэхийг зөвшөөрнө гэдэг энэ концепц байсан.

Гэтэл 2 жил болоход 18 зөвшөөрлийг Зөвшөөрлийн зөвлөлөөс 1 ч дүгнэлт аваагүйгээр нэмэгдүүлсэн байсан. Одоо 360 биш шүү дээ. Энэ чинь бараг 380 хүрч байгаа шүү дээ. Ингээд яваад байх юм бол жил болгон ингээд 10, 10 зөвшөөрөл нэмээд байх юм бол энэ удахгүй 1000 зөвшөөрөл буцаад л болох байхгүй юу.

Тэгэхээр Зөвшөөрлийн зөвлөл өөрөө ажлаа хийх ёстой гэдэг утгаараа сая энэ Зөвшөөрлийн зөвлөлийг бас миний хувьд эрхлэх асуудлын хүрээнд ахалж байгаа учраас Зөвшөөрлийн зөвлөл дээр шийдвэр гаргаад салбарын яамнууд руу саналуудыг явуулаад нийтдээ 60 журмыг цуцлуулсан. Энэ удаа бооцоот тоглоом, төлбөрт тааврын үйл ажиллагаа эрхлэх чинь хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээнд олгодог зөвшөөрөл. Анх энэ зөвшөөрлийг олгохыг нь ингээд шууд хасчихъя гэхээр хэрвээ хасчих юм бол бүүр зөвшөөрөгдчих гээд байгаа байхгүй юу. Зөвшөөрлийн хуулийн үзэл баримтлалд. Энийг аваад хаячих юм бол зөвшөөрөлд багтаагүй учраас энэ зөвшөөрөгдөнө гээд харин бүүр бооцоот тоглоомыг дураараа эхлэх ийм байдал руу хүрчхээд байгаа юм.

Тийм учраас бид нар тэр зөвшөөрлийг аваад доор нь хориглох заалтыг нь нэмээд тэгээд нийгмийн хор хохирлынх нь хэмжээ өнөөдөр эдийн засгийн гэмт

хэрэг 471 хүрчхэж байгаа учраас Эрүүгийн хууль, Зөрчлийн хууль дээр нь энэ санкцыг нь нэмэгдүүлээд зохицуулаад явах нь зөв өө гэдэг утгаараа энэ удаа хуулийг хийсэн. Тэгэхээр Ганхуяг гишүүний яриад байгаа маш зөв. Энэ Зөвшөөрлийн зөвлөл Зөвшөөрлийн хуулийнхаа хэрэгжилтийн манаанд хамт зогсохгүй бол энэ салбарын хуулиудыг дагалдуулж нэмж зөвшөөрөл авдаг, янз бүрийн дүрэм журмууд авдаг, янз бүрийн эрх авдаг энэ байдал өнгөрсөн хугацаанд хэрээс хэтэрсэн.

Тийм учраас энэ хаврын чуулганаар Зөвшөөрлийн хуулиараа дагалдуулж нэмэлтээр эрх олгосон янз бүрийн журам авсан 80 гаруй хуулиудыг өөрчлөхөөс өөр сонголтгүй болсон. Тэгэхээр энэ Зөвшөөрлийн хуулийг энэ хаврын чуулганаар бас оруулж ирээд шийдэх ёстой. Энэ дээр Ганхуяг гишүүнтэй хамтарч ажиллаад бас үр дүнд хүрнэ гэж ингэж бодож байгаа.

Б.Пүрэвдорж: Ганхуяг гишүүнд ахиж тодруулъя.

Х.Ганхуяг: Энэ Засгийн газрын гишүүдээс Учрал сайд яг энэ Зөвшөөрлийн хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор хамгийн их дунд тусалж, дэмжиж байгаа гишүүн байгаа. Ер нь Зөвшөөрлийн хууль гарснаар Зөвшөөрлийн хуультай холбогдсон бүх журмуудыг цуцлахаар хууль батлагдсан юм. Тэгээд нэг ёсондоо Улсын Их Хурлаас 2 удаа тогтоол гаргасан журмуудаа цуцлаач гээд. Тэгээд цуцлахгүй байсаар байгаад 2022 онд батлагдсан хуулийн хэрэгжилтийг нь сая энэ 25 оны 1, 2 сард хийж эхэлж байгаа байхгүй юу. Тэгээд одоо бид нар бас жоохон нэмэлт, өөрчлөлтийг оруулах асуудлыг Учрал сайд бид 2 бас яриад удахгүй өргөн барих байх.

Энэ бооцоот тоглоомтой холбоотойгоор хэрэвзээ энэ байхаар бол ер нь олон улсын практикт онцгой татвартай байдаг, хатуу хяналт дор явуулдаг, дээрээс нь хэн тоглож болох вэ, хэн тоглож болохгүй гэдэг насны юуг нь хязгаарлалтыг нь хийж өгдөг, онлайн тохиолдолд зөвхөн Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгжид ийм зөвшөөрөл олгож явдаг практиктай юм.

Б.Пүрэвдорж: Ноорогтой холбоотой ялангуяа хэвлэн нийтлэх эрх чөлөөний эсрэг асуудал гарсан байгаа. Тэгэхээр би Ганхуяг гишүүний асуултыг даргын зөвлөл дээр Алтангэрэл дарга байгаа орж ирэхээр нь заавал хариулуулна. Та хүлээж байгаарай.

Энхбатын Болормаа гишүүн асуулт асууя.

Э.Болормаа: Ингээд энэ асуудлыг оруулж ирж байгаад их баярлаж байна. Ер нь энэ 1xBet-ээс болж хохирч байгаа иргэдийн талаарх олон талаас нь бид нар ярилаа. Санхүүгийн зах зээл талаас нь би бас ярьж хөндье гэж бодож байна. Яагаад гэвэл энэ КОВИД-оос хойших 4 жилийн хугацаанд гадагшаа урсаж байгаа мөнгө үүнээс 4 дахин ихэссэн байгаа. 500 гаруй сая доллар гэдэг тоог албан ёсоор энэ танилцуулга дээр оруулж ирсэн байна. Зөвхөн өчигдөр, уржигдрын мэдээг харахад зүгээр энэ тоо биш юм шүү, 500 гаруй сая доллар гэдэг Монголын гадаад валютын нөөцийн бүүр 10 хувь гадагшийгаа урсаж байгаа мөнгө гэсэн үг. Монгол Улсад аялал жуулчлалын салбараас орж ирж байгаа бүх мөнгөтэй тэнцэхүйц хэмжээний мөнгө ганц жилд гадагшаа урсаж байна гэдэг ийм томоохон асуудал. Үүнийг бид энэ танхим дотор орж ирж ярих нь зөвөөс зөв.

Харин үүнийг Зөвшөөрлийн тухай хуульд оруулж ирэх нь зөв үү гэдэг асуудлыг би Учрал сайдаас асуумаар байна. Сая Ганхуяг гишүүн маш тодорхой асуулаа л даа Зөвшөөрлийн тухай хуульд хориглох заалт орох учиргүй ээ. Энд зөвшөөрлийг олгодог. Тэгэхээр одоогоор Зөвшөөрлийн тухай хуульд 11.4-д төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагааг Хууль зүйн яамнаас тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх боломжтой гэсэн байна. Тэгэхээр өнөөдөр яг Монгол Улсын хэмжээнд хэдэн аж ахуйн нэгж ийм зөвшөөрөлтэй байгаа вэ? Мэдээж 1xBet зөвшөөрөлгүй байгаа одоогоор. Тэгэхээр одоогоор энэ дээр зохицуулалт хийхэд хууль, эрх зүйн хүрээнд ямар хязгаарлалт та бүхэнд тулгарч байна? Засгийн газарт. Саяхан Учрал сайд нэлээд олон сайтыг хаасан байгаа. Энэ яг ямар хууль зүйн үндсэн дээр эдгээр сайтуудыг хаасан бэ? Тэгэхээр ямар гацаа тулгараад энэ Зөвшөөрлийн хуульд өөрчлөлт оруулж ирж байгаа юм бэ гэдгийг би асуумаар байгаа юм.

Яагаад гэвэл ийм том эдийн засгийн асуудал 1xBet-ээс болоод ингээд цаг алдаад тэгээд бид нар яаралтайгаар оруулж ирчхээд нөгөө талдаа энд давхар хоморгод нь өртөх магадгүй ирээдүйн аялал жуулчлалын томоохон салбар болох энэ спорт бооцоот тааврын ч гэсэн асуудал орж ирж байна л даа. Дэлхийн бусад улс орнуудад морин спорт ч юм уу, магадгүй манайхан цаашдаа аялал жуулчлал, үндэсний бөхөө ч юм уу ингээд хөгжүүлэх энэ боломжийг энийгээ ингээд давхар хамруулчхаж байгаа асуудал дээрээ судалгаа хийсэн үү гэдгийг эхлээд асууя. Тэгээд тодруулъя.

Б.Пүрэвдорж: Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Дэлхийн улс орнууд яагаад энэ цахим мөрийтэй тоглоомыг, бооцоот тоглоомтой нь хамтад нь хориглоод байгаа вэ гэвэл яг технологийн хувьд тэр онлайн бэт/bet/ цахим тэр бэт/bet/ буюу бооцоо үүнийг мөрийтэй тоглоомоос ялгах бололцоо бас төдийлөн байхгүй байгаад байх шиг байна. Тэр бооцоот тоглоом гэдэг нэрийдлээр ард нь мөрийтэй тоглоомын шинжийг агуулж байгаа үйл ажиллагаа л эрхлээд байгаа юм.

Хэрвээ энэ Зөвшөөрлийн хууль дээр бооцоот тоглоом, төлбөрт тааврын үйл ажиллагаа эрхлэхийг хэвээр нь үлдээвэл 1xBet шууд зөвшөөрлөө аваад л үйл ажиллагаагаа явуулна шүү. Энэ зүгээр жишээ. Тэд юу гэж өөрсдийгөө тайлбарладаг вэ гэхээр бид бооцоот тоглоомын үйл ажиллагаа явуулдаг шүү. Бид нар мөрийтэй биш шүү гээд байгаа юм, гэж хэлээд байгаа юм. Одоо зөвшөөрөлгүй яваад байдаг. Түрүүн бас гишүүд асууж байсан. Энэ чинь бүр татварын хуулиар маш өндөр шүү дээ энэ чинь. Энэ 3 тусгай зөвшөөрөлтэй дотоодын аж ахуйн нэгжүүд 3 тэрбум төгрөг татвар төлөх байсан шүү дээ. 1 ч төгрөг төлөөгүй. 1xBet нь бүр зөвшөөрөл ч аваагүй. Тэгээд ийм нөхцөл байдал байгаа учраас бол үүн дээр бүтнээр нь хориглох эхний алхам хийх ёстой юм байна гэж шийдсэн. Үүнийг ялгах бололцоо бол байхгүй. 1xBet бол тэр бүх төрлийн олон цахим мөрийтэй тоглоомуудын аппликэйшнүүдийн 1 л жишээ.

Болормаа гишүүний энэ санал дээр бол тэр нөгөө оффлайн буюу яг олонд заавал цахимаар биш тэр морин уралдаан, бусад төрлийн бооцоот тэр спорт, төлбөрт таавар, янз бүрийн үйл ажиллагаа явуулахыг Их Хурлын гишүүд ажлын

хэсэг дээрээ бас ярилцах чөлөөтэй, нээлттэй үлдээсэн. Үүнийг бол бас шийдээд явж болох байлгүй дээ л гэж ингэж бодож байгаа юм.

Тэгэхдээ ажлын хэсэг шийдэх хэрэгтэй. Засгийн газрын байр суурь бол бид гарч байгаа валютын урсгал, нийгмийн хор аюул, энэ болгоноо хараад Засгийн газар бол нэгдсэн байр суурьтайгаар цахим мөрийтэй тоглоомыг ч тэр, бооцоот тоглоомыг ч тэр, төлбөрт тааврыг ч тэр, технологи, эрх зүйн орчин, нэр, томьёо, агуулга дээр нь ялгаж салгахад бэрхшээлтэй байгаа олон улсын жишгийг үндэслээд бүхэлд нь хориглоод явъя. Цаашдаа тэр соён гэгээрүүлэх ажлууд хийгдээд нийгмийн сэтгэл зүй бэлэн болсон цагт спорт юуг нь ялгаад ч юм уу явах байх. Гэхдээ ер нь спорт бэт/bet/ гэдэг нэрийн цаана мөрийтэй тоглоомын хэв шинжийг агуулдаг. Одоо сүүлдээ бол тэр манипуляц хийдэг болсон байна лээ. Янз бүрийн байдлаар худлаа хожигдож өгдөг, нэг талд нь хожуулдаг, үүний дунд иргэд хохирдог.

Тэгээд л ингээд л үүний чинь цаана энэ чинь мөрийтэй тоглоомын шинж шүү дээ. Тэгээд яагаа вэ энэ хууль дээр бол бид нар ашиг олох зорилгоор үйл ажиллагаа эрхэлсэн бол 1 үйлдэл, зуучилсан буюу агент хийж дундаас нь шимтгэл авсан бол 1 үйлдэл, сурталчилсан бол бас 1 үйлдэл, зохион байгуулж, дэмжлэг үзүүлсэн бол 1 үйлдлээ гэдгийг бүхэлд нь хориглож, дэмжлэг үзүүлэх нь дугаараа ашиглуулна уу, банкны данс ашиглуулна уу ингээд.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Баатархүү сайд хариулчих. Хариулж дуустал нь минутыг нь өгчхөөрэй.

Ц.Баатархүү: Энэ цахим мөрийтэй тоглоомыг хэрхэн зохицуулах вэ хориглох вэ гэдэг асуудал дэлхийн улс орнуудын тулгамдсан асуудлын нэг болсон. Улс орнууд цахим мөрийтэй тоглоомыг зохицуулах комисс, газар, агентлагийг байгуулж байна. Дэлхий даяар энэ цахим мөрийтэй тоглоомыг орчин цагийн хар тахал гэж үзэж маш олон тийм сэтгэл зүйн судалгаануудыг явуулж байна. Хамгийн сүүлийн судалгааны дүнг би танилцуулахад 2023 онд энэ донтолтын зан үйлийн талаар судалгаа хийсэн байна. Энийг бүрэн хориглох юм бол хүмүүст ямар нөлөө үзүүлдэг юм бэ гэж. 60 орчим хувьд нь эерэг нөлөө үзүүлж, 40 орчим хувь нь хууль бус хувилбарыг хайсан байгаа.

Тэгэхээр бүрэн хориглосноор 60-65 хувийн эерэг үр дүн, 35-40 хувийн эрсдэл байна. Тэгэхдээ нэг дүгнэлт хийсэн байгаа. Энэнээс өөр хамгийн шилдэг арга бол олдохгүй байна. Хориглох бол хамгийн сайн арга биш юм гэхэд энэнээс өөр сайн зохицуулалт олдохгүй байна гэж байгаа. Дэлхийн улс орнууд үндсэндээ бүрэн хориглох, хэсэгчлэн хориглох гэдэг хоёр энэ арга замыг хэлбэрээр явуулж байна.

Монгол Улсын хувьд нийт энэ залилангийн хэргийн 80 орчим хувь нь цахим залилан байгаа учраас энэ цахим мөрийтэй тоглоом, спорт, таавар гэдгийн цаана маш олон цахим залилан, далд эдийн засгийн асуудал үүсэж, гэр бүл салах, орон байраа тавих, тэр байтугай маш олон улсын томоохон хөрөнгө оруулалттай компанийн нэгэн менежер байгууллагынхаа бүх компьютерыг тавьж тоглох ч гэх юм уу маш олон ийм ноцтой хэргүүд гарч байгаа учраас бүрэн хориглох нь эхний удаа хамгийн зөв шийдэл гэж үзэж байгаа. Одоогийн байдлаар бид нар зөвхөн энэ технологийн хувьд хязгаарлах зорилгоор 6000 орчим домэйнийг прокурорын

зөвшөөрөлтэйгөөр хаасан байдаг. 2250 орчим дансыг хязгаарласан байдаг.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Энхбатын Болормаа гишүүн нэмж асууя.

Э.Болормаа: Сая Баатархүү сайд хэдэн данс болон хэдэн сайт хаасан тоог хэллээ. Мөн прокурорын зөвшөөрөлтэй гэдгийг дурдлаа. Яг ямар үндэслэлтэйгээр прокурор энийг зөвшөөрсөн юм бэ гэдгийг тодруулж асуумаар байна. Яагаад вэ гэхлээр тэгэхээр бид нар ямар хуульд өөрчлөх, оруулах шаардлагатай юм байдаг тэндээс л гарч ирэх гээд байна л даа. Одоо хийж болоод, хааж болоод, зохицуулж болоод байгаа юм уу? Тэгвэл бид нар яагаад энэ зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах гээд байгаа юм бэ гэдэг асуудал.

Тэгээд би энэ давхар бас тодруулга дээрээ энэ Санхүүгийн зохицуулах хороо болон Монголбанкныханд онцгойлон бас хэлмээр байна. Өнгөрсөн 4 жилийн хугацаанд Монгол Улсын валютын нөөцийн 10 хувьтай тэнцэх энэ хэмжээний мөнгө жилд гарч байна шүү дээ. 4 дахин ихсээд. Яагаад энэ эдийн засаг санхүүгийн байгууллагууд энэ дээр анхааруулга өгч, арга хэмжээ авах саналууд явуулаагүй юм бэ? Өнгөрсөн жил 6 хувийн зээлийн бүх ипотек гарснаас илүү их мөнгө гадагшаа 1xBet-ээр урссан байна шүү дээ. Энэ та бүхний цаашид анхаарах .../минут дуусав.

Б.Пүрэвдорж: Баатархүү сайд хариулъя.

Ц.Баатархүү: Энэ удаа зохицуулалт хийгдэж байгаа нь хамгийн гол нь энэ Монголбанк, банк санхүүгийн байгууллагууд энэ мөнгө гадагшаа гарч байгаа, цахим залилангийн шинжтэй, мөрийтэй тоглоомын шинжтэй энэ урсгал дээр хязгаарлалт тавих зохицуулалт нэмснээрээ энэ зохицуулалт илүү үр дүнтэй болж байгаа. Өмнө нь зөвхөн домэйнийг хаадаг байсан. Домэйнийг ямар ямар үндэслэлээр хаадаг вэ гэхээр оюуны өмчийн улсын байцаагч, прокурорын зөвшөөрөл, Харилцаа холбооны зохицуулах хорооны шийдвэрээр домэйнийг хаадаг. Ямар нэгэн төрийн байгууллага байхгүй. Хараат бус зохицуулах хороон дээр гомдол ирээд цагдаагийн байгууллага, хуулийн байгууллага гомдол ирээд шалгаж үзээд улсын байцаагчийн дүгнэлтээр хаадаг. Хаагаад байхад нэмж домэйн аваад, хаягаа өөрчлөөд яваад байсан учраас энэ маань юу юм бэ гэхээр технологийн хувьд хязгаарлах ямар ч боломжгүй юм байна. Тэгэхээр санхүүгийн гүйлгээтэй нь хамт хязгаарлая гэдэг энэ зохицуулалтыг л энэ хуулиар оруулж ирж байгаа.

Б.Пүрэвдорж: Нутгийн охин тодруул.

Э.Болормаа: Яг Эрүүгийн хуульд юм уу, Зөрчлийн тухай хуульд юм уу яг ямар зүйл, заалтыг үндэслэсэн бэ? Прокурорын бичиг дээр үндэслэсэн юм байгаа даа. Би тэрийг маш тодорхой асуугаад байна л даа. Юуг үндэслэж энэ иргэдийн данс болон сайтуудыг хаасан бэ гэдгийг л маш тодорхой хариулаад өгөөч.

Б.Пүрэвдорж: Санхүүгийн зохицуулах хороо хэдэн номер вэ, 5 уу? 5 номер.

Т.Батболд: Харилцаа холбооны зохицуулах хороо Т.Батболд Болормаа гишүүний хариултад өгье. Өнгөрсөн хугацаанд мөрийтэй тоглоомтой холбоотой

домэйн дэргэдэх хязгаарлалт нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу прокурорын зөвшөөрлөөр Эрүүгийн цагдаагийн албаны мөрдөн байцаагчийн албан даалгаврын хүрээнд хязгаарлалтуудыг хийсэн байгаа. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн заалтууд нь 22.1, 22.3, 26.1 дүгээр зүйлийг баримтална зөвшөөрлийг өгсөн байна.

Б.Пүрэвдорж: Банзрагчийн Түвшин алга байна. Ер нь сөрөг хүчний гишүүд заавал үг хэлэх ёстой. Нэрээ өгдөг. Энэ нэр өгчхөөд алга болчхож байж болохгүй шүү. Олон хүний асуулт асуух эрхийг хааж байна гэсэн үг. Цэндийн Сандаг-Очир гишүүн асуулт асууя.

Ц.Сандаг-Очир: Зөв өө зөв. Энэ хориглох асуудал байх ёстой. Харин ч цаг хугацаа алдаж байна гэж ойлгож байгаа. Өнөөдөр Монгол Улсад 2 зүйл хориглочихмоор байгаа. Нэг нь энэ цахим мөрийтэй тоглоом, нэг нь энэ электрон тамхи хоёрын асуудал. Ямар ч зохицуулалтгүй, татвар төлдөггүй ийм хоёр асуудал байгаа. Одоо тэгээд 1 асуудал нь өнөөдөр орж ирж байх шиг байна. Гэхдээ логикийн алдаа байна гэж харж байна. Учир нь түрүүнд 2 ч гишүүн хэллээ. Зөвшөөрлийн хууль бол тухайн зөвшөөрөл олгох асуудлыг л, харилцааг л хуульчилдаг хууль. Гэтэл зөвшөөрөл олгох асуудал биш, хориглосон асуудлыг Зөвшөөрлийн хуульд оруулж ирнэ гэдэг чинь өөрөө логикийн алдаатай байна.

Тийм учраас би Учрал сайдыг энэ бие даасан анхдагч хуулиар гэдэг юм уу, хязгаарлалт, хориглолтын хууль гэдэг ч юм уу ийм бие даасан хуулиар энэ асуудлыг зохицуулах бололцоо, боломж байдаггүй юм уу? Зөвшөөрлийн хуулиар чинь энэ одоогийн мөрдөгдөж байгаа хуульд энэ асуудал огт өгүүлбэр байхгүй байна шүү дээ. Зөвшөөрөл олгогдоогүй байж байж, олгогдоогүй байхад хориглоно гэдэг чинь өөрөө логикийн алдаа байгаа байхгүй юу. Ямар нэг зөвшөөрлийг өгчихсөний дараа түүн нь энэ нь болохгүй юм байна гээд эргүүлээд хориглох асуудал байж болно.

Гэтэл энэ үг, өгүүлбэр байхгүй энэ хуульд хориглосон заалт оруулж ирж байгаа нь өөрөө энэ логикийн алдаатай байна шүү дээ. Тэгэхээр энийг чинь өөрөө цаашдаа технологи яаж ч хөгжихийг үгүйсгэхгүй. Энэний дараа ахиад л технологийн өөрчлөлт гараад л ахиад л ийм юм гараад ирнэ. Тэгэхээр энэ болгон Зөвшөөрлийн хуульдаа оруулж ирсэн дор бол ер нь цаашдаа хориглолт, хязгаарлалтын ийм бие даасан анхдагч хууль байх бололцоо, боломж бас байхгүй юм уу? Энийг ярилцсан уу танай ажлын хэсэг? Энийг хэлж өгөөч учрал сайд аа.

Б.Пүрэвдорж: Учрал сайд хариулъя. Бие даасан хууль байж болохгүй юм уу.

Н.Учрал: 1999 оны онд бол 3 заалттай казиногийн хуулиар хууль гаргаад казиног бүхэлд нь хориглосон мөрийтэй тоглоомыг. Тухайн үед бол олон жилийн өмнө тухайн үед энэ сошиал медиа, мэдээллийн технологи ингэж их хөгжөөгүй байсан. Тэр ч утгаараа мэдээллийн технологи ашиглан мөрийтэй тоглоомыг зохион байгуулсан бол гээд Эрүүгийн хууль дээр тухайн үед хариуцлага оногдуулж байсан юм байна лээ. Одоо цаг үе их өөр болчихсон. Нөгөө цахим мөрийтэй тоглоом гэдэг чинь бие даасан ийм үйл ажиллагаа болчихсон.

Тэгээд бооцоот тоглоом, төлбөрт тааврын ард мөрийтэй тоглоомын хэв шинж дандаа агуулдаг болчихсон. Маш олон ийм аппликэйшнүүд гарчихсан. Тэгээд санхүүгийн салбарт ч гэсэн их том өөрчлөлт орсноороо төлбөр мөнгө, гүйлгээнүүдийг банкаар дамжихгүйгээр крипто валютаар шууд хоорондоо шилжүүлдэг болчихсон. Үүний цаана дандаа мөнгө угаахын ийм шинж агуулагддаг. Ийм үндэстэн дамнуулсан ийм үйл ажиллагаанууд ер нь их болсон. Ер нь бол тэгээд л татвараас нуугдах зорилготой янз бүрийн оффшор бүсэд аваачиж мөнгө төгрөг хийдэг энэ арга нь улам нарийсаж байгаа юм.

Тийм учраас яг энэ үйл ажиллагаа эрхлэхийг нь ч тэр, зуучлахыг нь ч тэр, сурталчлахыг нь ч тэр, дэмжлэг үзүүлэхийг нь бүүр нарийвчлаад тэр дансаа ашиглуулсан бол, цахим хаягаа ашиглуулсан бол гээд ингээд тухайлан үйлдлүүдийг нь заагаад хориглох шаардлага байсан. Бие даасан хууль гаргая гэчихээр 99 оны хуулиар бүхэлдээ энэ чинь нөгөө казиног бүхэлд нь хориглочихсон. Зарим тохиолдолд мөнгө угаах, залилангийн хэв шинж байвал хуулийн байгууллага татаад ингээд шалгадаг юм шиг байгаа юм. Тэгэхдээ энэ чинь нөгөө яг өнөөдрийн энэ сошиол дээр яваад байгаа энэ янз бүрийн аппликэйшн энэ тэр дээр бол шууд тэр заалтаар ингээд үйл ажиллагааг нь зогсоход л маш их бэрхшээлтэй. Үйлдлүүд нь тодорхойгүй биш учраас.

Дээрээс нь Зөвшөөрлийн хуулийг харсан чинь Зөвшөөрлийн хууль тэн дээр төлбөрт таавар, бооцоот тоглоомыг зөвшөөрөөд түүнийг нь Хууль зүйн сайд олгоно гээд хуульчилчихсан. Түүнийг нь аваад бие даасан хууль гаргаад ингээд явъя гэхээр Зөвшөөрлийн хууль дээр байгаа тэр зөвшөөрлүүдийг аваад заавал хориглох заалтыг нь хийхгүй болохоор түүнийг авснаараа Зөвшөөрлийн хууль дээр нөгөө зөвшөөрөл заагдаагүй л бол зөвшөөрөгдөнө гэдэг концепц нь үйлчлээд явчих юм бол яг тухайлан тэр төлбөрт таавар, бооцоот тоглоом нь энэ хуулийн цоорхойгоос гараад ингээд алга болчих ийм эрсдэлтэй байсан.

Тийм учраас ер нь Монгол Улс зөвшөөрөхгүй шүү гэдгийг хуульд нь бичээд ингээд явах нь зохимжтой юм уу гэдэг байдлаар л асуудалд хандсан. Тэгээд Их Хурлын ажлын хэсэг дээр бас ярилцаж болох байх гэж бодож байна.

Б.Пүрэвдорж: Наранцэцэгийн Алтаншагай гишүүн асуулт асууя.

Н.Алтаншагай: Баярлалаа. Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Энэ хууль батлагдсанаараа, шинэчлэгдсэнээрээ бас энэ цахим мөрийтэй тоглоом, бооцоот тоглоом, түүнээс үүсэх нийгэм, эдийн засгийн сөрөг нөлөөллийг бууруулахад ач холбогдолтой гэж үзэж байгаа.

Хэдэн асуулт байна. Энэ бол энэ цахим бооцоот, мөрийтэй тоглоом энэ технологид суурилсан нийгэмд шинээр үүсэж байгаа л тулгамдсан асуудлуудын нэг. Энийг хориглож болно. Эргээд яаж энэ сөрөг нөлөөллийг багасгах вэ, Яаж урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлуудыг хийх вэ? Ви Пи Эн болон энэ цахим карт ашиглаад энэ далд хэлбэр рүү шилжих бас боломж бүрдэх ийм аюултай. Энэ дээр ямар нэгэн яг тооцоо, судалгаа байна уу? Яг энийг хорьсноороо. Олон гишүүд асууж байна. Энэ цахим тоглоом, цахим казино зэргийг энэ нөгөө бооцоот спортын бооцооноос ялгах уу гээд. Энэ нөгөө үндэсний спортууд дээр нөгөө бооцоот зөвшөөрье гээд бас Сайнзориг гишүүн бид хоёр хуулийн төсөл бас боловсруулж өргөн барьсан. Энэнээсээ яг яаж оруулах вэ?

Учрал сайдын хэлж байгаагаар ажлын хэсэг дээр нээлттэй үлдээсэн гэж ойлгогдохоор байна.

Мөн дээр нь энэ телевиз болон энэ сая сайт, лайв/live/-уудаар сугалаанууд маш ихээр зохион байгуулагддаг болсон. Энэ яг юутай холбоотойгоор сугалаагаар дагнасан телевизийн хөтөлбөрүүд ч байна. Энэ дээр яг ямар арга хэмжээ авах вэ? Баатархүү сайдаас бас энийг тодруулъя. Энэ бол нөгөө амар арга, хялбараар мөнгө олох гэсэн энэ төрөл рүүгээ бас орж байгаа.

Сандаг Очир гишүүний хэлдэгтэй бас санал нэг байгаа. Бие даасан хуультай болохгүй аль дээр үеийн хууль дээр энийг аваачиж наагаад тал талаас нь ингээд яваад байх бас учир дутагдалтай байж магадгүй. Тэгэхээр энэ дээр яг бие даасан хуультай болох тал дээр Засгийн газар томоохон бодит шийдвэрийг гаргаач гэж хүсэж байгаа юм. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Баатархүү сайд хариулъя.

Ц.Баатархүү: Гишүүн маш зөв асуудлыг хөндөж байна. Ер нь энэ донтсон цахим мөрийтэй тоглоом гэдэг маань өөрөө сэтгэл зүйн хувьд донтуулаад байгаа учраас энэнээс сэргийлэх ийм ЕБС-ийн хичээлийн хөтөлбөрүүдийг л хэрэгжүүлж байна.

Хоёрдугаарт нь нь ч тоглоод байгаа хүмүүс гэр бүл нь нээлттэй манай гэр бүлийн хүн тоглоод байна, миний ойр орчмын хүн тоглоод байна гэдгийг эрүүл мэндийн байгууллага болон донтолтыг эмчилдэг газруудад мэдэгдэх нь нээлттэй болгож энэ эмчилгээний аргуудыг хэрэглэж байна. Энийг би маш зөв, зүйтэй санал дэлхий даяарыг энэ донтолтыг эмчлэх чиглэл рүү явж байна.

Ер нь түрүүн хэлсэн бүрэн хоригловол ямар сөрөг нөлөө байна вэ гэхээр 40 хувь нь хууль бус хувилбар хайдаг ийм сэтгэл зүйтэй байна гэдгийг дэлхий даяар явуулсан судалгаагаар гарч байгаа. Энэний цаана 2, 3 гол зүйл байгаад байгаа. Цахим мөрийтэй тоглоом, спортын бооцоот тоглоом хоёрыг яагаад ялгахгүй байна вэ гэхээр цахим платформ нь Спорт бэт/bet/ гэдэг нэртэй зөвшөөрөл авангуутаа цонхнууд дээрээ бүүр казино, нэмээд цахим мөрийтэй тоглоом гэдэг цонх, эсвэл тийм линк заагаад өгчхөж байгаа юм. Тэгэхээр одоогийн хуулиар спортын тааврыг, төлбөрт энэ спортын бооцоот тоглоомыг зөвшөөрлөө гэж үзэхэд энэ цахим залилан, цахим мөрийтэй тоглоом, далд эдийн засгийн урсгал яг технологийн хувьд ингээд арилгахад замбараагүй байдал яг хэвээрээ байх гээд байгаа юм. Тийм учраас бүхлээр нь хорьчихоод үүний дараа маш сайн судалж байгаад олон улсын жишгүүдийг харж байгаад яах вэ гэдгээ Улсын Их Хурал шийдсэн нь зөв байх гэж бодож байна.

Энэ сугалааны асуудлаар Өргөн нэвтрүүлгийн хуулиар 16 телевиз өргөн нэвтрүүлгийнхээ хуулийн дагуу тодорхой санхүүжилтийг авдаг. Ийм учраас иргэдээс ирсэн гомдлын дагуу ямар нэгэн сугалаа, бооцоот тоглоом гэсэн хэрэглэгчдийн эрх ашгийг зөрчсөн ийм үйл ажиллагаа явуулахыг хориглосон байдаг. Гэсэн хэдий боловч бас телевизүүд энэ өөрийнхөө хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхгүй явуулсан хэвээрээ байдаг. Одоогийн хуулийн зохицуулалт бол иргэд, хэрэглэгчдийн, татвар төлөгчдийн мөнгөөр санхүүждэг олон нийтийн

телевиз, өргөн нэвтрүүлгийн телевизүүд энэ сугалаа явуулах нь хориотой байдаг юм гэдгийг танд хэлье. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Алтаншагай гишүүн тодруулъя.

Н.Алтаншагай: Цахим гэмт хэрэгтэй тэмцэхээс байх шиг байна энд хүмүүс. Шийдвэр гарсны дараа энийг ер нь яг хяналтдаа авч чадах уу? Технологийн хувьд бид бүхэн яг энэ дээр ямар боломж, нөөцтэй байгаа вэ, технологийн хувьд, техникийн хувьд боломжтой юу гэдгийг бас тодруулж асууж байгаа юм. Боллоо.

Б.Пүрэвдорж: Учрал сайд хариулъя. Хариулт байна шүү дээ.

Н.Учрал: Ингээд Зөвшөөрлийн хуулиар бүхэлд нь ингээд хориглочихоор хуулийн байгууллага ч тэр, энэ Харилцаа холбооны зохицуулах хороо, мэдээллийн технологийн салбарынхан гээд ер нь хамтдаа ажиллах бололцоо бүрдэнэ л дээ. Одоо бол хуулиар нээлттэй зөвшөөрөл аваад явж байгаа үйл ажиллагаа учраас маш их цаг алддаг. Хариу арга хэмжээ авъя гэхээр аль байгууллагын эрх, үүргээ хэрэгжүүлэхэд бол бас хүндрэлтэй байдаг. Тийм учраас яах вэ 60 хувь багасна гэдэг ийм үндэслэл хэлээд байгаа юм.

Б.Пүрэвдорж: Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн асуулт асууя.

Ц.Мөнхбат: Манай гишүүд бол ерөнхийдөө асууж байна. Эерэг, сөрөг талуудыг нь аль алийг нь ярьж байна. Тэгээд бид нар энэ нийгэмд бас тийм дэлгэрэнгүй мэдээлэл, ойлголт өгөх зорилготойгоор энэ зарим юмыг дахиад асууя гэж ингээд бодоод байгаа юм. Одоо энэ Зөвшөөрлийн хуулийг энэ зүйл, заалтаар бүгдийг нь хорино гэж байна. Энэ бүгдийг гэдэг дотор яг юу юу орж байгаа вэ? Энэ бооцоот тоглоомууд, төлбөрт тааврууд нь, зөвхөн онлайнууд нь ороод байна уу, аль эсвэл бүгд ороод байна уу гэдгийг тодорхой нэмж хэлж өгөөч гэж.

Хоёрдугаарт нь хэрвээ ингээд бүгдийг нь хаачихвал буцаагаад нээхдээ яах юм? Тэрийг нь тусдаа бие даасан хууль боловсруулаад ингээд ийм процессууд явсаар байгаад дараа нь буцааж нээх юм уу гэдэг нэг ийм асуулт байна.

Мэдээж энэ бооцоот тоглоом энэ онлайн мөрийтэй тоглоомын сайтуудаар дамжаад асар их мөнгө 500 гаран сая доллар ингээд гарсан гээд ингэж байна. Энэнээс дутахгүй нэг асуудал бол энэ нөгөө крипто валют, койн гээд ийм асуудлууд байдаг. Энийг яаж зохицуулах юм? Энэ дээр жишээ нь Засгийн газраас бодож байгаа ийм юм байна уу, төлөвлөж байгаа зүйлүүд байна уу? Энэ бол яг үнэндээ ард иргэдийг энэ цахим бооцоот тоглоомоос дутахгүйгээр илүү их хохироож байгаа ийм асуудал байгаа юм. Тэгэхээр энэ дээр ямар байр суурьтай байна вэ гэдэг ийм асуулт байна.

Б.Пүрэвдорж: Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Өмнөх парламентад Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн хуулийг миний бие ахалж батлуулж байсан. Тэгээд ер нь дэлхийн энэ санхүүгийн салбар их өөрчлөгдөж байна л даа. Энийг хуулиар зохицуулах бололцоотой биш. Дэлхийн улс орнууд крипто валют, крипто үндэстэн болох эхнээсээ дэлхийн

улсууд бол биткойныг хүртэл төр нь худалдан авалт хийдэг ийм шинэ тогтолцоо руу шилжиж байна.

Ер нь манайх шиг ийм банкандаа барьцаалагдчихсан ийм эдийн засагтай цаашаа явах бололцоогүй боллоо л доо. Тэгэхээр хөрөнгийн зах зээлийн санхүүгийн салбарыг томоохон тулгуур болгож авч үзье гэвэл хүссэн ч, эс хүссэн ч бид нар энэ санхүүгийн салбарт энэ крипто валютыг би дэмжих ёстой гэдэг би байр суурьтай байдаг.

Яагаад гэвэл энэ өөрөө хуулиар хянах бололцоотой биш. Зөв явуулж чадвал энэ эдийн засгийг төрөлжүүлнэ гэвэл төрөлжүүлнэ. Дээрээс нь эрчим хүч гэж ярьж байгаа үед бол бид нар зайлшгүй л энэ крипто валют руу бол бас анхаарлаа хандуулах ёстой. Тэр ч утгаараа Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн хуулийг бид нар тухайн үед зөвхөн биржийг зохицуулж байсан. Биржүүдийг л зөвшөөрөлтэй болгож байснаас болуулж байсан мөртөө ер нь Монгол Улс хуулиараа энэ виртуал хөрөнгө гэдэг ойлголтыг бас зөвшөөрсөн орнуудын нэгд тооцогддог болчихсон юм билээ. Энэ хууль гарснаас хойш.

Энэ мөрийтэй тоглоом, бооцоотой тоглоом ч бай ер нь энэ цахим орчинд үүсээд байгаа асуудлууд дээр би энэ 500 сая доллар гадагшаа урсчихсан гээд байгаа чинь крипто валютаар хоорондоо шилжсэнийг бол хэн ч, хаана ч тэрийг бол статистикт бүртгэж авч чадахгүй шүү дээ. Хүн гар утаснаасаа гар утасны хооронд ямар крипто валютаар хоорондоо шилжүүлэг хийж байгааг аль банк, хэн нэгэн этгээд мэдэхгүй. Тэгээд энэ санхүүгийн салбарын том өөрчлөлт.

Гэтэл 500 сая чинь бол харин хэн нэгэн этгээд гарч ирээд дунд нь зуучлаад, дансаа хэрэглүүлээд, ингээд агент бүр ажиллуулаад, дундаасаа шимтгэл аваад албан ёсоор бүртгэгдээд байгаа үзүүлэлт байхгүй юу. Тэгэхээр бид энэ хуулийг гаргана гэдэг бол өөрөө энэ ядаж бүртгээд байгаа энэ асуудлуудтайгаа тэмцэх ёстой.

Тийм учраас ашиг олох зорилгоор үйл ажиллагаа эрхэлж байгаа үйлдэл дээр нь, ашиг олох зорилгоор тэр цахим мөрийтэй тоглоом, бооцоот тоглоомд зуучлаад байгаа үйлдэл дээр нь, цахим мөрийтэй тоглоом, бооцоот тоглоомд дансаа хэрэглүүлээд ашиглуулаад, цахим хаягаа ашиглуулаад, харилцаа холбооны сүлжээний дугаар ашиглуулаад байгаа дэмжлэг үзүүлж байгаа үйлдэл дээр нь ашиг олох зорилгоор зохион байгуулалтын хэв шинжтэй үйл ажиллагаа явуулж байгаа үйлдэл. Дээр нь дээрээс нь бооцоот тоглоом гэж нэртэй мөртөө дотор нь онлайн казино ажиллуулаад байгаа 1xBet шиг бүх төрлийн хэвлэлээр сур.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Үлдсэн асуулт асуух хүмүүс Даргын зөвлөлийн хуралд оролцож байгаа. Санал, үг нь байгаа тээ? Асууж дууссаны дараа юу? Тэгвэл Даргын зөвлөлийн хурал тарчихсан байх ёстой.

Тэгээд Одонгийн Цогтгэрэл гишүүн алга байна. Чинбатын Ундрэм гишүүн алга байна. Батбаярын Жаргалан гишүүн алга байна. Нямтайширын Номтойбаяр гишүүн алга байна. Жаргалан гишүүн асуулт асуух уу? Батбаярын Жаргалан гишүүний микрофоныг өгье.

Б.Жаргалан: Сайн байцгаана уу? Энэ зөвшөөрлийн тухай хуулиар цахим мөрийтэй тоглоомын асуудлыг бүрмөсөн хориглож байгаа. Би Байнгын хороон дээр бас байр сууриа илэрхийлсэн. Ер нь яагаад энэ цахим мөрийтэй тоглоом газар аваад байна, яагаад залуучууд энэ төрлийн эрсдэлд ороод байна гэдгийг бид нар цогцоор нь харах ёстой. Энэ бол эргээд нөгөө ажилгүйдэл, ядууралтай холбоотой асуудал юм. Тэгэхээр эдийн засгаа яаж тэлэх юм, ажлын байр яаж бий болгох юм гэдэг асуудал дээрээ бас давхар анхаарал хандуулахгүй бол зүгээр аль нэгэн зүйлийг хорьж цагдах, тэгээд баахан хүмүүсийг тийм эрүүгийн хэргийн холбогдогчоор татах энэ тэр асуудал чинь бас эцсийн шийдэл биш шүү гэдгийг бас давхар хэлэхийг хүсэж байна.

Тэгээд энэ Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж байгаатай холбогдуулаад Банкны тухай хуульд нэмэлт оруулахаар оруулаад ирчихсэн байж байгаа. Энэ бас ноцтой харагдаад байгаа юм. Яаж байна вэ гэхлээр Банкны тухай хуулийн 7.2-т банк түүний харилцагч болон гуравдагч этгээд нууц гэж үзсэн аливаа мэдээллийг доор дурдсанаас бусад тохиолдолд бусдад гаргаж өгөх, задруулахыг банкны хувьцаа эзэмшигч, ТУЗ-ийн дарга, гишүүн, гүйцэтгэх удирдлага, Хянан шалгах зөвлөл, ажилтанд хориглоно гээд ийм заалт орчихсон байгаа. Энэ заалт ерөөсөө нөгөө хүн, хувь иргэний нууц мэдээллийг хамгаалахтай холбоотой ийм заалт байгаа.

Тэгээд энд болохлоор юу оруулж ирж байна вэ гэхлээр энэ төлбөрт таавар, бооцоот тоглоом, цахим мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа эрхлэх, зуучлах, төлбөрт таавар, бооцоот тоглоом, мөрийтэй тоглоом сурталчлах, цахим хэрэгслийг ашигласан залилах гэмт хэрэгт хуульд заасны дагуу мөрдөн шалгах байгууллагаас шаардсан буюу зөвхөн ингээд мөрдөгчийн хүсэлтээр хүний нууц мэдээллийг бас задруулах ийм нөхцөл байдлыг үүсгэчихсэн заалтыг нэмж байгаа юм.

Тэгэхээр энэ яг энэ нөхцөлд шаардлагагүй гэж харж байна. Яагаад вэ гэхлээр энэ 7.2.3-д тэртээ тэргүй прокурор зөвшөөрсөн нөхцөлд шүүх, прокурорын байгууллага, удирдлага гаргасан эсвэл Авлигатай тэмцэх байгууллага, цагдаагийн байгууллагын шаардлагаар, прокурорын зөвшөөрлөөр энэ мэдээллийг гаргаж болно гэсэн заалт нь байж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ агуулгыг илүү өргөжүүлээд тэр мөрдөгчийн бас эрх, үүргийг нэмэгдүүлээд байх нь зохимжгүй юм гэж харж байгаа. Тэгэхээр хууль санаачлагчид энэ заалтаа буцаагаад татаад авчхаач ээ. Яагаад гэхлээр бид нар цаашид ер нь энэ эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааг илүү иргэндээ ээлтэй, хүн төвтэй, хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн байдлаар зохицуулахыг зорьж байгаа.

Нөгөө талаас ер нь энэ хувь хүний нууцтай холбоотой асуудлууд маш эмзэг хэвээр байгаа энэ цаг мөчид ийм цонх нээгээд байх шаардлагагүй гэж үзэж байгаа юм. Тэгэхээр энэ асуудлыг хойш нь татаад авчхаач л гэж энэ хууль санаачлагчид хэлэх гэсэн юм.

Д.Амарбаясгалан: Санал хэллээ. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуулт асууя.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр цахим гэмт хэргийн энэ асуудлыг сайн мэдэхгүй хүмүүс үүний оролцогч болж маш их хохирч байгаа. Хөдөө суманд, баг дээр

малчин айлын эхнэр, нөхөр хоёр хоёр талдаа гарчихсан оролцоод л, тоглоод хамаг малаараа тэгээд л тэр хохироод л юу ч үгүй болоод л ингэж байгаа тохиолдлууд маш их байгаад байгаа юм. Тэгэхээр энэ дээр Учрал гишүүн, сайд хамгийн гол нь соён гэгээрүүлэх ажлуудыг их сайн хий. Тэр яг хийгдэж байгаа тэр ямарваа нэгэн бооцоот болон мөрийтэй тэр тоглоомын хор хохирлыг нь л сайн тайлбарлаж өгч баймаар санагдаад байгаа юм л даа.

Жишээ нь покер тоглож байгаа магадгүй сумын 2, 3 хүн орцонд тоглож байж магадгүй. Гэтэл яг нөгөө удирдаж байгаа нөхөр нь 4 ширхэг гар утас ингэж тавьж байгаад л өөрөө дангаараа ороод л тэгээд нөгөө тоглож байгаа нөгөө 2 хөдөөгийн хүнийг л бүгдийг нь хохирогч болгодог л ийм л юм байлаа шүү дээ. Тэгээд эхэндээ ганц, хоёр удаа өгдөг. Өгөнгүүт нь хорхойсдог, хорхойсонгуут нь хамаг мал, хөрөнгийг нь бүгдийг нь хуу хамдаг л ийм л зүйл байгаа. Тэр жишээ нь хөдөөгийн тэр малчин залуу ганцаараа тоглож, ганцаараа олон хүнтэй тоглож байгаа л гэж бодож байгаа. Тэр зохион байгуулалттай хэсэг бүлэг гэмт хэрэгтнүүдтэй л тоглож байгаа.

Өөрөөр хэлбэл, бүх оролцогч нар бүгдээрээ холбоотой ганцхан чиний мөнгийг л авах гэж байгаа шүү дээ. Тийм учраас манай энэ зүйлээр тоглож байгаа энэ ард иргэд бас энэ дээр болгоомжтой байгаарай. Мэдээж манай Монголчууд ер нь жоохон мөрийтэй тоглох их хорхойтой гэж ярьдаг. Хорхойсоод байгаа бол тэгээд 13-аа сайхан тоглоод л, тэгээд өөр хоорондоо 50 мянган төгрөгөөр тороод тэгээд тэр хорхойгоо дараад тэгээд ямар ч аюул байхгүй, эрсдэл байхгүй, хэл ам байхгүй ийм л юм болно шүү дээ.

Тийм учраас ер нь Учрал сайд энэ хамгийн гол нь хэт их хориглохоосоо илүүтэйгээр яг энэ энэ мөрийтэй тоглоом цахимаар явж байгаа энэ мөрийтэй тоглоом чинь ингэж ингэж хохироож байсан юм байна гэдэг юмыг яг энэ хууль батлах явцдаа олон нийтэд таниулж бас энэ хууль баталж энэ хориглосны үр дүнд энэ мэдээж энэ цахим мөрийтэй ийм далдлал орох байх л даа. Далд орох учраас, энэ далд хэлбэртэй болох учраас энийг л иргэдэд сайн таниулах тэр ажлуудыг л хийх ёстой л гэж би үзэж байна.

Д.Амарбаясгалан: Пүрэвдорж гишүүн үг хэллээ. Бат-Эрдэнэ гишүүн алга байна. Батбаатар гишүүн алга байна. Золжаргал гишүүн алга байна.

Ингээд Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Санал хураалт болох гэж байгаа учраас гишүүдэд мэдээлэл хүргэе.

Хуулийн төслүүдийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж болон бүлэгт харьяалагддаггүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлнэ.

3 гишүүний нэр ирсэн байна. Ганхуяг, Сэддорж, Зулпхар. Зулпхар гишүүн үг хэлье. 1 дүгээр индэр.

С.Зулпхар: Их Хурлын дарга, эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтган мэндчилье.

Бидний хувьд бас их чухал хуулийн төслийг хэлэлцэж байна. Энэ нийгмийн харилцаанд шинээр бий болж байгаа нөхцөл байдалтай уялдан шаардлагатай үед бид тэр харилцааг зохицуулах, бэлтгэлийг хангах ёстой. Шаардлагатай үед бол тэрэнтэй уялдсан эрх зүйн орчныг бүрдүүлэх ёстой тэр эрх зүйн орчныг бүрдүүлэх үүрэг нь Улсын Их Хурлын өөрт нь байгаа юм. Бид виртуал ертөнц буюу зохиомлоор, хиймлээр бий болгосон бодит ийм ертөнцөд, бодит орчинд олон төрлийн харилцаанд ордог болсон. Тэр нь эдийн засгийн харилцаа, нийгмийн харилцаа, цаашлаад санхүүгийн харилцаа ч гэдэг юм уу. Гэхдээ энэ харилцааг хэрвээ зохицуулахгүй орхичих юм бол энэтэй уялдсан заримдаа үр дагаврууд гарч байгаа. Энэ үр дагаврыг бол өнгөрсөн хугацаанд тодорхой хуулиуд дээр өөрчлөлт оруулах байдлаар хийж байсан гэдгийг бас энд тэмдэглэж байгаа юм.

Хүүхэд хамгаалалтай холбоотой хуулийг өнгөрсөн жилийн 2024 оны 1 сарын 17-нд Улсын Их Хурлаас баталж байсан. Тэр үед цахим орчин дахь хүүхэд хамгааллын асуудал яригдаж байсан. Одоо цаашдаа бараг хууль болгонд цахим орчин дахь тодорхой харилцаануудыг зохицуулах ийм шаардлага гарах нь гэж үзэж байгаа учраас өнөөдөр бидний энэ хэлэлцэж байгаа Зөвшөөрлийн тухай хуультай уялдан цахим мөрийтэй тоглоомын асуудлыг цаашдаа бид зохицуулах шаардлага үүссэн юм байна гэдгийг та бүхний хэлэлцүүлэх явцад гарсан саналуудаас ойлголоо. Сэтгэл сэртхийлгэн бас гарцаа байхгүй анхаарал хандуулах ийм тоонууд байна. 500 саяд доллартой тэнцэх ийм мөнгөн хөрөнгө бол гадагшаа гараад явчихсан гэдэг ийм тоо хэлж байна. ДНБ өнгөрсөн жил 23.4 тэрбум ам.доллар байсан бол манай ДНБ-ий 2 хувьтай тэнцэх хэмжээний ийм мөнгөн хөрөнгө гадагшилсан байна. Үүнийг валютынхаа нөөцөөр аваад үзвэл сая бас ажлын хэсгийн ахлагч Учрал сайд танилцуулж байна манай валютын нөөцийн 10 хувьтай тэнцэхүйц ийм жишээ нь, нөхцөл байдал үүссэн шүү гэдгийг хэлж байна. Эдийн засаг, санхүүгийн хувьд бол энийг бид ярьж байна. Нийгмийн үр дагавар нь бүүр энэнээс бас ноцтой байхаар байгаа юм.

Нийгмийн үр дагавар нь донтолт гэдэг томоохон ийм нөхцөл байдлыг, ийм өвчнийг бол газар авахад хүргэж байна. Цахим тоглоомд донтоно гэдэг бол сэтгэл зүйч сэтгэл зүйн чиглэлээр үйлчилгээ үзүүлж байгаа энэ мэргэжлийн улсуудын үйлчилгээ үзүүлдэг ажлынх нь бараг 80 хувь боллоо гэдэг ийм бас ноцтой статистик хэлж байна. Энэ үүднээс нь аваад үзвэл та бид энэ хуулийг бол зайлшгүй хэлэлцэх ёстой юм байна. Хэлэлцэхдээ мэдээжийн хэрэг тодорхой зүйлүүдийг өнөөдөр та бүхний ярьсан саналуудтай уялдуулсан байдлаар нарийвчилж бас ярилцах, зохицуулалтуудыг нь тал талаас бас хэлэлцэх ийм шаардлага байгаа юм байна. Виртуал ертөнцөд зарим зүйлийг бид өнөөдөр зохицуулж чадаж байна. Зарим зүйлийг зохицуулж чадахгүй байна. Энэ техникийн хязгаарлалтууд байгаа байх. Тэрнээс гадна манайд технологийн хязгаарлалтууд байгаа байх. Хуулийн хязгаарлалтууд байгаа. Ямар ч байсан эхний ээлжид бол бид хуулийн хязгаарлалтаар дамжуулсан технологийн хязгаарлалтуудыг, техник хязгаарлалтуудыг хийхэд чиглэсэн шийдвэрүүд гарах байх.

Цаашдаа мэдээж хэрэг бас энэтэй уялдсан байдлаар илүү боловсронгуй болгох бас зохицуулалтууд хийгдэж таарах нь гэж үзэж байгаа юм. Энэ ч үүднээс манай нийгмийн хувьд бол бас томоохон анхаарал татсан, амаргүй, эрсдэлтэй нөхцөл байдлыг шийдэхэд чиглэсэн энэ хуулийн төслийг бид хэлэлцэх нь зүйтэй гэсэн ийм саналтай байна. Ингээд та бүхнийг бас дэмжиж саналаа өгөөч гэдгийг уриалж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа.

Улсын Их Хурлын гишүүд үг хэлж дууслаа. Одоо санал хураалттай. 9 санал хураалт байгаа. Гишүүд танхимд цуглая. Энэ хооронд дараачийн асуудлыг хэлэлцэж байя.

16.34 цаг

Зээлийн зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төсөл байгаа.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Энхбаярын Батшугар танилцуулна. Индэрт урьж байна.

Э.Батшугар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт олон улсын санхүүгийн зах зээлтэй холбогдсон олон тулгуурт, хүртээмжтэй санхүүгийн системийг хөгжүүлэх, банк, санхүүгийн зах зээлийн эрсдэл даах, найдвартай байдал хангах нөхцөлийг бүрдүүлэх зорилтуудыг дэвшүүлсэн байдаг.

Банкны салбарын нийт активын өрийн хэмжээ 2025 оны 2 дугаар сарын байдлаар 67 их наяд төгрөг хүрч, 2011 онтой харьцуулахад 7 дахин өссөн байна. Банкны системд чанаргүй зээлийн түвшнийг харгалзан санхүүгийн тогтвортой байдлаа хадгалах зорилтоор эрх зүйн шинэчлэл зайлшгүй хийх шаардлагатай байна.

Өнөөдрийн байдлаар 13 банк, 400 гаруй ББСБ, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд зээлийн мэдээллийн санд иргэд, аж ахуйн нэгжүүдийн зээлийн мэдээллийг тогтмол нийлүүлж байгаа бөгөөд зээлийн мэдээллийн санд 1.6 сая иргэн, 17 мянган аж ахуйн нэгжийн нийт 4.7 сая зээлийн мэдээллийн өгөгдөл хадгалагдаж байна. Энэхүү их өгөгдлийг үр ашигтай ашиглах, зээлдэгч нь зээлжих чадварыг тоон мэдээлэлд үндэслэн үнэлэх боломжийг одоогийн үйлчилж буй хуулиар бүрэн зохицуулаагүй байна.

Санхүүгийн үйлчилгээний хамгийн таатай нөхцөлийг зөвхөн том аж ахуйн нэгж, барьцаа хөрөнгөтэй зээлдэгч хүртэхээс гадна санхүүгийн сахилга баттай иргэд, аж ахуйн нэгжүүд урамшуулдаг нөхцөлийг бий болгох боломжтой. Өөрөөр хэлбэл, санхүүг сахилга баттай иргэд, аж ахуйн нэгжүүдийн зээлжих чадварыг барьцаанд тулгуурлаж биш их өгөгдөл дэвшилтэт технологи ашиглан тогтоож, уян хатан нөхцөлдөө зээлдэгчийн оноонд суурилсан санхүүгийн үйлчилгээг нэвтрүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай.

Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн барьсан.

Хуулийн төслөөр зээлдэгч нь зээлжих чадварыг тогтооход нэгдсэн онооны аргачлал, журам батлахад шинэ зохицуулалт тусгаж, зээлийн мэдээллийг зээлийн лавлагаанд 6 жилээр тусгах зохицуулалтыг 6 хүртэл жилээр өөрчилсөн.

Олон улсын сайн жишгийг дотооддоо нэвтрүүлэх зорилгоор “Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан байна.

Энэхүү өөрчлөлтийг хэрэгжүүлснээр үр дүнд нь дараах санхүү эдийн засгийн таатай нөхцөлүүдийг бүрдүүлнэ.

Нэгт, Банк, санхүүгийн салбарын үйлчилгээний хүртээмж, салбарын өрсөлдөөнийг нэмэгдүүлнэ. Зээлийн хүү буурах суурь нөхцөл байдал үүснэ. Зээлжих зээлдэгчийн хар жагсаалт гэх санхүүгийн ялыг арилгана.

Зээлийн үүргийн гүйцэтгэлийг барьцаа хөрөнгөөр хангуулахаас гадна оноонд суурилсан уян хатан нөхцөлтэй санхүүгийн үйлчилгээг нэвтрүүлнэ.

Барьцаа хөрөнгийн шаардлага буурах нөхцөлийг бий болгоно.

Банк, санхүүгийн салбарын эрсдэл даах чадварыг нэмэгдүүлж, эдийн засгийн, санхүүгийн тогтвортой байдалд эерэг нөлөөлөл авчирна.

Өөрөөр хэлбэл, иргэд, аж ахуйн нэгжүүдээ банк, санхүүгийн салбараас хүртэх өгөөж нэмэгдсэнээр бодит эдийн засагтаа тэтгэх суурь нөхцөлийг бүрдүүлнэ гэж ойлгож болно.

Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг d.parliament.mn цахим маягт байршуулсан бөгөөд олон нийтээс тусгайлан санал ирээгүй байгаа.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Иргэн, аж ахуйн нэгжүүдээ банк, санхүүгийн байгууллага бусдаас авсан зээлийн мэдээллийн бааз, сүлжээг сайжруулах, зээлжих чадвар, зэрэглэл тогтоох нэгдсэн аргачлал бий болох, зээлдэгчийн мэдээллийг мэдээллийн санд тусгах хугацааг уян хатан тогтоох, Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон дагалдах Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Төслүүдийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Лувсанжамц уншиж танилцуулна. Индэрт урьж байна. Лувсанжамц гишүүний танилцуулгын дараа санал хураалт явуулна. Өмнөх асуудлын 9 санал хураалт байгаа.

Г.Лувсанжамц: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Их Хурлын гишүүн Э.Батшугараас 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Эдийн засгийн байнгын хороо 2025 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагчийн зүгээс зээлдэгчийн зээлийн лавлагаанд тусгах хугацааг уян хатан болгох, зээлдэгчийн зээлжих чадварт зэрэглэлийг тогтоох аргачлал ашиглах, эрх бүхий байгууллагаас зээлдэгчийн зээлжих чадварт зэрэглэлийг тогтоох онооны аргачлал батлах зохицуулалтыг бий болгох зорилгоор уг хуулийн төслийг боловсруулжээ.

Хуулийн төсөл батлагдсанаар зээлдэгчийн зээлжих зэрэглэлийг тогтоох оноо нь нэгдсэн аргачлалтай болох бөгөөд банк, санхүүгийн салбарын үйлчилгээ, бүтээгдэхүүнийг төрөлжүүлж, салбарын тогтвортой хөгжил, хүртээмжийг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ гэж үзсэн байна.

Хуулийн төслийг d.parliament.mn цахим сайтад байршуулж иргэд олон нийтийн саналыг авч байна.

Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг эрх бүхий байгууллагаас тодорхой цаг хугацаанд өршөөл үзүүлэх байдлаар Зээлийн мэдээллийн сан дахь муу зээлийн мэдээллийн түүхийг олон нийтэд харагдахгүй болгодог явдал нь муу зээлдэгчийн хэмжээ ихсэж, банкнуудын эрсдэлийн санг нэмэгдүүлдэг асуудлыг төсөлд тусгасан эсэх, Монголбанкны үйл ажиллагаа нь улс төрөөс хараат бусаар ажиллаж байгаа эсэх, онооны системд ямар зээлдэгчийн ямар мэдээллүүдийг тусгах талаар, Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал их өгөгдөл буюу л зээлдэгчийн мэдээлэл дээр суурилсан онооны системийг Зээлийн мэдээллийн санд нэвтрүүлэх нь зүйтэй бөгөөд Зээлийн мэдээллийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын тогтоолын төслийн 1 дэх заалтын 1, 2 дахь дэд заалтад төрийн захиргааны төв, төрийн захиргааны байгууллагын дэргэдэх сангаас болон Монгол Улсын Хөгжлийн банкнаас авсан зээлээ хугацаандаа төлөөгүй, түүнчлэн хэвийн зээлийн ангиллаас бусад ангилалд орсон иргэн, аж ахуйн нэгж түүний зээлийн мэдээллийг хамааруулахгүй байх гэсэн заалтад Боловсролын зээлийн сангийн өмнө хүлээсэн хүлээсэн үүргээ биелүүлээгүй иргэд хамаарах эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж зээлийн онооны системд шилжсэнээр зээлийн хүү хэдэн хувиар буурах талаар төсөл санаачлагчаас асууж, хариулт авлаа.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд Монголбанкнаас зээлдэгчийн зээлжих чадварт зэрэглэлийг тогтоох онооны аргачлал гэснийг зарчим гэж өөрчлөх, зээлдэгч иргэдийн хувийн мэдээлэлд тодорхой хэмжээний өөрчлөлт орох үед түүнийг хянах боломжийг олгоход анхаарах, зээлийн онооны системээр зээлдэгчийн зээлжих зэрэглэлийг ангилахдаа өгөгдлүүдээс нь хамаарч хэт ялгаатай үнэлэхгүй байх талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл зээлдэгчийн зээлжих чадварын зэрэглэлийг тухайн улсын үнэт цаасны зээлжих зэрэглэлтэй хольж орчуулж ярьж байгаа нь санхүүгийн зах зээлд оролцогчдын төөрөгдөлд оруулах буюу иргэн аж ахуйн нэгж, байгууллагын кредит скоринг/credit

scoring/, кредит рейтинг/credit rating/-ийг холих эрсдэлтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиар зээлдэгчийн сүүлийн 6 жилийн зээлийн мэдээллийг зээлийн лавлагаанд тусгаж байгаа нь зарим тохиолдолд сөрөг үр дагавар үүсгэж байгаа тул өндөр хүүтэй зээлтэй иргэдийн амьдралын нөхцөл байдлыг тооцож, хуулийн зохицуулалтыг уян хатан байлгах талаар саналаа илэрхийлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн “Хууль баталсантай холбогдуулан авах зарга зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Уг асуудалтай холбогдуулан намын бүлэгт болон бүлэгт харьяалагддаггүй гишүүдээс асуулт асуухаар урьдчилсан байдлаар нэр ирүүлсэн. Нийт 21 гишүүн нэр ирүүлсэн байгаа. Тэгээд үндсэндээ энэ асуудлыг 150 минутын хугацаанд Их Хурал хэлэлцэхээр байгаа. Тэгэхээр өнөөдрийн ажлын цаг дуусах дөхсөн учраас энэ асуудлыг үргэлжлүүлэн ирэх 7 хоногийн 4 дэх өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

16.43 цаг

Одоо өмнөх асуудал буюу Зөвшөөрлийн тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлттэй холбоотой хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдтэй холбоотойгоор санал хураалт явуулахаар байгаа. Нийт 9 санал хураалтыг явуулна.

Санал хураалт явуулах боломжтой ирц бүрдсэн байгаа тул санал хураалтыг эхлүүлье. Санал хураалт.

1.Байнгын хорооны саналаар Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

52 гишүүн буюу 47.7 хувиар санал дэмжигдсэнгүй.

Жигжидийн Батжаргал гишүүн горимын санал юм уу? Горимын санал.

Ж.Батжаргал: Саяын санал хураалтыг, саналын томьёоллыг дэмжиж санал өгсөн юм. Тэгсэн чинь техник уншсангүй ээ. Тийм учраас саяын санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулж өгөхийг хүсэж байна. Өнөөдрийн бүх санал хураалтад дэмжиж санал өгсөн уншигдахгүй байгаад байна. Энэ аппаратыг янзлахгүй бол болохгүй нь ээ.

Д.Амарбаясгалан: Гишүүд санал хураалтдаа анхааралтай оролцъё. Батжаргал гишүүний бас энэ төхөөрөмж дээр хурууны хээг нь бүрэн уншихгүй асуудал бас гараад байгаа. Ганцхан төхөөрөмж дээр ийм асуудал гарч байгаа. Тэгэхээр энэ төхөөрөмжийг сольж үзэх үү, хурууны хээг нь ахиж уншуулах уу? Техникийн албаныхан энэ дээр бас анхаараарай.

Батжаргал гишүүний гаргасан горимын саналаар санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт явуулъя. Санал хураалт.

Хэнийх ажиллахгүй байгаад байна? Яагаад ажиллахгүй байна танхимд байгаа гишүүдээс?

Горимын санал дэмжигдсэнгүй шүү дээ. Батжаргал гишүүний гаргасан горимын санал 51 гишүүн буюу 46.8 хувиар дэмжигдсэнгүй.

Гомбын Ганбаатар гишүүн горимын санал гаргая.

Г.Ганбаатар: Энэ нээрээ тоног төхөөрөмж ажиллахгүй байна. Сая бас санал өгсөн боловч эсрэгээр уншигдаж байгаа харагдана. Ямар учиртай юм мэдэхгүй. Тийм учраас дахин санал хураалт явуулж өгөхийг хүсье.

Д.Амарбаясгалан: Дахиж горимын санал гаргаж байна. Эхлээд ирц бүртгэлийн санал хураалт явуулаадахъя даа. Энэ танхимд байгаа гишүүд ирц бүртгэлийн санал хураалт.

60 гишүүн дэмжиж санал өгч байна. Тэгээд сая чинь санал үндсэндээ. Энэ чинь Ариунхур дарга яах билээ Гомбын Ганбаатар гишүүний горимын саналаар санал хураалгаж болох билүү? Ариунхур дарга тайлбар хийе.

Ч.Ариунхур: Чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлээр хуралдаан даргалагчийн эрх, үүргийг тодорхойлсон байгаа. Энэ дээр хуралдаан даргалагч горимын саналаар 1 удаа санал хураалт явуулна гэж заасан. Үүнийг тухайн гишүүний гаргасан 1 удаагийн горимын саналаар 1 удаа хураана гэдэг байдлаар чуулган хэрэглэж явж байгаа энэ заалт.

Д.Амарбаясгалан: Тэгэхээр 1 асуудал гэдэг нь тухайн санал хураалтын процессыг хэлж байгаа учраас түрүүчийн горимын санал дээр, дэмжигдээгүй дээр Ганбаатар гишүүн тоног төхөөрөмж ажиллаагүй учраас ахиж санал хураалгаж өгөөч гэдэг хүсэлт гаргасан.

Тэгэхээр одоо Ганбаатар гишүүний гаргасан горимын саналаар 1 санал хурааж үзье. Тэгээд уг асуудал дэмжигдэхгүй бол энэ цаашаа ахиж санал хураагаад явах боломжгүй гэж ойлгоорой. Энэ юу л даа одоо дэмжигдэхгүй бол

төсөл санаачлагчид буцаана. Тийм, хэлэлцэх эсэхийг дэмжихгүй гэсэн үг болчхож байгаа учраас.

Гомбын Ганбаатар гишүүний гаргасан горимын саналаар Батжаргал гишүүний гаргасан горимын санал дэмжигдээгүйг хүчингүй болгоё гэдэг санал гаргасан.

Ингээд санал хураалт явуулъя. Санал хураалт.

58 гишүүн буюу 53.2 хувиар Батжаргал гишүүний гаргасан горимын санал дэмжигдээгүй нь хүчингүй боллоо тийм ээ.

Одоо тэгэхээр Батжаргал гишүүний гаргасан горимын саналаар дахиж санал хураана гэсэн үг байхгүй юу. Зөв үү? Тэгэхээр нөгөө хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураагаад цөөнх болсон Батжаргал гишүүн дахиж санал хураалт гаргах горимын санал гаргасан.

Тэгэхээр Батжаргал гишүүний гаргасан горимын саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

61 гишүүн буюу 56 хувиар санал дэмжигдлээ.

Одоо үндсэн саналаараа санал хураалт явуулъя. Санал хураалт

1.Байнгын хорооны саналаар Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

62 гишүүн буюу 56.9 хувиар санал дэмжигдлээ.

Тэгээд энэ дээр бас дэмжиж санал өгөхгүй байгаа гишүүд бас байгаа. Тэгэхээр энэ төсөл санаачлан өргөн барьсан санаачлагч, мөн Байнгын хороо цаашлаад энэ ажлын хэсэг байгуулагдаад ажиллах байх. Энэ хууль хоорондын бас зөрчил байгаа гэдэг асуудлыг гишүүд хөндөж байгаа. Тэгэхээр энэ хэлэлцүүлгийнх нь шатад, мөн эцсийн шатад нь энэ хуулийн зөрчлийг арилгах бас дэгийн хуулийн боломж байгаа юм байна лээ. Тэгэхээр тэр дээр бас анхааралтай хандаж ажиллаарай гэдгийг гишүүдэд хэлье.

Батжаргал гишүүнийг дэмжсэнээр протоколд тэмдэглэе. Мөнхтулга гишүүн бас дэмжсэн байна. Дэмжсэнээр протокол тэмдэглэе.

Хамт өргөн мэдүүлсэн

2.Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

61 гишүүн буюу 56 хувиар санал дэмжигдлээ.

3.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

63 гишүүн буюу 57.8 хувиар санал дэмжигдлээ.

4.Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

61 гишүүн буюу 56 хувиар санал дэмжигдлээ.

5.Банкны тухай хууль, Пүрэвийн Батчимэг гишүүнийг дэмжсэнээр протокол тэмдэглэе.

5.Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

48 гишүүн буюу 44 хувиар санал дэмжигдсэнгүй.

6.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай 36 дугаар зүйл нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг хэлэлцүүлэг явуулах 36.14 санал хураалтад оролцсон гишүүдийн олонх хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүй бол “Хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах тухай” тогтоол батлагдсанд тооцно.

Буцаалаа.

6.Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

59 гишүүн буюу 54.1 хувиар санал дэмжигдлээ.

7.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

62 гишүүн буюу 56.9 хувиар санал дэмжигдлээ.

8.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

65 гишүүн буюу 59.6 хувиар санал дэмжигдлээ.

9.Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

63 гишүүн буюу 57.8 хувиар санал дэмжигдлээ.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг гишүүдийн олонх дэмжсэн тул төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороо болон Хууль зүйн байнгын хороо, Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.

Дараагийн асуудалд оръё. Төсөв, Эдийн засаг, Хууль зүй гурван руу. Тийм үү, тэгвэл 9 дэх асуудал руу оръё.

16.58 цаг

Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсоно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3-д Улсын Их Хурал энэ хуулийн 46.1.2-т заасан хууль, тогтоолын эцсийн найруулгатай танилцаж, ёсчлохыг зөвшөөрөх гэж заасны дагуу тогтоолын эцсийн найруулгыг Байнгын хороо бэлтгэж, Улсын Их Хуралд танилцуулахад бэлэн болсон байна.

1.Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 02 дугаар дүгнэлтийн тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүд байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул чуулганы нэгдсэн хуралдааныг өндөрлүүлье.

17.00 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Д.ОТГОНДЭЛГЭР

